

A6-20

УТААГҮЙ ТҮЛШ

ТОП – 100

ТӨМӨР ЗАМ УС ХАНГАМЖ

ТЭРБУМ ДОЛЛАРЫН ОРЛОГО ЦАХИЛГААН СТАНЦ

70 САЯ ТОНН НҮҮРС

НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА

ТАВАНТОЛГОЙ ТӨМӨР ЗАМ

НҮҮРС ТЭЭВЭР

ХАРИУЦЛАГАТАЙ УУЛ УУРХАЙ

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ

АЛСЫН ХАРАА - 2050

ISO – 14001

НҮҮРС ОЛБОРЛОЛТ

ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ

НҮҮРС ОЛБОРЛОЛТ

ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ

ГОВИЙН ШИЛҮҮС
ГАШУУНСУХАЙТ

1072 ХУВЬЦАА

ТАВАНТОЛГОЙ ЦАХИЛГААН СТАНЦ
ҮНДЭСНИЙ ИХ БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ

САНХҮҮГИЙН ҮНДЭС

МОД

COVID – 19

НҮҮРС БОРЛУУЛАЛТ

НҮҮРС БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭР

УУЛ УУРХАЙ

НОГДОЛ АШИГ

ХҮҮХДЭД ЭЭЛТЭЙ – ЭТТ

ТАВАНТОЛГОЙ ТҮЛШ

ISO – 45001

ISO-9001
ЦАГААНХАД



WWW.ETT.MN

*Эх орныхоо
Тусын Тулг*
ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ ЭТТ

ТАЙЛАН СЭТГҮҮЛ БЭЛТГЭСЭН:

Захиргааны хэлтэс

Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтэс

Эх орныхоо Тусын Тулд

ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ ЭТТ

Эрхэм зорилго

“Монгол Улсын эдийн засгийн тэргүүлэх салбарт уул уурхай, хүнд үйлдвэр, эрчим хүч, тээвэр, логистикийн чиглэлээр бизнесийн үндсэн үйл ажиллагаагаа явуулж, компанийн нэгдэл хэлбэрээр “Уул уурхай-Дэд бүтэц- Аж үйлдвэрлэл”-ийн хосолсон цогцолбор байгуулж, хөрөнгө оруулалтын үр ашигтай бодлогыг хэрэгжүүлж, ажиллагсдын болон түншүүдийн тогтвортой хөгжлийг хангаж, олон улсын стандартад нийцсэн, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүнийг дэлхийн брэндийн түвшинд үйлдвэрлэж, зах зээлд хүргэн борлуулснаар Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүний таваас дээш хувийг бүрдүүлж, хувьцаа эзэмшигчдэд хөрөнгийн үр өгөөжийг хүртээнэ.

Үнэт зүйлс

БАЙГАЛИЙН БАЯЛАГ

Тавантолгой нүүрсний бүлэг орд нь стратегийн ач холбогдол бүхий үнэ цэнтэй, хязгаарлагдмал байгалийн баялаг бөгөөд Монгол Улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн хурдасгуур нүүрс нь компанийн үнэт капитал мөн. Коксжих болон эрчим хүчний нүүрсээр олон улсын стандартад нийцсэн, нэмүү өртөг шингэсэн, дэлхийн брэндийн түвшинд, өндөр чанарын бүтээгдэхүүнийг БИД үйлдвэрлэнэ.

Гадаргын болон гүний усны нөөцийн орд, эх үүсвэр нь байгаль, экологийн тэнцвэртэй байдлыг хангадаг үнэ цэнтэй, ховор байгалийн баялаг бөгөөд уул уурхай-дэд бүтэц-аж үйлдвэрлэлийн цогцолборыг хөгжүүлэх хөгжлийн түлхүүр-“Ус чандмань эрдэнэ” мөн. Усны нөөцийг байгальд ээлтэй, хэмнэлттэй, үр ашигтай ашиглаж, зөв хэрэглээг хэвшүүлж, усны нөөцийн санг бүрдүүлж, дахин ашиглах, тэнцвэртэй байдлыг БИД ханган ажиллана.

ЧАДВАРЛАГ, МЭРГЭШСЭН, ЭВСЭГ ХАМТ ОЛОН

Ажилчдын ур чадвар, мэргэшил туршлага, ажлын үр дүнг харгалзсан хариуцлага, урамшууллын бодлого, хөдөлмөр эрхлэлтийн тэгш нөхцөл боломжоор хангаж, чадварлаг, мэргэшсэн боловсон хүчнээр хамт олныг бүрдүүлнэ.

Хүндэтгэл, итгэл, шударга, ил тод, хариуцлага, сахилга баттай байдлыг эрхэмлэсэн багаар ажиллах чадвартай, эвсэг хамт олон нь өндөр үр дүн, амжилтын нийлмэл хүч байна.

ХАРИЛЦАН ИТГЭЛЦЭЛ

Хамт олон, харилцагч, түнш, олон нийтийн болон тэдний хоорондын эрх ашгийг дээдлэн хүндэлнэ.

Аливаа хамтын ажиллагаа, нээлттэй харилцааг эрхэмлэж, шударга, ил тод, хариуцлагатай байх зарчмыг чанд баримтална. Бизнесийн түншүүдтэй харилцан ашигтайгаар хамтран ажиллахдаа тогтвортой, урт хугацааны, харилцан ашигтай байх, сайн түншийн харилцааг эрхэмлэнэ.



“Домгийн шилүүс” бэлгэдэл нь Хүннү гүрний үеийн олдвороос сэдэвлэн Говь нутгийн ховордсон амьтан болох Монгол шилүүсийг уул ус, тэнгэр газартай хослуулан эртний зургийн хэв маяг шингээн ЭТТ ХК-ийн эмблем, уул, газрыг тусган 10 жилийн ойд зориулан бүтээсэн бүтээл юм. Говийн шилүүсний өвөрмөц шинж болох богино сүүл, чихний үзүүрийн туг хар үс, нүүрний урт сахал, хүзүүний дор өрөвлөг, том тавхай зэрэг онцлогийг тусгаж өгснөөс гадна түүний анч, хурдан шаламгай хөдөлгөөнийг нь харуулж үүл ороосон хэлбэртэйгээр дүрсэлсэн.



“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Гүйцэтгэх захирал
Б.ГАНХУЯГ:

**2021-2025 ОНД “УУЛ УУРХАЙ-ДЭД БҮТЭЦ-
АЖ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ХӨГЖЛИЙН
ЖИШИГ-ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ” ГЭСЭН
ЧИГЛЭЛИЙГ БАРИМТАЛЖ АЖИЛЛАНА**

“ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ” ХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ, ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮН
Б.ГАНХУЯГТАЙ ЦАГ ҮЕИЙН АСУУДЛААР ЯРИЛЦЛАА.

**-Танд энэ өдрийн мэнд хүргэе!
“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн 2020 оны ажлын амжилтаас хуваалцахгүй юу? Улс орон даяар цар тахлын амаргүй нөхцөл байдалтай нүүр тулж буй энэ үед танай компани ачааны хүндийг үүрэлцэж байна.**

“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хамт олон 2020 оныг 1 их наяд төгрөгийн цэвэр ашигтай ажилласан амжилттайгаар угтсан. Үүний үр дүнд компанийн нийт хувьцаа эзэмшигч иргэддээ 179.8 тэрбум төгрөгийн ногдол ашиг хуваарилах ажлыг 2020 оны 9 дүгээр сарын 3-ны өдрөөс эхлүүлэн амжилттай зохион байгуулж чадлаа. Өнгөрсөн оны хувьд ч өнөөдөр ч “Эрдэнэс Тавантолгой” компани гэлтгүй төр, хувийн хэвшлийн бүхий л байгууллага, иргэдэд цар тахал нөлөөлж байна. Оны эхний зургаан сарын хугацаанд компанийн нөхцөл байдал нэлээд хүндэрсэн. Борлуулалтын орлого 71 хувиар тасарсан. Олборлолт 38 хувиар багассан.

Бизнес учраас борлуулалт, орлогын харьцааг хадгалж явах нь чухал. Энэ ч утгаараа 2020 онд хэрэгжүүлэхээр ТУЗ-өөс баталсан төлөвлөгөө, төсөвт тодотгол хийсэн. Бүхий л компанид ийм нөхцөл байдал тулгарсан биз. Харин өнгөрсөн 7-12 дүгээр сар хүртэл цонх үе гарч, орлогоо боломжийн хэмжээнд нэмэгдүүлж, бүрдүүлж чадсан.

Мөн цар тахлын үеийн эрсдэлийн төлөвлөгөөг хоёр үе шаттайгаар хэрэгжүүлсэнээр тасраад байсан орлогын 85 хувийг нөхсөн. Цар тахал дэлхий нийтээр уул, уурхайн компаниудыг ч сорьж байна. Тиймээс Австралийн томоохон уурхайнуудад авч хэрэгжүүлсэн цар тахлын үеийн төлөвлөгөөг компанийнхаа хөрсөнд зөв буулгаж хэрэгжүүлсэн юм. Энэ нь компани нөхцөл байдлыг боломжийн хэмжээнд даван туулахад нөлөөлж байна. Манай компани 2020 онд 161 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажиллалаа.

2020 онд нийгмийн хариуцлагын чиглэлээр олны талархал хүртсэн олон ажил хийсэн. Тухайлбал, Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах зорилгоор “Тавантолгой түлш” ХХК-ийн Зүүн бүсийн үйлдвэрийг

ашиглалтад орууллаа. Өнөөдрийн байдлаар 269,1 тэрбум төгрөгийн санхүүжилт олгоод байна. Ковид-19 цар тахлын үед иргэдэд санхүүгийн дэмжлэг үзүүлэхээр Засгийн газраас сайжруулсан шахмал түлшний үнийг 75 хувиар бууруулах шийдвэр гарч, түүнд шаардагдах төлбөрийг “Эрдэнэс Тавантолгой” ХК-иас төлсөн.

Мөн өнгөрсөн онд бүтээн байгуулалтын томоохон төслүүдийг санхүүжүүлсэн бөгөөд, Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын төслүүдэд нийтдээ 1.7 их наяд төгрөгийн хөрөнгө оруулалт хийгээд байна.

“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Төлөөлөн Удирдах зөвлөлийн 2021 оны 3 дугаар сарын 9-ний хуралдаанаас компанийг ойрын жилүүдэд хөгжүүлэх “А6-20” бизнес төлөвлөгөөг баталсан байна. Та энэ төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудын талаар мэдээлэл өгөхгүй юу?

-Компанийн 2017-2020 оны бизнес төлөвлөгөө хэрэгжиж дууссан. Үүнд 157 төрлийн бие даасан ажлыг төлөвлөснөөс 109 ажил нь үр дүнтэй хэрэгжлээ. Үүнд тулгуурлан “А6-20” гэсэн дунд хугацааны бизнес төлөвлөгөөг боловсруулж, Төлөөлөн удирдах зөвлөл, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар, Монгол Улсын Засгийн газрын түвшинд танилцуулж, батлуулаад байна. Монгол хүн бүр хувьцааг нь эзэмшдэг компанийн хувьд таван жилийн хөгжлийн бодит төлөвлөгөө гэдэг чухал. 2017-2020 онд “Дэлхийн жишиг уурхай Эрдэнэс Тавантолгой” гэж явсан бол 2021-2025 онд “Уул уурхай-Дэд бүтэц-Аж үйлдвэрлэлийн хөгжлийн жишиг-Эрдэнэс Тавантолгой” гэсэн чиглэлийг баримталж ажиллана.

Зөвхөн уул уурхай биш дэд бүтэц, үйлдвэрлэл, бүтээн байгуулалтын асуудалд анхаарна. Хагас болон бүтэн боловсруулах үйлдвэр, хот байгуулалт болон бусад жижиг дунд үйлдвэрлэлийн асуудал, зам дагасан хөгжлийн асуудлыг тусгасан. Өөрөөр хэлбэл, Үндэстэн дамнасан томоохон бизнесийн цогцолбор, мега төслийн хэмжээнд төлөвлөгөөгөө

боловсруулсан гэсэн үг. “Эрдэнэс Тавантолгой” бол Монгол Улсын эдийн засаг санхүүгийн үндэс мод. Төрийн тэргүүнээс эхлээд Засгийн газар, УИХ, аж ахуй нэгж байгууллагууд, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчид тэр ч байтугай айл өрх бүрд хамааралтай. Энэ үндэс модыг стратегийн хувьд зөв төлөвлөж явснаар Монгол улсын эдийн засгийн салбар бүрд үр өгөөжөө өгч, иргэн бүрд ашиг хүртээх боломжтой.

Төлөвлөгөөнд туссанаар 2025 оныг хүртэл “Эрдэнэс Тавантолгой” ХК Нүүрс баяжуулах үйлдвэр, Тавантолгой цахилгаан станц, төмөр зам, авто зам, усан хангамжийн зэрэг 20 том төсөл хэрэгжүүлэх юм. Ерөнхийдөө компани үсрэнгүй хөгжиж, жилд олборлох нүүрсний хэмжээ 45 сая тоннд хүрч, борлуулалтын орлого 10 их наяд, цэвэр ашиг 3,7 их наяд төгрөг болж, жилд 700 орчим тэрбум төгрөгийн ногдол ашиг иргэдэд хуваарилдаг болно. Тодруулбал, 2023-2025 онд 1072 хувьцаатай нэг иргэн 669 мянган төгрөгийн ногдол ашиг авах тооцоо гарсан.

Бид зөвхөн дотооддоо болон бүс нутгийн хэмжээнд биш Евро-Азийн, цаашлаад дэлхийн эдийн засгийн харилцаанд орох том зорилтыг тавиад ажиллаж байна. Өнгөрсөн хугацаанд компанийн хэмжээнд дөрвөн том ажил хийгдсэний эхнийх нь үнийн судалгаа, эрсдэлийн асуудал. Манай нүүрсний зах зээлийн 90-95 хувь БНХАУ-ын хамааралтай. Энэ дагуу БНХАУ-ын нүүрсний маш том платформыг нэвтрүүлсэн. Фэнвэй энерги компаниар 15 жилийн үнийн судалгааг хийсэн. Мөн аудитын “PWC”, “Эрнест Янг”, “BDO” компаниудаар санхүүгийн болон бизнес төсөөлөл, эдийн засгийн мөнгөн урсгалуудын тооцоолол хийлгэсэн. Энэ тайлангуудад үндэслэн эдийн засгийн төлөвлөгөөгөө баталгаажууллаа.

“А6-20” гэж нэрлэсэн учрыг тайлбарлахгүй юу?

-2017-2020 оны хугацаанд хэрэгжүүлсэн бизнес төлөвлөгөөнөөс онцлох зургаан том ажлыг хэрэгжүүлсэн. Нэгдүгээрт, бид Тавантолгойн нөөцийг нэгдсэн



байдлаар тодорхой болголоо. Өмнө нь зүүн, баруун болон “Энержи Ресурс”, орон нутгийн Тавантолгой гэж тусдаа байсан. Үүнийг нэгтгэж баталгаажуулсан. Мөн АНУ-ын “Стентак” компанитай хамтран Жорк стандартыг нэвтрүүлсэн. Канадын болон Монголынхоо стандартуудад шилжүүлж, компанийн үнэлгээг 4.1 тэрбум ам.доллар гэж тогтоосон. Үүгээрээ бид дэлхийд өрсөлдөх хүчин чадалтай компани гэдгээ зарлалаа. Хоёрдугаарт, ямар ч алдагдалгүй, өргүй болж, ашигтай ажиллаж эхэлсэн.

Энэ бол цагаан дээр хараар бичигдэх том амжилт. Мөн бүх төслүүдээ өөрөө санхүүжүүлж байна. Технологи, дэд бүтцийн томоохон ажлуудаа монголчууд өөрсдийн гараар хийгээд явж байна. Хоёр төмөр зам, угаах үйлдвэр, цахилгаан станц барьж байна. Түүнчлэн уурхай өөрөө хөгжихгүйгээр өрөөлийг хөгжүүлж, чирч явна гэж байхгүй. Би энэ төсөлд 2007 оноос хойш ажиллаж байгаа хүн. Тэр үед 10 гаруй гэр кемптэй байсан одоо ч бараг хэвээрээ байна. Мөн хамаг техникээ алдсан, хүний техник дээр ажиллаж ирсэн ийм л компани. Харин одоо олон улсын стандартад нийцсэн уул уурхайн оффис, хотхоны барилга баригдаад дуусч байна. Мөн компани өөрийн гэсэн олборлолтын техникуудыг худалдаж аваад эхэлчихлээ.

Хэдий хүнд хэцүү байсан ч 2020 онд уурхайн хөгжилд зоригтой хөрөнгө оруулалтуудыг татаж ажилласан. Мөн хувьцаа эзэмшигчдийн маань талаас дээш хувь нь Улаанбаатарт байна. Хувьцаа эзэмшигч 486 аж ахуй нэгжийн 90 хувь нь мөн энд төвлөрдөг. Тиймээс нийгмийн хариуцлагаа хэрэгжүүлж утааг бууруулах ажилд

гар бие оролцож байна.

Мөн ажилчдынхаа нийгмийн асуудал, цалин хөлсийг нэмэгдүүлэхэд онцгой анхаарч ажиллалаа. Би үнэ цэнтэй, сая сая ам.долларын уурхайчидтай компанийн захирал. 2018-2020 онд уурхайчдын цалинг 45 хувиар нэмсэн. Шөнийн нэмэгдлийг хоёр дахин нэмэгдүүллээ. ХАБ-ын нэмэгдэл 15 хувь, бүтээлийн нэмэгдэл, хүүхдээ төрүүлээд гэртээ байгаа ажилчдаа хүртэл сар болгон цалинжуулж байна. Цаашид энэ зургаан том алхам дээр суурилсан 20 ажил хэрэгжээд явна гэсэн утгаар “А6-20” гэж нэрлэсэн.

-Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөл 2021 оны 2-р сарын 19-ний өдөр хуралдаж, 2020 оны цэвэр ашгаас хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилахгүй гэсэн шийдвэр гаргасан. Танай батлуулсан төлөвлөгөөнд 2023-2025 онд 1072 хувьцаатай нэг иргэн 669 мянган төгрөгийн ногдол ашиг авах тооцоо гарчээ. Харин ойрын жилүүдэд ногдол ашиг өгөх боломжийн хувьд ямар байгаа вэ?

-2020 онд Ковид-19 цар тахлын улмаас “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн үйл ажиллагаа нэлээд хэмжээгээр тасалдсан талаар дээр дурдсан. Жилийн эцсийн дүнгээр компани 13,1 сая тонн нүүрс олборлож, 11,9 сая тонныг борлуулж, 1,6 их наяд төгрөгийн борлуулалтын орлоготой, 149.4 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна. Гэтэл 149.4 тэрбум төгрөгөөс ногдол ашиг хуваарилбал, 1072 хувьцаатай иргэнд 12 мянган төгрөгийн ашиг хуваарилагдах тооцоо гарч байна. Бид өнгөрсөн жил 96480 төгрөгийн ашиг хуваарилсныг та бүхэн мэднэ. 2020, 2021, 2022

онуудад компанийн үр ашиг, ногдол ашиг гэдэг зүйл яригдахгүй. Бизнес эрхлэгч, хувьцаа эзэмшигчид маань ч учрыг нь ойлгож байгаа байх.

Өнгөрсөн онд үнэхээр зүтгэж байгаад хувьцааны ногдол ашгаа тараалаа. Бизнесийн итгэлцлийн хувьд суурийг нь тавихаас өөр аргагүй байв. “1072 хувьцаа бол худлаа, зүгээр нэг сонгуулийн санал авах арга тактик” гэж яригддаг байсныг бид таслан зогсоосон. Хөрөнгөө шийдсэн байсан ч сонгуулийн саналд нөлөөлөх нөлөөллийг бодож сонгуулиас өмнө тараагаагүй. Ер нь улс төр, бизнес ангид байх ёстой гэдэг зарчмыг тухайн үеийн Засгийн газрын тэргүүн У.Хүрэлсүх баримталсан. Өмнө нь манай компанийн үйл ажиллагаа улс төрөөс 100 хувь хараат явж ирсэн. Харин 2017 оноос хойш өөр болсон нь “Эрдэнэс Тавантолгой” амжилттай ажиллах хөшүүрэг болсон.

-Компанийн үйл ажиллагаа шилэн тунгалаг болсон нь анхаарал татаж байна. Та юу гэж бодож байна вэ?

Тийм ээ. Манай компанийн сайт руу ороход бүх зүйл тодорхой байгаа. Бид компанийнхаа үр ашгийг нэмэгдүүлж, олон улсын бизнесийн харилцаанд орохын тулд итгэлцэл бүрдүүлж байна. Компанийн засаглалын нээлттэй ил тод байдлыг хангах, төр, аж ахуй нэгж, хувьцаа эзэмшигч иргэдийг мэдээллээр хангахтай холбогдуулан “Шилэн компани” хөтөлбөрийг хэрэгжүүлж компанийн үйл ажиллагаатай холбоотой 9500 орчим хуудас материалыг веб сайтад байршуулсан.

Өнгөрсөн хугацаанд олон улсын хөрөнгийн зах зээл дээр гарч чадаагүй ч компанийг хаалттай

байлгаж болохгүй. Хамгийн сайн нээлттэй компани байх нь бидэнд олон талын боломж олгоно. “Эрдэнэс Тавантолгой” гэхээр төрийн баг өмссөн болж харагдаад байдаг. Үүнээс ангижрах нь хөрөнгө оруулагчдад зориулсан алхам юм. Нөгөө талаар бид шилэн болсноор хувьцаа эзэмшигчдийнхээ бидэнд итгэх итгэлийг нэмэгдүүлнэ.

Хувьцаа эзэмшиж байгаа 2.5 сая иргэн, 486 аж ахуй нэгж байна. Төр 85.2 хувийг нь эзэмшиж байна. Энэ их итгэл үнэмшил дээр тулгуурлан үйл ажиллагаагаа улам өргөжүүлэхээр хичээж байна. Нийтдээ 2.3 тэрбум долларын санхүүжилт шаардлагатайгаас зөвхөн 2021 онд 600 сая, 2022 онд 400 сая долларын санхүүжилт шаардлагатай байна.

Нэг тэрбум ам.долларын хөрөнгө дутагдаж байгаа ч үүнийг олно. Олон улсын хөрөнгө оруулагч, харилцагч нартай хамтран ажиллана. Нийт шаардлагатай санхүүжилт 2.3 тэрбум. Нэг тэрбумыг бид өөрсдөө бүрдүүлнэ. Энэ мэтчилэн 2021-2022 онд санхүүгийн өндөр ачааллын үе байна. Үндсэн бүтээн байгуулалтын ажлууд дуусаж, өртөг зардал буурч, бүрэн хүчин чадлаар ашигтай ажиллаж эхлэх он бол 2023. Үүнээс цаашаа үйл ажиллагаа жигдрээд явна.

-Төмөр замын бүтээн байгуулалтын гол санхүүжүүлэгч нь танай компани. Төслийн үр өгөөж юу вэ?

-Энэ бол хамгийн зөв төсөл. Манай компанийн өртгийг бууруулж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлнэ. Гарцуудыг нэмнэ. “Тавантолгой-Гашуунсухайт”-ын чиглэл гэхэд өртгийг дөрөв дахин бууруулах юм. 32 ам.доллараар зөөдөг байсан бол 9 ам.доллар болно. Энэ хэмжээгээрээ ашиг орлого нэмэгдэнэ. Зүүнбаянгийн төмөр замын төсөл маань гурван гарц нэмнэ. Ханги Мандал, Бичигт, Төв магистрелиар явсаар ОХУ-д хүрнэ. Зам дагуух дэд бүтцүүд хөгжинө.

Одоо бол ганцхан гарцаар нүүрсээ гаргаж байна. Энэ хаагдлаа гэвэл манай нүүрсний экспортын 60 хувь нь байхгүй болно. Тэгэхээр төмөр замын бүтээн байгуулалт бол бизнес эдийн засгийн өндөр ач холбогдолтой төсөл. “Эрдэнэс Тавантолгой” компанид үүрүүлж байгаа ачаа биш.

-“Эрдэнэс Тавантолгой” ХК нь стратегийн ач холбогдол бүхий төмөр зам, нүүрс баяжуулах үйлдвэр, дулааны цахилгаан

станцын бүтээн байгуулалт зэрэг томоохон төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх зорилготой санхүүгийн зах зээлд хамгийн өндөр дүн бүхий 2 их наяд хүртэлх төгрөгийн болон ам.долларын бонд гаргахаар болж, эхний транчийн арилжаагаа дуусгасан. Ажлын явц ямар байна вэ?

-ЭТТ бонд нь Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй “Эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө”-ний нэг хэсэг юм. Засгийн Газар, Уул уурхай хүнд үйлдвэрийн яам, Монгол банк, Санхүүгийн зохицуулах хорооны зүгээс тус үнэт цаасыг олон нийтэд санал болгон хөрөнгө оруулалт татах энэ ажлыг дэмжиж байгаа бөгөөд анх удаа төрийн компани

оруулалтыг дотоодын зах зээлээс босгож чадлаа. Энэ нь манай компанид хөрөнгө оруулагчид, иргэд, аж ахуйн нэгжийн итгэх итгэл маш өндөр байгааг харуулсан маш гайхалтай үр дүн боллоо. Түүнчлэн ЭТТ бондын төгрөгийн хүү 10 хувь, ам.долларын хүү 6.8 байгаа нь банкны хадгаламжийн хүүнээс өндөр байгаатай холбоотой болов уу.

ЭТТ-Бонд Монголын уул уурхайн салбарт төдийгүй, хөрөнгийн зах зээлд том нөлөө үзүүлж, цаашид олон компаниудын хувьд түүчээ болно гэдэгт итгэлтэй байна.

Бид бондын санхүүжилтийг Тавантолгой дулааны цахилгаан станц, Нүүрс баяжуулах үйлдвэр, Усан хангамж, Төмөр зам зэрэг үндэсний томоохон бүтээн



иргэд, ААН, гадаадын хөрөнгө оруулагчдадаа нээлттэй зарлаж байгаа бонд юм. Мөн дотоодын хөрөнгийн бирж дээр анх удаагаа гадаад валютаар буюу ам.доллараар гарч байгаа учраас ханшийн уналтаас хамгаалагдсанаараа давуу талтай. Бид 2021 онд нийт 2 их наяд төгрөгийн бонд гаргана гэж төлөвлөснөөс эхний ээлжинд 600 орчим тэрбум төгрөгийн бонд худалдаалахаар гуравдугаар сарын 5-ны өдөр холбогдох бичиг баримтыг Санхүүгийн Зохицуулах хороо, Монголын хөрөнгийн биржид хүлээлгэн өгөөд, эхний арилжааг 2021 оны 3 дугаар сарын 30-ны өдөр эхлүүлсэн. Эхний арилжаагаар бид 677 тэрбум төгрөгийн хөрөнгө

байгуулалтад зарцуулна. Дээрх бүтээн байгуулалтууд хийгдсэнээр компанийн үр ашиг илүү нэмэгдэж, 2025 он хүртэл нийт 11.5 их наяд төгрөгийн цэвэр ашигтай ажиллахаар төлөвлөж байна.

Иргэд, аж ахуйн нэгжүүд энэхүү бондын санхүүжилтэд хөрөнгө оруулснаар Монголын хөрөнгийн зах зээлд томоохон эерэг нөлөө үзүүлж, өөрийн хөрөнгийг тогтмол үр өгөөжтэй өсгөхийн зэрэгцээ эх орны тусын тулд томоохон бүтээн байгуулалтын ажлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг бүрдүүлэхэд хувь нэмрээ оруулж байгаа гэдгийг онцолж байна.

-Ярилцсан танд баярлалаа.

SEEKING TO UNSEAT AUSTRALIA, MONGOLIA'S GIANT COAL MINE PLANS \$700 MLN BOND

WWW.REUTERS.COM



- * Tavan Tolgoi raising money for rail link, power plant - CEO
- * First domestic bond tranche raised around \$200 million
- * Foreign investors welcome to invest in second tranche in Q3
- * Project planning \$3.4 billion in investment over 2021-2025

"Underwriters warned us that there is a risk of not reaching our goal with falling coal demand and (an) uncertain world financial market," Gankhuyag said.

The first tranche of bonds was offered for sale in late March, with an interest rate of 10% for local currency and 6.8% for U.S. dollars. It raised around \$200 million.

The bonds are due to mature in two years. The underwriters were BDSec JSC and the Mongolian International Capital Corporation, two local investment banks.

Tavan Tolgoi will require \$3.4 billion in investment over the 2021-2025 period, and 70% of that could be funded from the company's own cashflow, Gankhuyag said.

The company is also constructing water pipelines, a coal washing facility and a

450-megawatt power plant that will supply electricity to Rio Tinto's giant Oyu Tolgoi copper project.

It has become increasingly difficult to finance coal projects as banks come under pressure to divest from fossil fuels, a major source of climate-warming greenhouse gas.

Gankhuyag said Tavan Tolgoi saw the shift towards clean energy "not as a difficulty but as an opportunity". The company will focus more on selling gas and electricity in future, he added.

The second tranche of bonds is due to go up for sale in the third quarter, and Gankhuyag said international investors were welcome.

"We are working hard to make our bond available both on local and international stock exchanges," he said.

ULAANBAATAR, April 21 (Reuters) - Mongolia's giant Tavan Tolgoi coal mine is aiming to raise 2 trillion tugriks (\$700 million) through a bond issue as it tries to build infrastructure needed to replace Australia as one of China's top coal suppliers, the head of the project said.

Gankhuyag Battulga, chief executive of the state-owned Erdenes Tavan Tolgoi JSC, said Mongolia needs to invest in railways to take advantage of simmering tensions between Beijing and Canberra, which have reduced coal shipments to zero since December.

"The Chinese government introduced a strict limit on Australian coal and this provides Mongolian coal exporters a unique opportunity to boost market share," he told Reuters, adding that market conditions should shift in favour of Mongolia.

Tavan Tolgoi, located around 240 kilometres from the Chinese border, is one of the world's largest coal deposits, but its development has been stymied by limited delivery capacity and longstanding financing troubles.

Part of the project was put up for tender in 2011 but the winning bid was annulled after Japan and South Korea complained the process was unfair. Mongolia has also tried to list Tavan Tolgoi on global stock exchanges.





НЭГ. КОМПАНИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

*Эх орныхоо
Тусын Тулд*
ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ ЭТТ

“Эрдэнэс Тавантолгой” ХК нь нүүрсний олборлолт, ашиглалтын үйл ажиллагаа явуулах чиглэлээр байгуулагдан олон улсын стандартад нийцсэн, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж, гадаад зах зээлд борлуулснаар улсынхаа дотоодын нийт бүтээгдэхүүний 5-8 хувийг бүрдүүлдэг, хувьцаа эзэмшигч ард иргэддээ үр өгөөжөө хүртээсэн Монгол Улсын төрийн өмчит томоохон аж ахуйн нэгж болж чадсан юм. Манай компани MV-016883, MV-0168818, MV-016882, MV-011943, MV-011953, MV-011954, MV-011955, MV-011956 дугаар бүхий 8 тусгай зөвшөөрөл

эзэмшин үйл ажиллагаагаа явуулж байгаа бөгөөд 2020 онд компанийн 10 жилийн ой тохиолоо.

“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хамт олон 10 жилийн хугацаанд **71.4 сая** тонн нүүрс олборлож, **71.0 сая** тонн нүүрс экспортолж, **9.0 их наяд** төгрөгийн борлуулалтын орлого бүрдүүлж, **2.2 их наяд** төгрөгийн татвар хураамжийг улсын төсөвт хуримтлуулж, **20,000** ажлын байрыг шууд болон шууд бус байдлаар бий болгосон бахдам амжилттайгаар уг ойгоо тэмдэглэн өнгөрүүлээ.

КОМПАНИЙН ОНЦЛОХ АМЖИЛТУУД



Монгол Улсын Засгийн газар, Монголын Үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимаас хамтран шалгаруулдаг ТОП-100 аж ахуйн нэгжийн жагсаалтад 2019 оны ажлын үзүүлэлтээр 2 дугаар байрт шалгарлаа. Тухайлбал ашгийн хэмжээгээр 1 дүгээр, хөрөнгийн хэмжээгээр 1 дүгээр, борлуулалтын орлогоор 2 дугаар, татвар төлөлтийн хэмжээгээр 2 дугаар байрыг тус тус эзэлсэн байна.



2019 оны үйл ажиллагааны цэвэр ашгаас компанийн нэгж хувьцаанд 90 төгрөг байхаар тооцон **2,512,768** хувьцаа эзэмшигч иргэдэд нийтдээ **179.8 тэрбум** төгрөгийн ногдол ашиг олгосноор Монгол Улсдаа анхдагч болж чадлаа.



“Эрдэнэс Тавантолгой” хувьцаат компанийн зүгээс Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зарим томоохон төсөл, хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлэн санхүүжүүлж байна. Тухайлбал Тавантолгой – Гашуунсухайт чиглэлийн төмөр замын төсөлд **1041.8 тэрбум** төгрөг, Тавантолгой – Зүүнбаян чиглэлийн төмөр замын төсөлд **883 тэрбум** төгрөгийн санхүүжилт хийсэн байна. Мөн Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах зорилгоор “Тавантолгой түлш” ХХК-д нийтдээ **269.1 тэрбум** төгрөгийн хөрөнгө оруулалт хийжээ.



Тавантолгойн ордын гадаргын ерөнхий төлөвлөгөөг боловсруулан, баталгаажуулан Засгийн газрын 2020 оны 09 дүгээр сарын 23-ны өдрийн хуралдаанд танилцуулсны гадна Бортээгийн уурхайн техник-эдийн засгийн үндэслэл, Цанхийн баруун уурхайн шинэчилсэн техник-эдийн засгийн үндэслэлийг Эрдэс баялгын мэргэжлийн зөвлөлийн хуралдаанаар тус тус батлууллаа.



Дэлхий даяар тархаад буй COVID-19 цар тахлын улмаас компанийн борлуулалт буурч, хүндрэлтэй нөхцөл байдал үүссэн хэдий ч энэ байдлыг амжилттай даван туулж 2020 оны борлуулалтын төлөвлөгөөг **111 хувиар** биелүүлж, нийт **1 их наяд 677.1 тэрбум** төгрөгийн (“ЭТТ” ХК-1 их наяд **547.7 тэрбум** төгрөг, “ЭТТ Майнинг” ХХК-**129.9 тэрбум** төгрөг) борлуулалтын орлоготой, **149.4 тэрбум** төгрөгийн (“ЭТТ” ХК нь **149.0 тэрбум** төгрөг, “ЭТТ Майнинг” ХХК нь **0.4 тэрбум** төгрөг) цэвэр ашигтай ажиллаж, улсын төсөвт **490.1 тэрбум** төгрөгийн татвар (“ЭТТ” ХК-**459.5 тэрбум** төгрөг, “ЭТТ Майнинг” ХХК-**30.6 тэрбум** төгрөг), хураамжийг төвлөрүүлжээ.



Компанийн засаглалын нээлттэй ил тод байдлыг хангах, төр, аж ахуй нэгж, хувьцаа эзэмшигч иргэдийг мэдээллээр хангахтай холбогдуулан “Шилэн компани” хөтөлбөрийг хэрэгжүүлж компанийн үйл ажиллагаатай холбоотой **9500** орчим хуудас материалыг веб сайтад байршуулж, “Нүүрс тээврийн цахим цонх”-ыг ажиллуулсан нь ач холбогдолтой боллоо.



КОМПАНИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Манай компани дотоод, гадаадын компанийн засаглалын кодекс, туршлагаас суралцан “Сайн засаглал”-ыг нэвтрүүлэх, манлайлах зорилт тавин ажиллаж байгаа бөгөөд 2020 онд Гүйцэтгэх захирал, Тэргүүн дэд захирал, 5

дэд захирал, 22 хэлтэс, 8 алба, 1 нэгж мөн 1 салбартайгаар нийтдээ 911 ажилтан, албан хаагчтай үйл ажиллагаагаа явуулж байгаа бөгөөд 100 хувь Монгол Улсын иргэд ажилладгаараа онцлогтой.

“ХӨГЖЛИЙН СТРАТЕГИ – УРТ ХУГАЦААНЫ БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ”



“Эрдэнэс Тавантолгой” ХК нь өнгөрсөн хугацаанд компанийн дунд хугацааны бодлогын баримт бичиг болох бизнес төлөвлөгөөг 4 жилийн давтамжтайгаар батлуулж, мөрдөн ажиллаж ирсэн боловч компанийн хөгжлийн нэгдсэн стратеги буюу урт хугацааны бодлогын баримт бичиггүй явж ирсэнд дүгнэлт хийж, ирээдүйн хөгжлийн зорилтоо тодорхойлох ажлыг хийлээ.

“Алсынхараа - 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл зэрэг бодлогын баримт бичиг, геологи хайгуул, уулын ажил, бизнесийн орчны судалгаа, төсөл хөтөлбөрүүдийн ТЭЗҮ зэрэгт тулгуурлан 2021-2025 онд хэрэгжүүлэх “A6-20” дунд хугацааны бизнес төлөвлөгөөг боловсруулан Төлөөлөн удирдах зөвлөл, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд танилцуулан батлууллаа. Мөн “Компанийн урт хугацаанд хэрэгжүүлэх бизнес төлөвлөгөө-2050” стратеги төлөвлөгөө боловсруулах ажлыг зохион байгуулж, холбогдох судалгаа, тооцооллын ажлыг эхлүүлээд байна.



ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ

“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2020 оны 04 дүгээр сарын 24-ний өдөр онлайн хэлбэрээр амжилттай зохион байгуулж, Компанийн 2019 оны үйл ажиллагааны тайланг хэлэлцүүлэн, Төлөөлөн удирдах зөвлөлийн тайланд өгсөн дүгнэлтийг батлууллаа. Түүнчлэн Компанийн 2019 оны цэвэр ашгаас нэгж хувьцаанд 90 (ер) төгрөгийн ногдол ашгийг хуваарилах тухай шийдвэр болон Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019

оны үйл ажиллагааны тайланг тус тус танилцуулсан.

Мөн компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг 2020 оны 10 дугаар сарын 19-ний өдөр корона вируст халдварын дэгдэлттэй холбогдуулан цахим хэлбэрээр зохион байгуулж, ТУЗ-ийн гишүүдийн бүрэн эрхийг дуусгавар болгох, шинээр сонгох асуудлуудыг хууль тогтоомжийн дагуу хэлэлцэн шийдвэрлэж, ногдол ашиг хуваарилалтын тайлан, явцыг танилцуулсан.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

Төлөөлөн удирдах зөвлөл нь хуульд заасны дагуу Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар, Хувьцаа эзэмшигчдийн төрийн төлөөллийг хэрэгжүүлэгч 7, хараат бус 4, нийт 11 гишүүнтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлыг 2020 онд нийтдээ 20 удаа зохион байгуулж 63 асуудлыг хэлэлцэн шийдвэрлэсэн байна. Дээрх хурлуудаар хэлэлцсэн асуудлаар нийт 50 тогтоол гаргаж, хуралдаан тус бүрээр хураангуй тэмдэглэл 20, дэлгэрэнгүй 20 тэмдэглэлийг хөтлөн албажуулсан байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудитын хороо 12 удаа, Нэр дэвшүүлэх хороо 2 удаа, Хөгжил төлөвлөлтийн хороо 1 удаа хуралдаж холбогдох асуудлуудыг хэлэлцжээ. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэд Дотоод аудитын албыг 2020 оны 07 дугаар сараас байгуулан ажилласнаар компанийн үйл ажиллагаа, төсвийн зарцуулалтад тогтмол хяналт шалгалт хийж Төлөөлөн удирдах зөвлөлийг мэдээлэл судалгаагаар хангах үйл ажиллагааг зохион байгуулж байна.



ХОЁР. КОМПАНИЙН ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА

*Эх орныхоо
Тусын Тулг*
ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ ЭТТ



2.1. НҮҮРС ОЛБОРЛОЛТ, ГЕОЛОГИ ХАЙГУУЛ

2020 онд Цанхийн баруун болон зүүн уурхайгаас нийт 26 сая тонн нүүрс олборлож, 135.7 сая м3 хөрс хуулж, 158.4 сая м3 уулын цулын ажил хийж гүйцэтгэхээр төлөвлөн АМГГ-р батлуулсан. Төлөвлөгөөний хэрэгжилтийг тогтмол хянаж, сар бүрийн уулын ажлын төлөвлөгөөг гэрээт гүйцэтгэгч тус бүрээр гарган батлуулж ажилласан.

Ковид-19 цар тахлын улмаас экспорт, борлуулалтын эрч буурч, хилийн татан авалт, үйл ажиллагааны тогтворгүй байдлаас болж нүүрс олборлолтын төлөвлөгөөг тодотгох шаардлагатай болсон бөгөөд 2020 оны 08-р сард Цанхийн баруун болон зүүн уурхайн “Ашиглалтын үйл ажиллагааны төлөвлөгөөг” тодотгож холбогдох хэлтэс, нэгжүүд, байгууллагууд болон АМГГ-т хүргүүлж, батлуулсан.

Уулын ажлын төлөвлөгөө, тодотгол

Материал	Баруун	Зүүн	Нийт
Хөрс м3	33,000,000.0	45,500,000.0	78,500,000
Нүүрс тонн	6,000,000.0	7,000,000.0	13,000,000.0
Уулын цул м3	37,285,714.17	50,500,000.00	87,785,714
Кхх м3/тонн	5.5	6.5	6.03

2020 онд нийт уурхай нь 13 сая тонн нүүрс олборлож 100%, 75.8 сая м3 хөрс хуулж 97%, хөрс хуулалтын Кхх 5.8, 85.1 сая м3 уулын цулын ажил гүйцэтгэх 97%-н гүйцэтгэлтэй ажилласан байна. Үүнээс Цанхийн баруун уурхай нь 4.2 сая тонн нүүрс олборлож 70%, 28.2 сая м3 хөрс хуулж 85%, хөрс хуулалтын Кхх 6.7, 31.2 сая м3 уулын цулын ажил гүйцэтгэх 84%-н гүйцэтгэлтэй ажиллажээ.


Цанхийн зүүн уурхай нь 8.8 сая тонн нүүрс олборлож 126%, 47.6 сая м3 хөрс хуулж 105%, хөрс хуулалтын Кхх 5.4, 53.9 сая м3 хөрс хуулж 107%-н гүйцэтгэлтэй ажилласан байна.

Уулын ажлын гүйцэтгэл

Материал	Баруун		Зүүн		Нийт		
	Төл	Гүй	Төл	Гүй	Төл	Гүй	Хувь
Хөрс сая м3	33.0	28.2	45.5	47.6	78.5	75.8	97%
Нүүрс сая тонн	6.0	4.2	7.0	8.8	13.0	13.0	100%
Уулын цул сая м3	37.2	31.2	50.5	53.9	87.7	85.1	97%
Кхх м3/тонн	5.5	6.7	6.5	5.4	6.03	5.8	-

2019 онд Монгол улсын нийт олборлосон нүүрсний хэмжээ 57.1 сая тонн байсан бөгөөд “Эрдэнэс Тавантолгой” ХК нь 16.1 сая тонн-г олборлож дангаар 28%-г бүрдүүлсэн байдаг. 2020 оны 1-р сард “Эрдэнэс Тавантолгой” ХК нь Монгол Улсын нийт чулуун нүүрс олборлолтын 14%-г дангаар олборлож байсан бөгөөд жилийн төгсгөлд нийт олборлосон /43.1 сая тонн/ чулуун нүүрсний 30% буюу 13 сая тонн-д хүргэж амжилттай ажилласан байна.

Монгол Улсын нийт олборлосон нүүрс /чулуун нүүрс/



ГЭРЭЭТ КОМПАНИУДЫН УУЛЫН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ

Цанхийн баруун уурхай нь 2019 онд уулын ажлын гэрээт гүйцэтгэгчийн сонгон шалгаруулахаар 3 багц тендер зарласан бөгөөд А багцад "Монгол майнинг энд эксплорэйшн ХХК", Б багцад "Хишиг Арвин Индустриал" ХХК В багцад "Эм Эм И Кью" ХХК нар шалгаран нүүрс олборлолт, хөрс хуулалтын ажил гүйцэтгэж байна.

2020 оноос эхлэн Цанхийн баруун уурхайн өрөмдлөг, тэсэлгээний ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж "Спейшл Майнинг Сервис" ХХК-тай гэрээ байгуулан ажиллаж байна.

Гэрээт компаниудын уулын ажлын гүйцэтгэл /А, Б, В багц/

Компани	Хөрс сая м3		Нүүрс сая тонн		Уулын цул сая м3		
	Төл	Гүй	Төл	Гүй	Төл	Гүй	Хувь
А багц Монгол майнинг энд эксплорэйшн ХХК	3.0	2.8	0.5	1.2	2.8	3.6	131%
Б багц ХАИ ХХК	15.7	14.2	1.9	2.88	17.09	16.3	95%
В багц ЭмЭмИКью	14.6	11.1	0.3	0.15	14.9	11.2	75%
Нийт	32.3	28.2	2.7	4.2	37.79	31.2	89%

Өрөмдлөг тэсэлгээний ажлын гүйцэтгэл /СМС/

Төлөвлөгөө	Гүйцэтгэл /паспорт/	Гүйцэтгэл /баталгаажсан/	Хувь
24,863,330.30	25,135,078.60	19,431,910.20	101%

ХЭМНЭЛТ

Цанхийн баруун уурхайн өмнөх уулын ажлын гэрээнүүд нь уулын ажил болон өрөмдлөг тэсэлгээний зардлыг хамтад нь тооцож байгуулсан байдаг бөгөөд нийт хийж гүйцэтгэсэн уулын цулын 1 м3 тутамд өрөмдлөг тэсэлгээний ажлын өртөг тооцогдож байсан.

Компанийн зүгээс өрөмдлөг тэсэлгээний ажлыг салгаж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулан гэрээ байгуулан ажилласнаар Цанхийн баруун уурхайн олборлолтын зардлаас 2020 онд 18.4 тэрбум төгрөгийн хэмнэлт үүсгэсэн байна.

УРТ БОЛОН ДУНД ХУГАЦААНЫ ТӨЛӨВЛӨЛТ, ТӨСӨЛ

Цанхийн баруун уурхайн ТЭЗҮ тодотголыг боловсруулж, 2020 оны 12 дугаар сарын 25-ны өдөр “Эрдэс Баялгийн Мэргэжлийн Зөвлөлийн” өргөтгөсөн хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулсан.

Төслийн бүрэн хүчин чадлыг жилд 20 сая тонн нүүрс олборлохоор боловсруулсан бөгөөд өөрийн уулын техник, нүүрс баяжуулах үйлдвэр болон конвейерийн

систем зэрэг технологиуд, дэд бүтцийн төслүүдийг тусгасан.


Цанхийн зүүн уурхайн ТЭЗҮ тодотголын ажлын явц нь 60%-тай үргэлжилж байна. Уурхайн эцсийн хүрээ, оновчлолын хэсэг, нөөцийн тулгалтын ажлууд хийгдсэн бөгөөд нарийвчилсан төлөвлөлтийн хэсэг үргэлжилж байна.

ГАДАРГУУГИЙН ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨЛТ

Тавантолгой ордыг түшиглэн Цахилгаан станц, нүүрс баяжуулах үйлдвэр, нүүрс химийн үйлдвэр, ус хангамжийн цогцолбор, Тавантолгой- Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр зам, авто зам, Тавантолгой – Ханги- Мандал чиглэлийн авто зам зэрэг төсөл хөтөлбөрүүд хэрэгжиж байна. Эдгээр төслүүдийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, Зам, тээврийн хөгжлийн сайд нарын

хамтарсан 2020 оны 7 дугаар сарын 30-ны өдрийн А/198, А/139 дүгээр хамтарсан тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг, Тавантолгой ордыг түшиглэн үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуй нэгжүүд, төсөл хэрэгжүүлэгч нарын төлөөлөл, мөн “Эрдэнэс Тавантолгой” ХК-ний төлөөлөл хамтран оролцож “Гадаргуугийн нэгдсэн ерөнхий төлөвлөгөө”- нд багтаан баталсан.

ГАДАРГУУГИЙН ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ



ТООЦОО, СУДАЛГАА

2021-2035 онуудад гүйцэтгэх уулын ажлаас “Эрдэнэс Тавантолгой” ХК өөрөө уулын техник худалдан авч ажиллуулснаас гарах эдийн засгийн үр өгөөжийг тооцож гаргах, танилцуулга бэлтгэж ТУЗ, УУХҮЯ-д танилцуулсан.

5 жилийн хугацаанд “Эрдэнэс Тавантолгой” ХК худалдан авах санхүүгийн боломжид тааруулсан өөрийн техник хөрөнгө оруулалтын тооцоо, техникийн оновчлолын ажлыг хийжээ.

Автозам, конвейерийн системийг харьцуулсан эдийн засгийн судалгаа тооцооллын ажил гүйцэтгэсэн.

Төмөр замын төслүүд болон автозам ашиглалттай холбоотой хүчин чадлын оновчлол, эдийн засгийн тооцооллыг хийсэн.

Цанхийн Зүүн уурхайн 3 жилийн уулын ажлын тендертэй холбоотойгоор олборлолтын нэгж өртгийг тооцоолж, одоогийн болон баруун уурхайн

олборлолтын өртгүүдтэй харьцуулж, үнэлэлт дүгнэлт хийсэн бөгөөд ТУЗ болон холбогдох удирдлагуудад танилцуулан ажилласан.

Цанхийн зүүн уурхайн 3 жилийн уулын ажлын тендертэй холбоотойгоор Цанхийн зүүн уурхай, Цанхийн баруун уурхайн 3 жилийн төлөвлөгөөнүүдийн хүрээнд талын дундаж зайн тооцоолол, оновчлолын ажлыг хийж гүйцэтгэн ТУЗ болон удирдлагуудад танилцуулан ажилласан.

Цанхийн зүүн уурхай, Бортээгийн хэсгүүдэд бүхэлд нь уулын ажил явах байдлаар, шинээр баригдаж байгаа нүүрсний агуулах E, S талбайнууд руу нүүрсийг буулгах талын дундаж зайг тооцоолж, буулгах талбайн оновчлол, тооцооллын ажлуудыг хийж гүйцэтгэсэн.

Уурхайгаас дээж авч баяжуулалтын бүрэн судалгаа хийх ажилд хяналт тавих, үр дүнг нэгтгэх, баяжигдах шинж чанарын тооцооллын ажлыг хийсэн.




ХАЙГУУЛ, СУДАЛГААНЫ АЖИЛ

“Эрдэнэс Тавантолгой” ХК “Элгэн” ХХК, “Монкаротаж” ХХК, “Алс групп” ХХК, “Инженер геодези” ХХК зэрэг компаниудтай өрөмдлөг, цооногийн геофизик, нүүрс, чулуулгийн шинжилгээний ажил гүйцэтгэх гэрээний дагуу хамтран ажиллаж байна.

Цанхийн баруун, зүүн хэсгийн уурхайн олборлолтын 3 жилийн хүрээнд ашиглалтын хайгуул, геотехникийн

өрөмдлөг, болон Бортээг хэсгийн шинээр нээгдэх уурхайн ТЭЗУ-н дагуу ашиглалтын 3 жилийн хүрээнд хайгуулын өрөмдлөг, геофизикийн судалгааны 50000 тууш метр ажлыг 2020 оны 04 сарын 13 өдрөөс эхлүүлэн 2020 оны 11 сарын 10 өдрийг хүртэлх хугацаанд амжилттай гүйцэтгэлээ. Энэ жилийн ажлын хувьд геотехникийн судалгааны ажлыг Цанхийн зүүн уурхайн хөрсний 2-р овоолгын орчимд эхлүүлсэнээрээ онцлог байлаа.

ХАЙГУУЛЫН ХЭЭРИЙН АЖЛЫН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ




ӨРӨМДЛӨГ, ГЕОФИЗИК: 2020 оны ажлын зорилго нь Цанхийн зүүн болон баруун уурхайн ахилттай уялдуулан ашиглалтын хайгуулын ажлыг уурхайн бүсэд тодорхойгүй хэсгүүдийг шалгах мөн 2-3 жилийн (2020-2023) тэлэлтийн хүрээнд хийж ашиглалтын нөөцийг бэлтгэх, олборлох хэсгийн нүүрсний структур, хил зааг, чанар (өмнөх судалгаагаар бүрэн судлагдаагүй байсан 0 давхраасын мэдээллийг нарийвчлах), нүүрсний гарцийг нарийвчлах, геотехникийн тогтворжилтын судалгаа хийж уурхайн хэвийн үйл ажиллагааг хангах мөн Бортээгийн хэсэгт 2021

оноос шинээр эхлэх уурхайн эхний 1-2 жилд олборлох нөөцийг ашиглалтад бэлтгэх, нүүрсний гарц, уурхайн эцсийн ханыг оновчлох өмнөх нарийвчилсан хайгуулыг гүйцээх байсан юм.


Энэ хайгуулын ажлаар Цанхийн баруун хэсэгт 65 цооногийн 19237.6 тууш метр, Цанхийн зүүн хэсэгт 89 цооногийн 22035.2 тууш метр, Бортээгийн хэсэгт 37 цооногийн 8327.7 тууш метр, Ончхараатын хэсэгт 1 цооногийн 399.5 тууш метр өрөмдлөгийн ажлыг гүйцэтгэсэн.

ХАЙГУУЛЫН ӨРӨМДЛӨГИЙН АЖЛЫН ДЭВСГЭР ЗУРАГ



Өрөмдлөгийн ажлыг “Элгэн” ХХК нь өөрийн эзэмшлийн БНСУ-д үйлдвэрлэсэн Youngjin Power 900 маркийн 10 өрмийн машин болон бусад туслах 21 автомашин, техник, тоног төхөөрөмжөөр гүйцэтгэсэн бөгөөд өдөр шөнийн ээлжинд 8-9 геологич хяналт тавин ажилласан.

А- ӨРМИЙН МАШИН Б- ӨРМИЙН ГЕОЛОГИЧ ХЯНАЛТ ТАВИН АЖИЛЛАЖ БУЙ БАЙДАЛ



Өрөмдөж дууссан цооног бүрт “Монкаротаж” ХХК-ийн инженерүүдтэй хамтран цооногийн геофизикийн судалгааг гүйцэтгэсэн ба Gamma, density, caliper, electric resistance, deviation, sonic, dipmeter8 acoustic televiewer зэрэг тусгай зориулалтын багажийн хэмжилтүүд хамаарна.

ГЕОЛОГИ, ГЕОТЕХНИКИЙН БИЧИГЛЭЛ: Хайгуул, судалгааны ажлыг Австралийн ЖОРК стандартын дагуу нүүрс, чулуулаг тус бүрийн хил заагийг ялган эрдэсжилт, хувирал, өгөршил, структур, текстур зэрэг геологийн шинж чанар, нүүрсний үе давхраасуудын зузаан, чанар, чулуулгийн исэлдэл, өгөршлийн бүс зэрэг хээрийн нөхцөлд авч болох бүхий л мэдээллийг тодорхойлох ажлууд хийгдсэн.

ГЕОЛОГИ, ГЕОТЕХНИКИЙН БИЧИГЛЭЛ ХИЙГДЭЖ БУЙ БАЙДАЛ



ДЭЭЖЛЭЛТ: Цооногийн бичиглэл болон каротажийн мэдээлэлд боловсруулалт хийн нүүрс, геотехник, палеонтологи, барилгын материал зэрэг дээжлэлтүүдийг гүйцэтгэсэн.

Ашиглалтын хайгуулын өрөмдлөгөөс нүүрсний 15433 ш дээжлэлт хийснээс 11668 ш дээжийг “Алс групп” ХХК-ийн лабораторид хүлээлгэн өгч шинжилгээнд хамруулан чанарын хяналт хийсэн. Мөн хайгуулын ажлын хүрээнд “SGS” ХХК компаниар Цанхийн баруун зүүн уурхайн 40 гаруй дээжинд гадаад хяналтын шинжилгээ хийлгэсэн.

НҮҮРСНИЙ ДЭЭЖЛЭЛТ БОЛОН ГЕОТЕХНИКИЙН ДЭЭЖИЙГ ЛАБОРАТОРИД ХҮЛЭЭЛГЭН ӨГЧ БУЙ БАЙДАЛ



ЦЭГЭН ДАРАЛТЫН ТУРШИЛТ: Хээрийн нөхцөлд чулуулгийн хатуулаг, даралт тэсвэрлэх чадамж зэрэг физик, механик шинж чанарыг тодорхойлох зорилгоор геотехникийн судалгаатай уялдуулан туршсан.

МЭДЭЭЛЭЛ БАРИМТЖУУЛАХ, НЭГТГЭХ: Хээрийн ажлын явцад геологийн анхдагч баримт материалуудыг бүрдүүлж баримтжуулан, мэдээллүүдийг тоон мэдээллийн сан хөрвүүлэн, хяналт тавин ажилладаг.

ЦЭГЭН ДАРАЛТЫН ТУРШИЛТ БА МЭДЭЭЛЭЛ НЭГТГЭХ



Өрөмдлөг, судалгааны ажлын өдөр тутам, 7 хоног, сарын мэдээ гүйцэтгэл зэргийг гаргахаас гадна анхан шатны суурин боловсруулалтын ажлуудыг хээрийн ажлын үеэр гүйцэтгэсэн.

ДАВХАРГАЗҮЙН СУДАЛГАА: Тавантолгой ордын нүүрс агуулагч чулуулгийн стратиграфи, палеонтологийн цогц судалгааны ажил хийгдэж байгаа бөгөөд судалгааны ажлын эхний үр дүнгээр Тавантолгой формацийн тулгуур зүсэлтийг Бортээгийн талбайд тогтоож Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамнаас хаягжуулалт хийгдсэн.

2020 ОНЫ ӨРӨМДЛӨГ, ХАЙГУУЛЫН АЖЛЫН ҮР ДҮН

Цанхийн зүүн болон баруун уурхайн ойрын 2-3 /2023 он хүртэл/ жилийн ахилтын хүрээнд ашиглалтын хайгуул гүйцэтгэж нөөцийг ашиглалтад бэлтгэсэн.

2020 оны хайгуулын ажлаар Цанхийн зүүн уурхай доторх ашиглалтын хайгуул хийгдээгүй уулын ажлын төлөвлөгөөнөөс зөрөх магадлалтай хэсгүүдэд уурхай ашиглалтын А.6 блок орчимд нэмэлт өрөмдлөгийн ажил хийж нарийвчилсан.

Цанхийн баруун уурхайн ашиглалтын D.4 блокийн орчимд 3 давхраасын хагарлаар зөрсөн хэсгийг нарийвчилж тодруулсан.

Цанхийн баруун уурхайн B.2.5 блокийн орчимд 3 давхраасын гарш үзүүрийн хэсгийн нүүрсний структурийг тогтоож, баталгаажуулсан.

Цанхийн зүүн уурхайн хөрсний 2-р овоолгын тогтворжилт, геотехникийн судалгааны өрөмдлөг хайгуулын ажлыг гүйцэтгэсэн.

Бортээгийн хэсэгт шинээр нээх уурхайн эхний 1-2 жилийн хүрээнд олборлох нөөцийг ашиглалтад бэлтгэж, балансын нүүрсний гарцыг нарийвчлан судалсан.


Бортээгийн талбайн хүрээнд нүүрс агуулагч хурдас нь бараг моноклиналь оршилтой байдаг байна. Чулуулгийн үе, нүүрсний үе давхарга хойшоо 20-35° уналтайг тогтоосон. Улааннуурын синклиналийн өмнөд жигүүрийн тэнхлэгийн дагуу өрөмдсөн хайгуулын цооногийн зүсэлт дэх эвдрэлийн орчинд нүүрст хурдас, нүүрсний үе давхаргын уналын өнцөг илүү их байна.

Уурхайн бүсийн гүний усны статик төвшнийг тодорхойлсон.

Өмнөх хайгуул судалгааны явцад бүрэн судлагдаагүй хэсгийн 0 давхраасыг нарийвчлан судалсан.

Онч хараатын хэсэгт хайгуулын 1-р шугам дээр 3 болон 4-р давхраасын чанар болон зузааны талаар урьдчилсан мэдээллийг хайгуулын 1ш цооногоор шалгасан.

ХАЙГУУЛЫН СУДАЛГААНЫ ТҮВШИН 2020 ОНЫ ХАЙГУУЛЫН ДАРАА



2020 оны хайгуулын ажлаар Тавантолгойн ордын брахисинкиналын төвийн хэсгийг хөндлөн чиглэлд дайрсан Цанхийн хэсгийн Тавантолгойн голч хагарлын хойд хэсэг зарим хэсэгтээ ялангуяа Цанхийн зүүн уурхайд хагарал орчмын бүсийг шалгаж судалсан ба структурийн тайлал боловсруулалтын ажлууд үргэлжлэн хийгдэж байна.

Судалгаанаас явцаас харахад голч хагарлаас урагш нүүрсний давхраасууд тогтворгүй болдог ба өмнөх судалгаагаар тогтоогдсон зүсэлтүүдэд зарим давхраасууд

зөрж холбогдсон байдал их ажиглагдаж байна. Ер нь уулын ажлын явцад иймэрхүү тохиолдол гардаг ба тухайн тохиолдлуудаас урьдчилан сэргийлэхэд ашиглалтын хайгуулын нэг зорилго оршдог.

Цаашдаа дээрх өрөмдлөг хайгуулын ажлуудын үр дүнд ордын нэгдсэн модель боловсруулах, чанарын өөрчлөлтүүдийг судлах, нүүрсний техникийн шинжилгээнээс гадна нарийвчилсан бусад шинжилгээнүүдийг шат дараатайгаар гүйцэтгэхээр төлөвлөн ажиллаж байна.

ОРДЫН НӨӨЦИЙН ТАЙЛАН

Тавантолгойн ордын нийт нөөцийн хэмжээг Австрали Азийн ЖОРК код (2012) болон Канад, Европын NI 43-101 стандартын дагуу АНУ-ын "Стантек" компаниар гүйцэтгүүлэн хамтран ажиллаж нөөцийн үр дүнгийн тайланг хүлээн авлаа. Ордын нийт нөөцийн хэмжээг **7.4 тэрбум** тонн хэмээн тогтоосон байна. Энэхүү тайлангаар Цанхийн зүүн хэсгийн эдийн засгийн хувьд үр ашигтай

нүүрсний ашиглалтын нөөцийг 500 метр хүртэл гүнд, Цанхийн Баруун хэсгийн нүүрсний нөөцийг 400 метрийн гүнд тооцоолсон.

Энэхүү гүний хэмжээсүүд нь уурхайн талбайн хэмжээ болон хөрс хуулалтын харьцааг харгалзан үзсэн бөгөөд ил уурхайн олборлолт хийхэд хамгийн боломжит гүн гэж үзсэн.

2020 ОНД JORC АРГАЧЛАЛААР ТООЦСОН НӨӨЦ

Тус аргачлалаар Цанхийн зүүн хэсгийн нийт коксжих нүүрсний нөөцийг 973 сая тонн, эрчим хүчний нөөцийг 303 сая тонн буюу нийт нөөцийг 1.2 тэрбум тонн, Цанхийн баруун хэсгийн нийт коксжих нөөцийг 998 сая тонн, эрчим хүчний нүүрсний нөөцийг 322 сая тонн буюу нийт 1.32 тэрбум тонноор үнэлж баталгаажуулсан.

НӨӨЦ ЖОРК

ЗҮҮН ЦАНХИ (MV-011943, MV-016883)

1,279 сая.тн

East Tsankhi Total In-Place Resources			
Classification	Total Coal (Mt)	Coking Coal (Mt)	Thermal Coal (Mt)
Measured	850	641	209
Indicated	398	317	81
Inferred	32	19	13
Total	1,279	976	303

976 сая.тн

Коксжих нүүрс
76.3%


303 сая.тн

Эрчим хүчний нүүрс
23.7%

Зүүн Цанхийн нүүрсний нөөц, нөөцийн ангилалаар (сая.тн)



2,599 сая.тн



БАРУУН ЦАНХИ (MV-016881, MV-016882)

1,320 сая.тн

West Tsankhi Total Controlled Resources			
Classification	Total Coal (Mt)	Coking Coal (Mt)	Thermal Coal (Mt)
Measured	864	662	202
Indicated	423	310	113
Inferred	32	25	7
Total	1,320	998	322

998 сая.тн

Коксжих нүүрс
75.6%

322 сая.тн

Эрчим хүчний нүүрс
24.4%

Баруун Цанхийн нүүрсний нөөц, нөөцийн ангилалаар (сая.тн)



2020 ОНД NI 43-101 АРГАЧЛАЛААР ТООЦСОН НӨӨЦ

Тус аргачлалаар Цанхийн зүүн хэсгийн нийт коксжих нүүрсний нөөцийг 982 сая тонн, эрчим хүчний нөөцийг 318 сая тонн буюу нийт нөөцийг 1.3 тэрбум тонн, Цанхийн баруун хэсгийн нийт коксжих нөөцийг 1,031 сая тонн, эрчим хүчний нүүрсний нөөцийг 357 сая тонн буюу нийт 1.38 тэрбум тонноор үнэлж баталгаажуулсан.

НӨӨЦ NI43-101

ЗҮҮН ЦАНХИ (MV-011943, MV-016883)

1,300 сая.тн

East Tsankhi Total In-Place Resources			
Classification	Total Coal (Mt)	Coking Coal (Mt)	Thermal Coal (Mt)
Measured	843	645	198
Indicated	425	319	107
Inferred	32	19	14
Total	1,300	982	318


982 сая.тн

Коксжих нүүрс
75.5%


318 сая.тн

Эрчим хүчний нүүрс
24.5%

Зүүн Цанхи



2,688 сая.тн



БАРУУН ЦАНХИ (MV-016881, MV-016882)

1,388 сая.тн

West Tsankhi Total Controlled Resources			
Classification	Total Coal (Mt)	Coking Coal (Mt)	Thermal Coal (Mt)
Measured	889	692	197
Indicated	466	314	151
Inferred	33	25	8
Total	1,388	1,031	357


1,031 сая.тн

Коксжих нүүрс
74.3%

357 сая.тн


Эрчим хүчний нүүрс
24.7%

Баруун Цанхи



Цанхийн баруун зүүн хэсгийн гүнээр хязгаарлагдсан нөөц

Resource Interval (m)	Coking Coal				Thermal Coal				Grand Total
	MEAS	IND	INF	TOTAL	MEAS	IND	INF	TOTAL	
0-100	398.7	169.1	12.5	580.2	101.8	144.7	5.6	252.1	832.3
0-200	929.2	356.8	19.8	1,305.80	236	201.5	7.8	445.2	1,751.00
0-400	1,485.50	754.5	60.1	2,300.10	436.9	310.3	37.9	785.1	3,085.20
0-500	1,802.20	917.8	99.4	2,819.40	458.4	370	68.7	897.2	3,516.50



Суурин боловсруулалт: Ордын хэмжээнд 1970 оноос хойш хийгдсэн өрөмдлөг хайгуулын ажлын үр дүнг нэгтгэх, хайгуулын цооног тус бүрийн нүүрсний интервалуудыг тулган баталгаажуулах, нэгдсэн мэдээллийн сан үүсгэх ажлын хүрээнд геологийн бичиглэл, геофизикийн каротаж дээжлэлтийн үр дүнг шалгаж тааруулах, цооногийн корреляцийн ажлыг эхлүүлээд байна.

Баяжуулалтын судалгаа: Ордын хэмжээнд Цанхи болон Бортээгийн хэсгийн нүүрсний баяжигдах шинжчанаар судалгааны ажил үргэлжлэн хийгдэж байна. Туршилтаар нийт 1908 дээж шинжилгээнд хамруулсан.

Мөн “Эрдэнэс Тавантолгой” ХК нь нүүрс баяжуулах үйлдвэрийн төслийн ТЭЗҮ, FEED буюу урьдчилсан зураг төсөл боловсруулахаар БНХАУ-ын “СМЕС” компанийн хамтаар ажиллаж байгаа бөгөөд тус ажлын хүрээнд технологийн туршилт,

судалгааны ажлыг эхлүүлэн ажиллаж байна. Энэхүү ажлын хүрээнд нүүрсний баяжуулалтын судалгааны дээжийг Цанхийн баруун болон зүүн уурхай, Цанхийн баруун уурхайн нүүрсний агуулах, “Таван толгой” ХК-ийн уурхайгаас бөөн дээж авч, “Алс Групп” ХХК-ийн нүүрсний төв лабораториор шинжлүүлсэн.

3D Модель боловсруулалт: Цанхийн баруун, зүүн уурхайн ТЭЗҮ боловсруулах ажлын хүрээнд Цанхийн зүүн хэсгийн геологийн 3 хэмжээст загварчлалыг 2018 оны батлагдсан нөөцийн тайланд тохируулан шинэчлэн боловсруулсан. Шинээр модель боловсруулах ажлыг хөнгөвчлөх, ордын хэмжээний том модель боловсруулах ажлын хүрээнд Minescape /Datamine/ программыг ашиглалтад нэвтрүүлж эхний ээлжид цанхийн зүүн уурхайн структур моделийг боловсруулсан. Цаашдаа дараа дараагийн боловсруулалтын ажлыг хийхээр төлөвлөж байна.



2.2. БАЙГАЛЬ ОРЧИН, ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ

БАЙГАЛЬ ОРЧНЫ БОДЛОГО, НӨХӨН СЭРГЭЭЛТ

Байгаль орчныг хамгаалах, усны зохистой хэрэглээг бий болгох асуудал эн тэргүүний зорилт хэмээн үзэж, энэ чиглэлээр компанийн нийгмийн хариуцлагыг чиглүүлэн ажиллаж байна. “Эрдэнэс Тавантолгой” ХК нь байгаль орчинд учирч болохуйц сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, нөхөн сэргээх зорилготой менежментийн төлөвлөгөөг 2020 оны 04 дүгээр сарын 01-ний өдөр БОАЖЯ-аар батлуулан Цанхийн уурхайн үйл ажиллагаанд хог хаягдал, ус, тоосжилт, хөрсний элэгдэл, эвдрэл нөхөн сэргээлт зэрэг чиглэлүүдээр төрөлжсөн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэн ажиллаж байна.

“Эрдэнэс Тавантолгой” хувьцаат компани уурхайн дэд бүтцийн усан хангамжийн эх үүсвэрийг Загийн усны хоолойгоос татаж авах бололцоог бүрдүүлэхээр “Монгол Ус” ТӨҮГ-тай “Санамж бичиг” байгуулсан бөгөөд “Загийн усны хоолойг Улсын

төсвийн хөрөнгөөр судалж, нөөц тогтоосон газрын доорх усны эрэл, хайгуул, судалгааны зардлыг ус ашиглагчаар эргүүлэн төлүүлэх” тухай гэрээг байгуулахаар ажиллаж байна.

“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн зүгээс байгаль экологийн тэнцвэрт байдлыг хангахад чиглэсэн “Ногоон говь”, Өмнөговь аймгийн ИТХ-ын 2015 оны 56 дугаар тогтоолоор батлагдсан “Тонн баялаг – 1 мод” зэрэг хөтөлбөрүүдийг хэрэгжүүлдэг бөгөөд говийн нэн ховор ургамлын төрөл зүйлийг хамгаалах, моджуулах үйл ажиллагааг тогтмол зохион байгуулж байна. Компанийн үйл ажиллагаа эхэлсэн цагаас хойш Цанхи хотхон, Эрдэнэс хотхон болон хотхон дундах цэцэрлэгт хүрээлэн, уурхайн оффисын гадна талбай, зочдын тавцан, мод үржүүлгийн талбай зэрэгт нийт 110696 ширхэг мод тарьсан.

КОМПАНИЙН УС АШИГЛАЛТЫН БАЙДАЛ

Уурхайн хэмжээнд нийт гүний усны 21 худаг байгаа бөгөөд өнөөдрийн байдлаар ашиглагдаж буй 16 худаг байна. 2020 оны 10 сарын байдлаар гүний худгаас нийт 592.5 мянган тонн ус ашигласан байна.

Үүнд:

- ✓ Үйлдвэрлэлийн зориулалтаар – 488.2 мян.тн ус;

- ✓ Ахуйн хэрэглээний зориулалтаар - 25.6 мян.тн ус;
- ✓ Мод усалгааны зориулалтаар – 12.5 мян.тн усыг ашигласан байна.

Мөн Цанхийн баруун, зүүн уурхайгаас шавхан зайлуулсан буюу шүүрлийн ус 8.878 мянган тонн усыг тоосжилт дарах зорилгоор зам усалгаанд ашиглажээ.

Гүний усны ашиглалт /тонн/

Сар	Ахуйн	Үйлдвэрийн	Ойжуулалт	Эх үүсвэр			Бүгд
				Худаг	Шүүрэл	Хурын ус	
I	2,957	21,268		24,225			2,4225
II	3,421	39,982		43,403			43,403
III	2,991	56,681		59,672			59,672
IV	3,427	67,617	129	71,173	4,865		76,038
V	3,106	70,057	2,283	75,446	2,307		77,753
VI	2,044	78,322	3,099	83,465	746		84,211
VII	1,741	48,658	2,407	52,806		10,280	63,086
VIII	2,140	29,210	1,819	33,169		7,354	40,523
IX	1,942	34,029	1,648	37,619		16,416	54,035
X	1,836	42,427	1,197	45,460	960	23,153	69,573
Нийт	25,605	488,251	12,582	526,438	8,878	57,203	592,519

ОРОН НУТАГТАЙ ХАМТРАН АЖИЛЛАХ, НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫН ХҮРЭЭНД

Уул уурхайн сайн туршлагын дагуу орон нутгийн иргэд уурхайн үйл ажиллагааг хүлээн зөвшөөрч, нийгэмд эерэг хандлага давамгайлах явдлыг уул уурхайн салбарын оршин тогтнох үндэс суурь гэж үздэг.

Компанийн нийгмийн хариуцлагын хүрээнд Цогтцэций сумын Өгөөмөр, Билгэх, Цагаан-Овоо, Сийрст багийн малчид болон уурхайн нөлөөллийн бүсийн айлуудад өвөлжилтөд зориулан дэмжлэг үзүүлэх зорилгоор 500 шуудай хивгийг тараан өгсөн.

Өвөлжилтийн нөхцөл байдал хүндэрсэн үед зэрлэг амьтдад өвс тэжээл тараан тавих ажлыг жил бүр сум орон нутагтай хамтран зохион байгуулдаг ба 2020 онд нийт 150 боодол өвсийг Уушийн цохио, Цэций хайрхан зэрэг газруудад тараан байршуулж биотехникийн арга хэмжээг авч хэрэгжүүлсэн.

УУШИЙН ЦОХИОНД БИОТЕХНИКИЙН АРГА ХЭМЖЭЭ АВЧ ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ БАЙДАЛ

ХИВЭГ ТАРААХ ҮЙЛ АЖИЛЛАГАА



Цогтцэций сумын ЗДТГ-аас ирүүлсэн 2020 оны 4 сарын 08-ны өдрийн №1-222 тоот албан бичгийн дагуу Цогтцэций сумын хэмжээнд 04 сарыг Ариутгал халдваргүйтгэлийн сар болгон зарласантай холбогдуулан Цогтцэций сумаас зүүн тийш болон зүүн урагш нийтдээ 10 га талбайд хог хаягдлын их цэвэрлэгээг зохион байгуулсан. Уг арга хэмжээнд гэрээт компаниудын нийт 126 ажилчид оролцож 15 тонн хог хаягдал цэвэрлэсэн.

ИХ ЦЭВЭРЛЭГЭЭНИЙ ҮЕЭР




БАЙГАЛЬ ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ

ТООСОНЦРЫН АГУУЛАМЖИЙН ХЭМЖИЛТ

Хэмжилтийг уурхай болон хотхоны хэмжээнд нийт 7 цэгт хийж байгаа бөгөөд тоосны хэмжилтийн Dusttrak DRX8533 болон Dusttrak DRX8533 EP багаж ашиглан Уурхайн оффис, Цанхи хотхон, Борлуулалтын талбайд 7 хоногийн 3 өдөр 24 цагийн хэмжилт хийж байна.

Монгол Улсын Агаарын чанарын стандарт MNS 4585:2016-ын дагуу 24 цагийн хэмжилт нь нарийн ширхэглэгт тоосонцор PM2.5-ын зөвшөөрөгдөх дээд хэмжээ 50мкг/м3, том ширхэглэгт тоосонцор PM10-ын зөвшөөрөгдөх дээд хэмжээ 100мкг/м3 байх ёстой байдаг ба хэмжилтийн утгаас харахад зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс-с 1.5-2 дахин илүү гарч байна. Цаашид тоосжилтыг бууруулах талаар туршилт судалгааны ажлыг зохион байгуулж байна.



Тухайлбал “Спецпродукт монгол” ХХК-тай “Тоос бууруулах бодис турших ажлын гэрээ хийж 2020 оны 06 сарын 22-26-ны өдрүүдэд Цанхийн баруун уурхайн

Бортээгийн 1-р замын ачаатай талын нийт 1.3 км буюу 18200 мкв зам дээр тоосжилт бууруулах туршилтын ажлыг хийсэн. Bitanox-RZ бодисыг технологийн горимын дагуу 70:30 харьцаатай буюу 10 тонн усанд 3 тонн бодис найруулан нийт 13 тонн усыг зам дээр цацаж туршсан.

ТУРШИЛТ ХИЙЖ БАЙГАА НЬ



МАЛЧДЫН ХУДГИЙН ТҮВШИН ХЭМЖИХ

Цагаан-Овоо багийн Улаан овоо, Бунхант, Могойт, Сийрст багийн Эргийн ус, Гүн гашуу худагт автомат түвшин хэмжигч суурилуулсан ба сар бүр түвшин хэмжигч багажаар (Levelloader) бичигдсэн хэмжилтийн датаг авч, дүнг нэгтгэж байна.

ХИЙН ТӨЛӨВТ АГААР БОХИРДУУЛАГЧ БОЛОН УС, ХӨРСНИЙ ЧАНАРЫН ШИНЖИЛГЭЭ

Усны чанарын шинжилгээг Улаанбаатар хотод байрлах “Ханлаб” ХХК-ийн итгэмжлэгдсэн лабораторитой гэрээ

байгуулан усны хими, микробиологи, саарал усны үзүүлэлтүүдийг шинжлүүлдэг ба 2020 оны 01 болон 05-р сард дээж бэлтгэн шинжилгээнд хүргүүлсэн.

Хөрсний шинжилгээг “Инженер геодези” ХХК-тай гэрээ байгуулан хөрсний механик иж бүрдэл, агрохими, хүнд металлын үзүүлэлтүүдийг шинжлүүлдэг. 2020 оны 01 болон 05-р сард дээж авч шинжилгээнд хүргүүлсэн ба шинжилгээний хариу стандартаас давсан үзүүлэлт байхгүй байна.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хүрээнд хийн төлөвт органик бус бохирдуулагчийн шинжилгээг 2020 оны 05 дугаар сарын 19-20-ны өдрүүдэд “Ногоон титэм” ХХК-ийн мэргэжилтэнтэй хамтарч хяналтын нийт 10 цэгээс агаарын сорьцын дээж авсан.

ХӨРСНИЙ ШИНЖИЛГЭЭНИЙ ДЭЭЖ БОЛОН АГААРЫН СОРЬЦ ЦУГЛУУЛЖ БАЙГАА БАЙДАЛ



СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ: (УСАН ОРЧИН)

2020 онд туслан гүйцэтгэгч “Эм Эм И Кью” ХХК, “Хишиг-Арвин Индустриал” ХХК, “Ти Ти Жи Ви Си Өү” ХХК-тай хамтран 5 худгийн амыг засах, худгийн байр барих ажлыг хийж гүйцэтгэлээ.

ХУДГИЙН БАЙР БАРЬСАН БАЙДАЛ



НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТУРШИЛТЫН АРГА ХЭМЖЭЭ

Нөхөн сэргээлтийн туршилтын ажлын хүрээнд шимт хөрсний 4-р овоолго дээр 10 зүйлийн нутгийн ургамал тариалж усалгаа арчилгааны ажил хийгдэж байна. Нөхөн сэргээлтийн туршилтын талбайд ургаж буй хайлаас, шар хуайс зэрэг модны үрийг түүж тусгай хайрцаглан бэлтгэсэн талбайд тарилт хийсэн.

ХАЙЛААСНЫ ҮР ТҮҮХ, СУУЛГАХ АЖЛЫН ЯВЦ



8.2 км зам тавих ажилд ашиглагдаж байсан хайрганы карьерийн техникийн нөхөн сэргээх ажлыг Эм Эм И Кью ХХК-н хариуцан хийж гүйцэтгэсэн. Нийт 12109 м² талбайг техникийн нөхөн сэргээлтийг хийж хөрсийг тэгшилсэн.

ТЕХНИКИЙН НӨХӨН СЭРГЭЭЛТ ХИЙГДСЭН БАЙДАЛ



ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙ

“Эрдэнэс Тавантолгой” ХК 2019 онд Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үйл ажиллагааны олон улсын менежментийн тогтолцооны ISO 45001:2018 стандартыг үйл ажиллагаандаа бүрэн нэвтрүүлж, 2020 оны 08 дугаар сард магадлан аудитад хамрагдаж ISO 45001:2018 стандартын гэрчилгээг сунгуулж чадсан. Энэ онд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн заавар журмыг чанд мөрдөн ажиллаж үйлдвэрлэлийн осол, болзошгүй аюулаас бүрэн урьдчилсан сэргийлж, компанийн хэмжээнд осол, нас баралтын тохиолдол бүртгэгдээгүй байна.

2020 оны байдлаар “Эрдэнэс Тавантолгой” ХК болон гэрээт, туслан гүйцэтгэгч компаниудын ажилтнуудыг ХАБЭА-н 6 төрлийн сургалтад хамруулжээ.

Давхардсан тоогоор шинэ ажилтны сургалтад 3796, жолооны сургалтад 1399, цахилгааны сургалтад 38, түр ажиллах ажилтны сургалтад 321, өөр ажлын байранд шилжсэн ажилтны сургалтад 42, журам танилцуулах 120, давтан сургалт 1758, зөрчлийн сургалтад 38 ажилтныг тус тус хамруулсан байна.






2.3. НҮҮРС БОРЛУУЛАЛТ


Манай компани нь 2010 онд үйл ажиллагаа эхлүүлж, 2011 оны 07-р сараас Цанхийн уурхайгаас олборлосон нүүрсийг борлуулж, экспортолж эхэлсэн цагаас хойш 2020 он дуустал 9.0 их наяд төгрөгийн мөнгөн орлоготой ажиллаж, 71.0

сая тонн нүүрс (Үүнд коксжих нүүрс 67.0 сая тонн (94%), исэлдсэн нүүрс 4.0 сая тонн (6%)) -ийг борлуулж, Монгол улсын Гашуунсухайт, Замын-Үүд, Ханги боомтуудаар экспортод гаргаад байна.

“Эрдэнэс Тавантолгой” ХК нь 2010-2020 оны хооронд борлуулсан хэмжээ, орлогын дүнг дор харуулав.



2020 Ковид-19 коронавируст цар тахлын үед компани нь нүүрсний борлуулалтыг хэвийн тасралтгүй үргэлжлүүлэх чиглэлээр ажиллаж, **591.7 сая \$**-ын орлоготой ажилласан.



БОРЛУУЛАЛТЫН ОНЦЛОХ АМЖИЛТУУД:

2,568,337.60

2020 оны 12-р сард **2,568,337.60** тонн нүүрс ачуулж борлуулсан нь компанийн түүхэнд нэг сард ачуулж борлуулсан нүүрсний дээд хэмжээ юм.

106,574.25

2020 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр **106,574.25** тонн нүүрс ачиж борлуулсан нь Өдрийн ачилт, борлуулалтын дээд үзүүлэлт болжээ.


ЗАХ ЗЭЭЛ

Гуравдагч зах зээлд нүүрс нийлүүлэх хамтын ажиллагааны суурийг тавьж, Гашуунсухайт, Замын-Үүд, Ханги боомтуудаар нүүрс экспортолсон.

100%


ТУЗ-аас баталсан төлөвлөгөөний биелэлт 2020 оны 12 дугаар сарын 29-ний өдөр бүрэн хангагдсан.

Компанийн сүүлийн 5 жилийн хугацаанд **56.5** сая тонн нүүрс борлуулж, **3.0 тэрбум** ам.долларын мөнгөн орлоготой ажилласан.




Сүүлийн 5 жилийн нийлүүлэлтээс харахад дунджаар нийт борлуулалтын 63-85%-ийг Цанхийн зүүн уурхайгаас, 15-37%-ийг Цанхийн баруун уурхайгаас нийлүүлсэн байна.

График: Цанхийн баруун, зүүн уурхайн борлуулалт



“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Төлөөлөн Удирдах зөвлөлөөс 2020 онд Цанхийн баруун уурхайгаас 9 сая тонн, Цанхийн зүүн уурхайгаас 18 сая тонн, нийт 27 сая тонн нүүрс борлуулж, экспортлох төлөвлөгөөг баталсан боловч Дэлхий дахин тархаад буй Ковид-19 коронавируст халдварын улмаас компанийн олборлолт, борлуулалт, тээвэрлэлтийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлсөнтэй холбоотойгоор төлөвлөгөөг дахин тодотгосон.

Төлөөлөн удирдах зөвлөлөөс 2020 оны 09 дүгээр сарын 14-ний өдөр дахин тодотгон баталсан төлөвлөгөөний дагуу 2020 онд 11.7 сая тонн нүүрс борлуулж, 1.5 их наяд төгрөгийн орлоготой ажиллахаар төлөвлөсөн ба нийт 1.68 их наяд төгрөгийн мөнгөн дүн бүхий 11.9 сая тонн нүүрс борлуулснаар тодотгосон төлөвлөгөөний биелэлт нүүрсний хэмжээний хувьд 102%, мөнгөн дүнгийн хувьд 111%-тай байна. Үүнээс 9.05 сая тонн нүүрсийг Гашуунсухайт, Ханги, Замын-үүд боомтоор экспортолсон байна.




Эхний 6 сарын байдлаар 1.57 сая тонн /сарын дундаж 0.27 сая тонн/ нүүрс борлуулсан бол сүүлийн 6 сарын байдлаар 10.3 сая тонн /сарын дундаж 1.69 сая тонн/ нүүрс борлуулсан нь эхний 6 сарын үзүүлэлтээс нийт борлуулсан хэмжээ нь 6.6 дахин, сарын дундаж үзүүлэлт нь 6.4 дахин өссөн үзүүлэлттэй байна.

Сүүлийн 6 сарын дундаж үзүүлэлтээр тооцоход манай

компани нь Цанхийн уурхайгаас жилд 20 сая тонн, сарын хамгийн өндөр үзүүлэлтээр тооцоход жилд 25-30 сая тонн нүүрсийг уурхайн амнаас ачуулж, борлуулах бүрэн боломжтойг харуулсан.

Нийт борлуулалтын 68% буюу 8.1 сая тонн нүүрсийг Цанхийн зүүн уурхайгаас, 32% буюу 3.75 сая тонн нүүрсийг Цанхийн баруун уурхайгаас нийлүүлсэн байна.



Нийт борлуулалтын 97% буюу 11.4 сая тонн түүхий хатуу коксжих нүүрс, 3% буюу 0.3 сая тонн түүхий исэлдсэн нүүрс нийлүүлсэн байна.

	Исэлдсэн нүүрс		Коксжих нүүрс		Нийт
2019 он	513.45	3%	14,979.75	97%	15,497.62
2020 он	348.04	3%	11,550.82	97%	11,905.10

Нийт борлуулалтын 97%-ийг коксжих нүүрсний борлуулалт эзэлж байгаа ба нийт борлуулсан коксжих нүүрсний чанарын дундаж үзүүлэлтийг авч үзвэл Дэгдэмхий хий 29.5-аас дээш дундажтай коксжих нүүрсний борлуулалт 3.74 сая тонн байсан ба энэ нь нийт борлуулалтыг 31%-ийг, коксжих нүүрсний борлуулалтын 32%-ийг эзэлж байна. Дэгдэмхий хий 29.5-аас дээш үзүүлэлттэй буюу сул коксжих чанартай нүүрс нь үнийн


хувьд хатуу коксжих чанартай нүүрснээс бага боловч 2020 онд хатуу коксжих нүүрсний үнэтэй ижил үнээр борлуулсан байна. Сул коксжих болон хатуу коксжих нүүрсний үнийн зөрүүг дунджаар 9.9-16%-зөрүүтэй байдаг ба хамгийн бага зөрүүгээр тооцоход 2020 онд хатуу коксжих нүүрсний үнээр борлуулсан сул коксжих нүүрснээс 18.5-30.0 орчим сая ам.долларын нэмэлт орлого олсон байна.

Төрөл	VM	Хэмжээ	Хувь
Хатуу коксжих 3,4	29.5>	7,807,508.50	66%
Сул коксжих	29.5<	3,743,309.55	31%
Исэлдсэн	OxI	348,043.10	3%
Нийт		11,898,861.15	

“Эрдэнэс Тавантолгой” ХК нь 2020 онд 591.7 сая ам.долларын борлуулалтын мөнгөн орлоготой ажилласан. Энэ онд нүүрс худалдах, худалдан авах гэрээнүүдийн дагуу компанийн дансанд 421 сая ам.долларын мөнгөн орлого төвлөрүүлснээс 142.5 сая ам.долларыг Чалко Трейдинг Хонгконг компаниас, үлдсэн 278.5 сая ам.долларыг бусад худалдан авагч компаниас төвлөрүүлсэн.

Нийт төвлөрүүлсэн орлогын хувьд 1-6 сард 111.6 сая ам.доллар буюу 27%-ийг (Үүнд ЭТТМ компани 75.7 сая ам.долларын орлогыг эхний 5 сард төвлөрүүлсэн), 7-12 сард нийт орлогын 73% буюу 309.4 сая ам.долларын орлогыг төвлөрүүлж, борлуулалтын орлогоос Тавантолгой ордыг хөгжүүлэх болон нийгмийн хариуцлагын хүрээнд хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрүүдийг санхүүжүүлэх боломжийг бүрдүүлсэн.

ҮНИЙН МЭДЭЭЛЭЛ:




Эх сурвалж: sxcoal.com, metalbulletin.com, [Platts reports](http://Platts.com)

БНХАУ дахь нүүрс, кокс боловсруулах үйлдвэрийн тэлэлт, барилга, дэд бүтцийн салбарын бүтээн байгуулалтын бууралт зэрэг хүчин зүйлсийн нөлөөллөөр төмрийн ирээдүйн хэрэглээ багассан нь 2017-2018 онуудад нүүрсний эрэлт нийлүүлэлтийн харьцаанд сөргөөр нөлөөлж 2019 оны эхний улирлаас эхлэн коксжих нүүрсний үнэ 190 ам.доллараас 136 ам.доллар хүртэл, дунджаар 28 хувиар буурсан үзүүлэлттэй байсан. Оны эхэнд нүүрсний үнэд бага зэргийн сэргэлт ажиглагдаж байсан боловч давагдашгүй хүчин зүйлийн нөлөөллөөс /COVID-19/ шалтгаалж 2020 оны 11 дүгээр сар хүртэл үнийн бууралт үргэлжилсэн.


Харин 11 дүгээр сараас Австралийн нүүрсний экспортын хориг болон БНХАУ-ын коксын үйлдвэрүүд

улирлын чанартай нөөцөө бүрдүүлж эхэлснээс шалтгаалж үнэ өсөлт ажиглагдаж эхэлсэн.

Ганцмод боомтын үнийн хувьд олон улсын таваарын зах зээл дээрх коксжих нүүрсний үнийн уналтын нөлөөллөөр 2019 оны 7 дугаар сараас эрчимтэй унаж эхэлсэн ба түүхий коксжих нүүрсний дундаж үнэ 2019 оны оргил үеэсээ буюу 1050 юаниас 847 юань хүртэл дунджаар 19 хувиар унасан. Улмаар 2020 он гараад нүүрсний үнэд бага зэргийн сэргэлт ажиглагдаж байсан боловч давагдашгүй хүчин зүйлийн нөлөөллөөс /COVID-19/ шалтгаалж нүүрсний зах зээлд "Тодорхойгүй байдал" бий болсноос үүдэн үнэ эргээд бууралтын цикл рүүгээ шилжиж, 9 сард бууралтын доод хязгаарт хүрснээр 10 сарын сүүлээс аажим аажмаар өсөж эхэлсэн байдаг.



ЭТТ-"FCA-УУРХАЙН АМ" (КОКСЖИХ НҮҮРС)



Жич: Дээрх 2 графикт харуулсан ЭТТ болон Ганцмод боомтын үнийн өсөлт/бууралт нь сар бүр харилцан адилгүй байгаа нь Тавантолгой-Цагаанхад-Гашуунсухайт чиглэлийн тээврийн зардалтай шууд холбоотой юм. Манай компанийн нүүрсний үнэ нь Хятадын Ганцмод боомтын үнэ болон боомт хүртэл нүүрс тээвэрлэх тээврийн зардлаас ихээхэн хамаардаг.


2020 ОНД БАРИМТАЛСАН ҮНИЙН БОДЛОГО

Дэлхий дахинд тархаад буй Ковид-19 халдварын тархалттай холбоотойгоор Монгол Улс өндөржүүлсэн бэлэн байдал, бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт тус тус шилжсэнтэй холбоотой эхний 6 сарын борлуулалтын гүйцэтгэл маш бага байсан ба Ковид-19 халдварын нөлөөгөөр дэлхийн эдийн засаг, нүүрсний зах зээл, БНХАУ дахь нүүрсний зах зээлийн уналт үргэлжилсээр байсан тул Төлөөлөн Удирдах зөвлөлийн шийдвэр, Захирлуудын

зөвлөлийнхурлыншийдвэрзэргийгүндэслэнборлуулалтыг нэмэгдүүлэх, хэвийн тасралтгүй үргэлжлүүлэх чиглэлээр холбогдох арга хэмжээг авч ажилласан.


Олон улсын судалгааны Фенвэй компанийн www.sxcoal.com сайтын мэдээллээр БНХАУ нь 2020 онд нийт 72.6 сая тонн коксжих нүүрс импортолсон ба үүнээс 23.8 сая тонн буюу 33%-ийг Монгол Улсаас экспортолсон нүүрс эзэлж байна.

БНХАУ-ЫН КОКСЖИХ НҮҮРСНИЙ ИМПОРТ



Монгол Улсын хувьд сүүлийн 5 жилийн хугацаанд БНХАУ-ын коксжих нүүрсний импортын 40 орчим хувийг эзэлж байна.

БНХАУ-ЫН КОКСЖИХ НҮҮРСНИЙ ИМПОРТОД ЭЗЛЭХ ХУВЬ



Өнгөрсөн хугацаанд манай компани нь Монгол Улсын жилийн нийт экспортын 30-40%-ийг, БНХАУ-ын коксжих нүүрсний нийт импортын 10-20%-ийг дангаараа бүрдүүлэн ажиллаж, Монгол Улсын хамгийн том нүүрс экспортлогч компани болон өргөжсөн байна. Манай компани сүүлийн 5 жилийн нийлбэр үзүүлэлтээр БНХАУ-ын коксжих нүүрсний импортын 15%-ийг, Монгол Улсын коксжих нүүрсний экспортын 37%-ийг дангаараа бүрдүүлсэн байдаг ба 2020 оны хувьд БНХАУ-ын нийт коксжих нүүрсний импортын 12%-ийг, Монгол улсын нийт экспортын 38%-ийг дангаараа бүрдүүлсэн байна.

Огноо	БНХАУ нийт импорт	МУ-ын экспорт	ЭТТ-ийн экспорт	БНХАУ-ын нийт импортод эзлэх хувь%	МУ-ын нийт экспортод эзлэх хувь%
2016	59.31	23.56	7.45	13%	32%
2017	69.90	26.27	7.43	11%	28%
2018	65.32	27.68	11.71	18%	42%
2019	74.66	33.77	14.98	20%	44%
2020	72.56	23.77	9.00	12%	38%
Нийт	341.74	135.05	50.56	15%	37%


ТЭЭВЭР, ЛОГИСТИКИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

2020 онд 57 борлуулалтын гэрээний хүрээнд тээвэрлэлтийн хариуцлагын гэрээ байгуулсан 273 компанийн 8002 тээврийн хэрэгсэлд 12,828,264 тн (168,203 рейс хоногт дунджаар 35,146 тн нүүрсийг 461 тээврийн хэрэгсэлд) нүүрсийг ачиж экспортлох ажлыг

амжилттай хийж гүйцэтгэсэн.

Энэ хугацаанд компанийн зүгээс 1 тэрбум орчим төгрөгийн хучилтын төлбөрийн тооцоог барагдуулж нүүрс экспортыг тасалдуулахгүй, хэвийн тогтвортой байдлаар ханган ажилласан.

2020 ОНД НҮҮРС ТЭЭВЭРЛЭСЭН СТАТИСТИК



“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн нүүрсний тээвэрлэлт, экспортыг гүйцэтгэж буй 144 тээврийн компанийн 7865 тээврийн хэрэгсэлд 2020 оны I, II, III, IV дугаар улиралд “С” зөвшөөрөл олгуулах хүсэлтийг боловсруулж Авто Тээврийн Үндэсний Төв ТӨҮГ-д хүргүүлсэн.

“Гашуунсухайт авто зам” ХХК-тай хамтран замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангуулахаар зам тээврийн зөрчил гаргасан, маршрутын бус замаар тээвэр гүйцэтгэсэн 180 орчим тээврийн хэрэгслийг уурхайд орох эрхийг нь түр хязгаарлаж хариуцсан аж ахуйн нэгжид анхааруулж ажиллаж байна.

НҮҮРС ТЭЭВРИЙН ЦАХИМ ЦОНХ

“Эрдэнэс Тавантолгой” ХК шилэн компани зорилгын хүрээнд нүүрс тээврийн бүхий үйл ажиллагааг ил тод, нээлттэй болгож “Нүүрс тээврийн цахим цонх” цэсийг ажиллуулж мэдээллийг тогтмол шинэчлэл хийж ирсэн.

Дээрх цонхонд:

- ✓ Бүртгэлийн бүрдүүлэлт
- ✓ Нүүрс тээврийн гэрээ нь баталгаажсан компаниуд
- ✓ Тээврийн шилжилт хөдөлгөөн
- ✓ Улирлын “С” зөвшөөрөл хүссэн компаниуд
- ✓ “С” зөвшөөрөл авсан компаниуд
- ✓ Тээврийн хэрэгслийн зөрчлийн мэдээлэл
- ✓ Тээврийн хяналт
- ✓ Тээврийн зар
- ✓ Санал хүсэлт гэх мэт мэдээллийг тогтмол оруулж байна.

Мөн нүүрс тээврийн үйл ажиллагааг ил тод, нээлттэй болгох хүрээнд нүүрс тээврийн цахим цонхыг хариуцсан нэгж ажиллаж эхэлсэн бөгөөд нүүрс тээврийн бүхий үйл ажиллагаа, мэдээлэл, санал гомдлыг хүлээн авах боломжтой 24 цаг тасралтгүй ажилладаг 1800-1072/2/ лавлах утсыг ажиллуулж байна. 2020 оны 10 дугаар сарын 05-ны өдрөөс хойш нийтдээ 11,271 дуудлага хүлээж авчээ.



ИЛ ТОД-НЭЭЛТТЭЙ-ШУУРХАЙ-ШУУД ХАРИЛЦАХ
НҮҮРС ТЭЭВРИЙН ЦАХИМ ЦОНХ
1800-1072
 ЗНГИЙН УТАСНЫ ТАРИФААР

НҮҮРС АЧИЛТАНД ОРОХ ЭРХ НЭЭГДСЭН ЭСЭХ МЭДЭЭЛЭЛ
 ХҮСЭЛТ ӨГСӨН КОМПАНИУДИЙН БҮРТГЭЛ, МЭДЭЭЛЭЛ

НҮҮРС ТЭЭВРИЙН АЖ АХУЙН НЭГЖҮҮДИЙН ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛИЙН
 БҮРТГЭЛ НЭМЭГДСЭН, ХАСАГДСАН ТАЛААР МЭДЭЭЛЭЛ

ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛ, ЧИРГҮҮЛИЙН БҮРТГЭЛД ӨӨРЧЛӨЛТ ОРСОН
 ТАЛААРХИ МЭДЭЭ, МЭДЭЭЛЛИЙГ ТА ЦАГ АЛДАЛГҮЙ АВААРАЙ!



/1072 Хувьцаа
 мэдээллийн төв

www.ett.mn

ЗОГСОХ ЭРХГҮЙ



ТЭЭВЭРЛЭГЧ КОМПАНИ БОЛОН ЖОООЧ НАРТ ТЭЭВРИЙН
 ХЭРЭГСЛИЙН БҮРТГЭЛТЭЙ ХОЛБООТОЙ МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ,
 САНАЛ, ГОМДОЛ.

НҮҮРС ТЭЭВРИЙН ЖОООЧ НАРАА!
 КОРОНА ВИРУС БҮЮУ COVID-19-ИЙН
 ЭСРЭГ ХАЛДВАР ХАМГААЛЛАА САХИН БИЕЛҮҮЛШГЭЭ!



ГУРАВ. ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Эх орныхоо
Тусын Тулд

ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ ЭТТ


ЭДИЙН ЗАСАГ САНХҮҮГИЙН БАЙДАЛ

Дэлхий нийтээр тархаад буй Ковид-19 цар тахлын улмаас “Эрдэнэс Тавантолгой” ХК-ний нүүрсний экспорт 2020 оны эхний хагас жилд огцом буурсан ч Монгол, БНХАУ-ын хилийн боомтын “Ногоон гарц”-ыг хэрэгжүүлэх түр журмын үр нөлөөгөөр экспорт эрчимжиж борлуулалтын төлөвлөгөөг 111 хувиар биелүүлж ажилласан. Үүний үр дүнд 2020 онд нийт 1 их наяд 677.1 тэрбум төгрөгийн (“ЭТТ”

ХК-1 их наяд 547.7 тэрбум төгрөг, “ЭТТ Майнинг” ХХК-129.9 тэрбум төгрөг) борлуулалтын орлоготой ажиллаж, Улсын төсөвт 490.1 тэрбум төгрөгийн татвар (“ЭТТ” ХК-459.5 тэрбум төгрөг, “ЭТТ Майнинг” ХХК-30.6 тэрбум төгрөг), хураамжийг төвлөрүүлж, 149.4 тэрбум төгрөгийн (“ЭТТ” ХК нь 149.0 тэрбум төгрөг, “ЭТТ Майнинг” ХХК нь 0.4 тэрбум төгрөг) цэвэр ашигтай ажилласан байна.

ЦЭВЭР АШИГ /тэрбум төгрөг/

ТАТВАР ХУРААМЖ /тэрбум төгрөг/



Энэ онд төвлөрүүлсэн татвар хураамж болон цэвэр ашгийн дүн өмнөх оноос буурч байгаа гол шалтгаан нь БНХАУ-ын коксжих нүүрсний үнэ өмнөх оны дунджаас 14 хувиар буурч, Ковид-19 цар тахлаас үүдсэн экспортын тасалдлаас шууд хамаарч байна.

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ БОЛОН САНХҮҮЖИЛТ

Компанийн дунд хугацааны бизнес төлөвлөгөөнд тусгагдсан өрсөлдөх чадварыг дээшлүүлж, экспортыг нэмэгдүүлэн компанийн ашигт ажиллагааг өсгөх үндсэн зорилтын хүрээнд Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын төслүүдүүдээс гадна нийгмийн хариуцлагын хүрээнд Улаанбаатар хотын

агаарын бохирдлыг бууруулах сайжруулсан шахмал түлш үйлдвэрлэх “Тавантолгой түлш” ХХК-ийн шаардлагатай хөрөнгө оруулалтыг тус тус санхүүжүүлж байна. Мөн 2019 оны цэвэр ашгаас анх удаа хувьцаа эзэмшигч иргэд, аж ахуйн нэгжүүдэд 179.8 тэрбум төгрөгийн ногдол ашгийг бэлэн мөнгөөр олгосон.

Хөрөнгө оруулалт болон санхүүжилт

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2018	2019	2020	НИЙТ
Тавантолгой-Зүүнбаян төмөр зам	тэрбум	-	357.0	526.0	883.0
Тавантолгой-Гашуунсухайт төмөр зам	тэрбум	-	308.9	732.9	1,041.8
"Тавантолгой Түлш" ХХК	тэрбум	18.6	111.8	138.7	269.1
Хөрөнгө оруулалт	тэрбум	20.2	12.0	31.3	63.4
Ногдол ашиг	тэрбум			179.8	179.8
Нийт	тэрбум	38.8	789.6	1,608.7	2,437.1

2020 онд **1.6 их наяд** төгрөгийн хөрөнгө оруулалт болон санхүүжилтийг хийж 2018-2020 оны өссөн дүнгээр **2.4 их наяд** төгрөгт хүрээд байна.

2020 онд Ковид цар тахлын улмаас экспорт өмнөх оноос эрс буурсан нь компанид санхүүгийн хүндрэлтэй

байдал, мөнгөн хөрөнгийн дутагдал бий болж үүнээс үүдэн Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замд олгосон санхүүжилтийн **212 тэрбум** төгрөгийг гадны эх үүсвэрээр буюу Хаан банкнаас **120 тэрбум** төгрөг, Голомт банкнаас **92 тэрбум** төгрөгийн зээлийг тус тус авч санхүүжүүлсэн. Энэ зээлийг оны эцэст бүрэн төлж барагдуулсан.

ХУДАЛДАН АВАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

“Эрдэнэс Тавантолгой” ХК нь Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор баталсан төсөвт үндэслэн **1 их наяд 51 тэрбум** төгрөгийн Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж, Төсвийн ерөнхийлөн захирагчаар батлуулсан. Компанийн дотоод үйл ажиллагаатай холбоотой нийт 2 удаа тодотгосон байна. Үүнд:

-Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 06 дугаар сарын 04-ний өдрийн 28 дугаар тогтоолоор төсвийг бууруулан баталсныг үндэслэн **974.9 тэрбум** төгрөгөөр;

-Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 09 дүгээр сарын 14-ний өдрийн 37 дугаар тогтоолоор оруулсан төсвийн өөрчлөлтийг үндэслэн худалдан авалтын төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж, **978.3 тэрбум** төгрөгөөр батлуулсан.

Үүнээс **927.9 тэрбум** төгрөгийн худалдан авалтыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийг үндэслэн зохион байгуулж ажилласан байна. Төлөвлөгөөний биелэлт 94,8% хувьтай.

Худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний төрөл	Тоо	Худалдан авалтын дүн /мян төг/
Нээлттэй тендер шалгаруулалтын аргаар	32	108,975,705.69
Харьцуулалтын тендер шалгаруулалтын аргаар	22	601,011.92
Зөвлөхийн тендер шалгаруулалтаар	7	3,661,434.29
Гэрээ шууд байгуулах аргаар	15	814,697,322.6
Шууд худалдан авалт	128	532,933.64
Ерөнхий гэрээ	20	514,736.03
Нийт		928,983.14

Өнөөдрийн байдлаар нийт 45 Үнэлгээний хороо байгуулагдан тендер шалгаруулалтыг ТБОНӨХБАҮХАТХ-ийн дагуу цахим хэлбэрээр зохион байгуулан ажиллаж байна. Компанийн Бараа, ажил, үйлчилгээ худалдан авах журмын дагуу гэрээ шууд байгуулах үүрэг бүхий нэг “Ажлын хэсэг” байгуулагдан ажиллаж байна.

Дотоодын үйлдвэрээс худалдан авах чанар стандартын шаардлага хангасан, тохирлын баталгаатай барааны жагсаалт"-д багтсан бараа, бүтээгдэхүүнийг худалдан авч, дотоодын үйлдвэрлэлийг дэмжих тухай Монгол улсын Засгийн газрын тогтоолыг хэрэгжүүлж ажиллаж байна. 2020

онд нийт **2,406,377.42** мянган төгрөгийн барааг дотоодын аж ахуйн нэгжээс худалдан авсан байна.

Худалдан авах ажиллагааны цахим системээр зарласан тендер шалгаруулалтын тоо нийт тендер шалгаруулалтын 84.2% буюу 64 байна. 15 төслийн тендер шалгаруулалт амжилтгүй болсон тул Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлд зааснаар гэрээ шууд байгуулсан ба мөн хуулийн 34.3-т зааснаар гэрээ шууд байгуулах аргыг хэрэглэх болсон үндэслэлийг Монгол улсын Сангийн яаманд хүргүүлэн ажиллалаа.

ДААТГАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Компанид учирч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, учирсан хохирлыг даатгалын компаниар нөхөн төлүүлэх замаар үр ашиггүй зардлыг бууруулж, компани, компанийн ажилтнуудыг эрсдэлээс хамгаалах зорилгоор 8 төрлийн даатгалын үйлчилгээ авахаар даатгалын компаниудтай хамтран ажиллах гэрээг байгуулан ажиллаж байна.

Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний дагуу 2020 онд даатгалын үйлчилгээ үзүүлэгчийг сонгон шалгаруулах тендерийг нэгтгэн зарлаж, тендерийн үнэлгээг хийн даатгалын компанийг шалгаруулсан.

КОМПАНИЙН ХАМРАГДСАН ДААТГАЛЫН ТӨРЛҮҮД

- ✓ Жолоочийн албан журмын хариуцлага
- ✓ Хөрөнгө
- ✓ Ачаа тээвэр
- ✓ Эмчилгээний зардал
- ✓ Гэнэтийн осол
- ✓ Ажил олгогчийн хариуцлага
- ✓ Уул уурхайн хүнд машин механизмын даатгал
- ✓ Тээврийн хэрэгсэл, жолоочийн нэмэлт хариуцлагын даатгал



**ДӨРӨВ.
КОМПАНИЙН ЗАХИРГАА, ХҮНИЙ
НӨӨЦИЙН БОДЛОГО, ОЛОН НИЙТТЭЙ
ХАРИЛЦАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА**



ЗАХИРГАА, УДИРДЛАГА

Компанийн Гүйцэтгэх удирдлага нь компанийн дүрэм болон Төлөөлөн удирдах зөвлөлтэй байгуулсан гэрээнд заасан эрх хэмжээний хүрээнд компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулж ирлээ.

Компанийн үйл ажиллагааны төлөвлөгөөг Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн 2017-2020 оны Бизнес төлөвлөгөө, хөтөлбөрийн хүрээнд дэвшүүлсэн зорилттой уялдуулан компанийн төсөв, хөрөнгийн эх үүсвэрийн боломжид тулгуурлан үндсэн үйлдвэрлэл, уулын ажил, геологи хайгуул, маркетинг, борлуулалт, худалдан авах ажиллагаа, стратеги төлөвлөлт, хувьцаа, эдийн засаг, санхүү бүртгэл, дэд бүтэц, төсөл хөтөлбөр, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, байгаль орчин, компанийн засаглалыг сайжруулах зэрэг 30 зорилтын хүрээнд 127 ажил, арга хэмжээг төлөвлөн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны 66 дугаар тогтоолоор батлуулсан.

Монгол Улсын Их хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолоор Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг баталсан, дэлхий даяар тархсан COVID-19 цар тахлын улмаас Компанийн 2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан 12 арга хэмжээ хугацаандаа хэрэгжих боломжгүй болсон, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 27 дугаар тогтоолоор “Эрдэнэс Тавантолгой Майнинг” ХХК-ийг “Эрдэнэс Тавантолгой” ХК-д нэгтгэсэн зэрэг шалтгааны улмаас “Компанийн 2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөө”-г 28 үндсэн зорилтын хүрээнд 128 арга хэмжээг хэрэгжүүлэхээр шинэчлэн боловсруулж Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 09 дүгээр сарын 14-ний өдрийн 37 дугаар тогтоолоор батлуулсан.

Компанийн 2020 оны үйл ажиллагааны шинэчилсэн төлөвлөгөөнд “Эрдэнэс Тавантолгой Майнинг” ХХК-ийг нэгтгэсэнтэй холбогдуулан Цанхийн зүүн уурхайд олборлолт явуулах, ашиглалтын үйл ажиллагааны төлөвлөгөө, тайланг боловсруулах, Компанийн хэрэгжүүлж буй Тавантолгой-Зүүнбаян, Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр зам, авто зам, Нүүрс

баяжуулах үйлдвэр, Ус хангамжийн төсөл, нүүрс ачилтын нэгдсэн төв зэрэг төслийн ажлуудыг эрчимжүүлэх, хэрэгжүүлэх, санхүүжилтийг шийдвэрлэх арга хэмжээг тусгасан. Эдгээр 28 үндсэн зорилтын хүрээнд гүйцэтгэх 128 арга хэмжээ тус бүрийн биелэлтийг ханган ажилласан бөгөөд төлөвлөгөөний хэрэгжилт дунджаар 94 хувьтай байна. Компанийн үйл ажиллагааны 2020 оны тайлан, төлөвлөгөөний хэрэгжилтийг улирал, жилээр гарган УУХҮЯ-нд хүргүүлж, 2020 оны жилийн эцсийн тайланг Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж дүгнүүлсэн.

Компанийн үйл ажиллагааг хэвийн тогтвортой явуулах, ажлын хариуцлага, сахилга батыг сайжруулах ажлын хүрээнд Гүйцэтгэх захирлын 1476 тушаалыг албажуулан гаргасан бөгөөд үйл ажиллагаатай холбоотой 359 тушаал, боловсон хүчинтэй холбоотой 1117 тушаал гаргасан.

Удирдлага, ажилтны дотоод томилолтын зохион байгуулалт, хэрэгжилтийн хүрээнд нийт 182 дотоод томилолтын удирдамж, давхардсан тоогоор 327 ажилтнуудын үнэмлэхийг бичиж баталгаажуулан ажилласан.

2020 онд нийт 3735 албан бичиг, 721 өргөдөл гомдол хүлээн авсан бөгөөд хугацаанд нь шийдвэрлэж хариу өгчээ. “Эрдэнэс Тавантолгой” ХК-аас 2020 онд нийт 2988 албан бичгийг стандартын дагуу албажуулан зохих байгууллагад нь хүргүүлэв.

Компанийн архивд түр хадгалах хадгаламжийн 4956, Байнга хадгалах хадгаламжийн 1976, 70 жил хадгалах хадгаламжийн 259, Дүрс бичлэгийн баримт буюу тусгай төрлийн баримтын 448, Устгах хэргийн актын 854, Геологийн 299 баримтуудын данс бүртгэлээр нийт 8792 хадгаламжийн нэгж хадгалагдаж байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн хурал зохион байгуулахад дэмжлэг үзүүлж хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалтыг гарган, нэгжүүдийн хэлэлцэх асуудлуудын материал, танилцуулгыг бэлтгэн хүргүүлж Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоолын хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр гарган ТУЗ-ийн ажлын албанд хүргүүлэн ажиллалаа.

ДЭЭД ГАЗРЫН ТОГТООЛ ШИЙДВЭР, ДҮРЭМ, ЖУРМЫН ХЭРЭГЖИЛТ

“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн үйл ажиллагаатай холбоотой гарсан УИХ-ын тогтоол, УИХ-ын байнгын хорооны тогтоол, Ерөнхийлөгчийн захирамж, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж, Засгийн газрын тогтоол, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл, Засгийн газрын албан даалгавар нийт 47 шийдвэрийн хэрэгжилтийг ханган, биелэлтийг улирал, хагас жилээр гарган, Засгийн газрын хэрэг эрхлэх газар, Уул уурхай хүнд

үйлдвэрийн яам, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар тайлагнаж, төр засгийн шийдвэрийг цаг хугацаанд нь бүрэн хэрэгжүүлэн ажиллаж байна.

Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 онд батлан гаргасан 50 тогтоолын хэрэгжилт, хурлаас өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг хагас, бүтэн жилийн байдлаар гарган ТУЗ-ийн ажлын албанд хүргүүлсэн.

ХУУЛЬ, ЭРХЗҮЙ

Компанийн ашигт ажиллагааг нэмэгдүүлэх, компанийн засаглалыг сайжруулах зорилгоор Эрсдэлийн удирдлагын бодлогын баримт бичиг, Хүний нөөцийн бодлогын баримт бичиг, Хэвлэл мэдээлэл, олон нийтийн чиглэлээр баримтлах бодлогын баримт бичгийг тус тус боловсруулан, батлуулж ажиллалаа.

Хөдөлмөрийн аюулгүй байдлыг нэмэгдүүлэх зорилгоор “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм”, Компанид учирч болзошгүй эрсдэлийг бууруулах, даван туулах харилцааг зохицуулах зорилгоор “Эрсдэлийн удирдлагын журам”, компанийн хөрөнгийг үр ашигтай зарцуулах зорилгоор “Дуудлага худалдааны журам”, COVID-19 коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор улс орон даяар өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан “Эрдэнэс Тавантолгой ХК-ийн өндөржүүлсэн бэлэн байдалд ажиллах түр журам”-ыг тус тус шинээр боловсруулан батлуулсан бөгөөд компанийн хэмжээнд 1 журам хүчингүй

болж, 2 журам шинээр баталж, 13 журамд нэмэлт, өөрчлөлт оруулан шинэчиллээ.

Гэрээний нэгдсэн бүртгэл, бүртгэлийн цахим сан үүсгэн ажиллаж байгаа бөгөөд компанийн хэмжээнд 2020 оны жилийн эцсийн байдлаар иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудтай байгуулсан нийт 737 гэрээ, 217 гэрээний нэмэлт өөрчлөлт, 162 гэрээ дүгнэсэн актыг хянаж, баталгаажуулан гэрээний нэгдсэн бүртгэлд бүртгэсэн байна. Гэрээний журмын дагуу гэрээний талаарх мэдээлэл лавлагааг 26 албан тушаалтанд олгосон. “Гэрээ, санамж бичгийн журам”-ыг шинэчлэн боловсруулж байна.

Компанийн үйл ажиллагаатай холбоотой үүссэн иргэний 19, захиргааны 8 хэрэг, Авлигатай тэмцэх газар, цагдаагийн байгууллагад шалгагдсан 11 гомдол, нийт хэрэг 38 маргаанд компанийг төлөөлөн ажилласан бөгөөд тайлант хугацаанд эрүү, иргэн, захиргааны 64 удаагийн шүүх хуралд оролцсон. АТГ-ын эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд 3 удаа оролцсон.

ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЭЛ, ОЛОН НИЙТИЙН ХАРИЛЦАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Компанийн зүгээс 2020 онд “Сайн мэдээний уурхай”, “Эерэг дүр” хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхийн зэрэгцээ компанийн танилцуулга материал бэлтгэх, ЕТТ нэгдсэн бүртгэлийн систем нэвтрүүлэх, компанийн 10 жилийн ойг угтсан арга хэмжээ зохион байгуулах, компанийн нийгмийн сүлжээгээр түгээж буй мэдээлэл, сурталчилгааны ажлыг эрчимжүүлэх, хандалтын тоог нэмэгдүүлэх чиглэлээр ажиллалаа.

Компанийн үйл ажиллагааны талаарх мэдээ мэдээллийг хэвлэл мэдээллийн байгууллагуудаар тогтмол түгээн ажиллаж байна. Компанийн албан ёсны веб сайтад

нийт 132 мэдээ, сурвалжилга нийтэлсэн бөгөөд эдгээр мэдээлүүдийг давхардсан тоогоор 100 орчим хэвлэл мэдээллийн байгууллагаар түгээжээ.

Тайлант хугацаанд нийт 15 удаа хэвлэлийн бага хурал зохион байгуулав. Давхардсан тоогоор 200 орчим хэвлэлийн байгууллага ирж сурвалжилсан бөгөөд мэдээлэл нь 1000 гаруй удаа хэвлэл мэдээллийн байгууллагаар цацагдсан.

Компанийн албан ёсны веб сайтад 313 тендерийн урилга нийтэлсэн бөгөөд зах зээлийн 21 мэдээ, ажлын байрны зар зэргийг нийтлэв.

1072 ХУВЬЦАА МЭДЭЭЛЛИЙН ТӨВ

“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн шийдвэрийн дагуу хувьцаа эзэмшигч иргэддээ ногдол ашиг олгох болсон үүнтэй холбогдуулан “ҮЦТХТ” ХХК “Ногдол ашиг зуучлан хуваарилах” ЭТТ-2020/136 тоот гэрээний дагуу 2020 оны 09 дүгээр сарын 03 -ны өдрүүдэд хувьцаа эзэмшигч иргэдийн дансанд ногдол ашиг шилжиж эхэлсэн бөгөөд 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар нийт 2,014,287 иргэн ногдол ашгаа авсан байна.

Компанийн зүгээс брокерын компаниудтай хамтран ажиллах гэрээ байгуулан ЕТТ нэгдсэн бүртгэлийн системд 25 брокерын компани холбогдон цахим хэлбэрээр хувьцааны данс нээх ажлыг зохион байгууллаа. ЭТТ-2020/323 дугаартай хамтын ажиллагааны гэрээний дагуу “Төрийн банк”-тай хамтран ЕТТ нэгдсэн бүртгэлийн системд “Qpay”, үйлчилгээг нэвтрүүлснээр иргэд төлбөр төлөхөд илүү хялбар болсон. ЕТТ системийг 2019 оны 12 сард Play Store, AppStore байрлуулснаас хойш 2020 оны гуравдугаар улирлын байдлаар нийт 336'239 мянга хэрэглэгч татаж авсан бөгөөд нийтдээ 25 брокерын компани ЕТТ нэгдсэн бүртгэлийн системээр дамжуулан данс нээж байна.

Хувьцаа эзэмшигч иргэдийн 1072 хувьцаанаас хасаж

тооцуулсан иргэдийн гаргасан өргөдөл, хүсэлт зэрэг анхан шатны баримтыг цахимжуулж 2020 оны 09 сарын 28-ны байдлаар 104'386 орчим материалыг системд нэгтгэсэн.

Нийт 2'512'768 иргэн “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцаа эзэмшиж байгаагаас 2020 оны байдлаар давхардсан тоогоор 1'850'000 орчим иргэн хувьцааны дансаа нээлгэжээ.

Мөн Үндэсний дата төвтэй хамтран ЭТТ-2020/310 дугаартай Төрийн мэдээлэл солилцооны систем ашиглах гэрээ, ЭТТ-2020/506 дугаартай Төрийн үйлчилгээний цахим машинаар үйлчилгээ үзүүлэх гэрээг байгууллаа. Энэ гэрээг байгуулснаар иргэд Төрийн үйлчилгээний цахим “ТҮЦ” машинаар “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн 1072 ширхэг хувьцаа ба түүний өөрчлөлтэй холбоотой лавлагаа авах, үнэт цаасны данс нээх үйлчилгээний хүсэлт илгээх гэх мэт үйлчилгээг авах боломжтой болж байна.




2020 оны 01 сард 1072 Мэдээллийн албанаас 4 удаа 1072 хувьцаа, хөрөнгийн зах зээлийн суурь ойлголт өгөх сургалтыг зохион байгуулсан. Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэнээс хойш олон нийтийг хамруулсан сургалт, уулзалт зохион байгуулаагүй.



ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГО, СУРГАЛТ ХӨГЖИЛ

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 5-р сарын 28-ны өдрийн 27 тоот тогтоолоор компанийн орон тооны хязгаарыг 986 /оффис-271, уурхай- 676/ болгон шинэчлэн баталсан. 2020 оны жилийн эцсийн байдлаар нийт 911 ажилтантайгаар үйл ажиллагаагаа явуулж байна.

Компанийн нийт ажилтны судалгааг доорх ангиллаар харуулбал:



СУРГАЛТ, ХӨГЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

2020 онд 34 төрлийн сургалтыг санаачлан нийт 1008 ажилтныг чиглүүлэх, дадлагажуулах, хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлийн сургалтад амжилттай хамруулж, сургалтын үйл ажиллагааны төсвөөс нийт 92 сая төгрөгийг зарцуулсан байна. Ковид-19 цар тахлын халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор өндөржүүлсэн бэлэн

байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан олон нийтийн арга хэмжээ зохион байгуулахыг хориглосон тул ажилчдыг шагнаж урамшуулах, сургалтад хамруулах ажлыг 2020 оны 02 дугаар сараас хойш зохион байгуулаагүй. Энэ хугацаанд ажилтнуудыг 3 төрлийн цахим сургалтад хамруулжээ.

ХҮНИЙ НӨӨЦИЙН БҮРДҮҮЛЭЛТ, СОНГОН ШАЛГАРУУЛАЛТ

Компанийн хэмжээнд сул орон тоог дотоод нөөц бололцоог ашиглан шийдвэрлэх ажлын хүрээнд удирдлагын санал болон ажилтны хүсэлтийн дагуу 37 ажилтныг дэвшүүлэн, 107 ажилтныг шилжүүлэн ажиллуулсан байна. Мөн ажил үүргийн давхардал, зохион байгуулалтын шинэчилсэн бүтцээр орон тоо хасагдсан ажилтнуудад ажлын байрны саналыг хүргүүлснээр 30 ажилтны албан тушаал, цалингийн шатлалыг бууруулсан.

Гүйцэтгэх захирлын 2019 оны 03 дугаар сарын 29-ны өдрийн А/166 тоот “Ажилтан сонгон шалгаруулах” журмын

дагуу Төв оффист 39, салбарт 25 нийт 64 ажлын байран дээр нээлттэй болон нөөцөөс нөхөх сонгон шалгаруулалтыг явуулж ажилд томилжээ.

Нээлттэй сонгон шалгаруулалтын зарыг компанийн веб сайтад байршуулан, ирсэн анкетуудаас шаардлага хангасан ажил горилогчоос шалгалт аван, шалгалтад тэнцсэн ажил горилогчтой ярилцлага хийж дүгнэсэн бөгөөд нээлттэй сонгон шалгаруулалтаар Мэдээллийн технологийн хэлтэст 1 мэргэжилтэн, Барилга, дэд бүтцийн хэлтэст 3 мэргэжилтэн нийт 4 ажилтан сонгон шалгаруулж ажилд томилогдсон.

ЦАЛИН, УРАМШУУЛАЛ, ТУСЛАМЖ, ТЭТГЭМЖ

Компанийн Гүйцэтгэх захирлын 2020 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн “Ажилтнуудын үндсэн цалинг нэмэгдүүлж, цалингийн сүлжээг шинэчлэн тогтоох тухай” А/173 дугаар тушаалаар компанийн ахлах мэргэжилтэн болон түүнээс доош албан тушаалтай ажилтнуудын үндсэн цалинг 20 хувь нэмэгдүүлсэн бөгөөд ингэснээр “Эрдэнэс Тавантолгой” ХК дундаж цалингийн үзүүлэлтээр Монгол Улсдаа тэргүүлэх боллоо.

“Ажилтанд цалин хөлс тооцож олгох журам”-ын дагуу компанид 36 сар ажилласан Салбарын 18, төв оффисын 2, нийт 20 ажилтны үндсэн цалинг II шатлал руу Хөдөлмөрийн гэрээний нэмэлт байгуулан шилжүүлэв. Мөн Гүйцэтгэх захирлын 2020 оны 9 дүгээр сарын 21-ний өдрийн “Зарим ажилтны цалингийн шатлалыг өөрчлөх тогтоох тухай” Б/814 дүгээр тушаалын дагуу төв оффисын 7, салбарын 27, нийт 34 ажилтны үндсэн цалинг цалингийн сүлжээний III шатлалаар нэмэгдүүлэн тогтоов.

Гүйцэтгэх захирлын 2020 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн А/346 дугаар тушаалаар компанийн хөдөлмөрийн

гэрээгээр ажиллаж буй үндсэн 897 ажилтанд 2020 оны 13 дахь сарын шагналт цалинг 2020 онд ажилласан сард ногдуулан олгосон.

Нийт ажилтнуудад 4-6 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний үр дүнгийн урамшууллыг олгосон нь цар тахлын хүнд хэцүү үед ажилтан, албан хаагчдаа дэмжсэн үйл ажиллагаа боллоо.

Нийт 12 ажилтанд ажил албан тушаал хавсарсны болон ажлын байранд заагаагүй ажил үүргийг гүйцэтгэсний нэмэгдлийг үндсэн цалингийн 10-40 хувиар, 491 ажилтанд удаан жилийн нэмэгдлийг үндсэн цалингийн 5-15 хувиар, 10 ажилтанд зөвлөх болон мэргэшсэн зэргийн нэмэгдлийг үндсэн цалингийн 8-10 хувиар тус тус журмын дагуу тооцон олгож байна.

Нийт 180 ажилтанд 926,502,863 төгрөгийн тусламж, дэмжлэг, тэтгэмж, хөнгөлөлт, олговрыг “Ажилтанд тусламж, тэтгэмж, нөхөн төлбөр, дэмжлэг олгох журам” болон Үйлдвэрчний эвлэлтэй байгуулсан Хамтын гэрээний хүрээнд олгож ажилтны нийгмийн асуудлыг шийдвэрлэв.

САХИЛГА, ХАРИУЦЛАГА

2020 оныг Гүйцэтгэх захирлын тушаалаар “Сахилга, хариуцлагын жил болгон зарласантай” холбоотойгоор компанид мөрдөж буй хууль тогтоомж, дүрэм, журам зөрчсөн, зөрчил дутагдал гаргасан, ажлаа цалгардуулсан ажилтан, албан тушаалтанд холбогдох хуулийн дагуу тухай бүр хариуцлага тооцож ажиллалаа. 2020 онд 61 ажилтанд сахилгын арга хэмжээ авснаас 45 ажилтанд сануулах, 12 ажилтанд цалингийн хувь хасах, 4 ажилтныг ажлаас халах арга хэмжээ тус тус авсан байна.

Мөн Гүйцэтгэх захирлын тушаалаар сахилгын арга хэмжээ ногдуулахаас гадна Хөдөлмөрийн хууль, байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын дагуу 120 минутаас доош хоцролттой төв оффисын 65 ажилтанд “Анхааруулах хуудас” хүргүүлсэн ба ажилтнуудын ажлын цаг ашиглалт, ажлын бүтээмжийг сайжруулах, үүрэгт ажлаа чанартай, үр дүнтэй хийж гүйцэтгэх талаар холбогдох танилцуулга, мэдээлэл, дүрэм, журмыг тогтмол цахимаар хүргүүлэн ажиллав.

АЖИЛЧДЫН НИЙГМИЙН ХАМГААЛАЛ

Компанийн ажилтнуудыг төрөөс хэрэгжүүлж буй орон сууцны хөнгөлөлттэй зээлд хамруулахад тавигдах шаардлагыг Гүйцэтгэх захирлын тушаалаар баталж Голомт банканд 17 албан бичгээр 42 ажилтны нэрсийг хүргүүлсэн бөгөөд шаардлага хангасан 30 ажилтны зээлийг шийдвэрлэсэн байна.

“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн нийгмийн хариуцлагыг хэрэгжүүлэх, ажилтнуудын нийгмийн

асуудлыг шийдвэрлэх зорилгоор Чингэлтэй дүүргийн Засаг даргын тамгын газартай санамж бичиг байгуулан хамтран ажиллаж байгаа бөгөөд Чингэлтэй дүүргийн Улсын тэргүүний 33 дугаар цэцэрлэгт 124 сая төгрөгийн хөрөнгө оруулалтыг хийсэн. Санамж бичгийн хүрээнд 2020 онд компанийн ажилчдын нийт 36 хүүхдийг сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэхээр хамруулсан.



МЭДЭЭЛЭЛ ТЕХНОЛОГИ

“Эрдэнэс Тавантолгой” ХК үйл ажиллагаандаа орчин үеийн дэвшилтэт техник технологи, мэдээллийн технологийн ололтуудыг нэвтрүүлэх талаар анхаарал хандуулан ажиллаж байна. Компанийн салбар уурхайд 2018-2020 онд тоон радио станц нэвтрүүлэх ажил үе шаттайгаар хэрэгжиж байгаа бөгөөд Цанхийн зүүн уурхайн хэмжээнд тоон радио станцыг бүрэн нэвтрүүлж дууссан. Цаашид Цанхийн баруун уурхай, Бортээгийн хэсэгт тоон радио станцыг нэвтрүүлэхээр ажиллаж байна.

Нүүрс ачилт, тээвэрлэлтийн үйл ажиллагааг цахимжуулах зорилгоор уурхайн Гаалийн хяналтын бүсээр нэвтэрч байгаа тээврийн машинуудын үйл ажиллагааг

сайжруулах тээврийн машинуудад хяналт тавих дугаар таних хяналтын камер, RFID таг уншигч программ хангамж гэх мэт системүүдийг уялдуулах программ хангамжийн ажлууд хийж байна.

Ажилтнуудыг ажиллах нөхцөл бололцоог хангах, файлын хадгалалт хамгаалалт нууцлалыг сайжруулах ажлын хүрээнд албан ёсны эрхтэй Office 365 программын нэвтрүүлэлтийг бүрэн хийж дууссан.

Компанийн мэдээллийн аюулгүй байдлыг сайжруулах зорилгоор Мэдээллийн аюулгүй байдлын бодлогын баримт бичгийг батлуулж, үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.

ERP СИСТЕМ

Нийт 17 модуль бүхий бүхий ERP систем нэвтрүүлэх төлөвлөгөөг “Woovoo technologies” ХХК-аас гарган хамтран ажиллаж байна. Сервер тоног төхөөрөмжүүдийн судалгаа хийгдсэн. Систем нэвтрүүлэх ажил 2021 онд үргэлжлэн хийгдэж байна.

ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХӨГЖҮҮЛЭГДЭХ СИСТЕМҮҮД

1. Санхүүгийн удирдлагын систем

2. Уул уурхайн удирдлагын систем

- ✓ Уулын төлөвлөлт
- ✓ Уулын ашиглалт
- ✓ Геологи
- ✓ ХАБЭА
- ✓ Байгаль орчин
- ✓ Диспетчир бүртгэл

3. Төсөв, төлөвлөлтийн удирдлагын систем

4. Санхүүгийн шинжилгээ

5. Ханган нийлүүлэлтийн удирдлагын систем

6. Сонгон шалгаруулалтын удирдлагын систем

7. Хүний нөөцийн удирдлагын систем

8. Цалингийн удирдлагын систем

9. Цаг бүртгэлийн удирдлагын систем

10. Төслийн удирдлагын систем

11. Гэрээний удирдлагын систем



12. Эрсдэлийн удирдлагын систем

13. Баримт бичгийн удирдлагын систем

14. Ажил үүргийн удирдлагын систем


15. Борлуулалтын удирдлагын систем

- ✓ Тээвэр, логистик
- ✓ Нүүрс ачилт, логистик

16. “Засвар үйлчилгээ, механик”-ийн модулийг нэмэлтээр хөгжүүлэхээр ажиллаж байна.

КАМЕРЖУУЛАЛТ

Цанхи хотхоны бүсэд сүүлийн үеийн өндөр нягтрал бүхий IP камеруудыг байрлуулж шилэн кабелиар холбож бүрэн ажиллагаанд оруулсан.



ДУГААР ТАНИХ КАМЕР БҮХИЙ НЭВТРЭХ СИСТЕМ

Сүүлийн үеийн технологийн дэвшлийг ашигласан дугаар таних камер бүхий автомат нэвтрэх системийг уурхайн руу нэвтрэх постны нэвтрэх хэсэгт угсарч суурилуулан бүрэн ажиллагаанд оруулсан.



ТООН РАДИО СТАНЦ НЭВТҮҮЛЭЛТ



Уурхайн бүсэд Тоон радио станц нэвтрүүлэх ажлын хэсэг байгуулагдан ажилласан. Уг ажлын хүрээнд уурхайн овоолгын цамхгийн байранд тоон технологийн дэд станцуудыг байрлуулан угсралт хийж туршилт хийсэн. Мөн тоон технологийн удирдлагын программыг суулган тохиргоо хийсэн. Тоон технологийн суурин болон гар станцуудад тохиргоо хийж шаардлагатай хүмүүст хуваарилсан. Оффисын хажууд байрлах диспетчерийн өрөөнд Site 2-г угсарч, харгалзах лиценз болон тохиргоог хийлээ.



ТАВ. ХАМТЫН АЖИЛЛАГАА, НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА

“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн “Нийгмийн хариуцлагыг хэрэгжүүлэх бодлогын баримт бичиг”-ийг баталж хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Уг бодлогын баримт бичиг батлагдсанаар нийгмийн хариуцлагын чиглэлээр зохион байгуулах ажил арга хэмжээний чиглэлийг тодорхойлж, үр ашгийг дээшлүүлэх ач холбогдолтой юм.

ХАМТЫН АЖИЛЛАГАА, САНАМЖ БИЧИГ

“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьд 2020 онд 2 байгууллагатай шинээр хамтран ажиллах санамж бичиг байгуулсан байна. Тухайлбал:

“Эрдэнэс Тавантолгой” ХК Монголын хуульчдын холбоотой хамтран ажиллах санамж бичгийг 2020 оны 04 дүгээр сарын 08-ны өдөр байгуулж, Монголын хуульчдын холбоо “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн ажилчдын хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, компанийн засаглалыг хөгжүүлэх болон дүрэм журмын төсөл боловсруулах талаар зөвлөмж өгөх, салбар эрх зүйн чиглэлээр сургалт,

судалгааны ажил, зөвлөх үйлчилгээ, олон улсын болон дотоодын хурал, зөвлөгөөн, бусад арга хэмжээг зохион байгуулах чиглэлээр хамтран ажиллаж байна.

Монголын Үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимын 60 жилийн ой, “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн 10 жилийн ой тохиож байгаатай холбогдуулан хамтран ажиллах санамж бичгийг 2020 оны 09 дүгээр сарын 21-ний өдөр байгууллаа. Энэхүү санамж бичгийн хүрээнд Монгол Улсын 2020 оны ТОП-50 аж ахуй нэгжийн удирдлагууд, компанийн хувьцаа эзэмшигч аж ахуй нэгжүүдийн удирдлагуудыг оролцуулсан “ЭТТ бизнес форум”-ыг зохион байгуулахаар боллоо.

НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА

“Эрдэнэс Тавантолгой” ХК нийгмийн хариуцлагын хүрээнд олон төрлийн төсөл хөтөлбөрийг дэмжин хэрэгжүүлж байна.

Үүнээс дурдвал:

Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах зорилгоор “Тавантолгой түлш” ХХК-2018 оноос дэмжлэг үзүүлэн ажиллаж байгаа бөгөөд 2020 онд 138.725 тэрбум төгрөгийн санхүүжилтийг “Тавантолгой түлш” ХХК-д шилжүүлж Баруун, Зүүн бүсийн сайжруулсан

түлшний үйлдвэр байгуулах, тоног төхөөрөмж худалдан авахад зарцуулжээ. Түүнчлэн Ковид-19 цар тахлын үед ард иргэдийн амьдралд дэмжлэг үзүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газрын шийдвэрээр “Тавантолгой түлш” ХК-ийн сайжруулсан шахмал түлшний үнийг 75 хувиар хөнгөлсөн. Уг хөнгөлөлтийн зардлыг “Эрдэнэс Тавантолгой” ХК хариуцан 128 тэрбум төгрөгийн нэмэлт санхүүжилтийг хийгээд байна.



“Эрдэнэс Тавантолгой” ХК үүсэн байгуулагдсаны 10 жилийн ойг тохиолдуулан нийгмийн хариуцлагын хүрээнд Тавантолгой-Гашуун сухайт чиглэлийн авто замаар нүүрс тээвэрлэж буй жолооч нарыг эрүүл мэндийн үзлэгт хамруулах ажлыг Эрүүл мэндийн яам, Улсын 1 дүгээр төв эмнэлэгтэй хамтран 2020 оны 10 дугаар сарын 19-ны өдрөөс 25-ны өдрүүдэд зохион байгууллаа. Уг эрүүл мэндийн үзлэгт нийтдээ 138 компанийн 1800 жолооч хамрагдсан байна.



“Эрдэнэс Тавантолгой” ХК нүүрс тээврийн жолооч нарын дунд коронавирусын халдвар тархахаас урьдчилан сэргийлэх зорилгоор Цагаан хад хилийн боомтод нүүрс тээврийн жолооч нарыг PCR шинжилгээнд хамруулах, дэг журам тогтоох ажлыг УОК-ын шийдвэрээр Дотоодын цэргийн 805 дугаар ангийн Штабын дарга Д.Энхбадрахаар ахлуулсан 50 цэрэг, Өмнөговь аймгийн ЭМН-ийн ЗУХ-ийн даргаар ахлуулсан Зооноз өвчин судлалын үндэсний төвийн 5 эмч, Ханбогд сумын 24 эмч нартай хамтран 2020 оны 11 дүгээр сарын 21-ний өдрөөс хойш зохион байгуулан ажиллалаа.

Энэ хугацаанд давхардсан тоогоор 14777 жолоочийг PCR шинжилгээнд хамруулж, нүүрсний экспортын хэвийн үргэлжлэх нөхцөлийг ханган ажиллав.



ОРОН НУТГИЙН ХАМТЫН АЖИЛЛАГАА



“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн орон нутаг дахь нийгмийн хариуцлагыг хэрэгжүүлэх, нутгийн ард иргэдийн нүүдэлчдийн

соёл, өв уламжлалыг түгээн дэлгэрүүлэх, соёлын түүхэн дурсгалт газрыг хамгаалах, угсаатан зүйн судалгаа хийх чиглэлээр “Өв соёл сан”-тай хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллаж байна.

Өмнөговь аймгийн ЗДТГ, Өмнөговь аймгийн Цогтцэций сумын ЗДТГ болон “Эрдэнэс Тавантолгой” ХК хооронд 2018 оны 05 дугаар сарын 08-ны өдөр байгуулсан ЭТТ-2018/112 тоот “Хамтын ажиллагааны гэрээ”-ний 5.5, 6.4 дэх хэсэгт заасны дагуу “Хамтын ажиллагааны хороо”-ны хурлыг 2020 оны 10 дугаар сарын 07-ний өдөр зохион байгуулсан. Хурлаар “Хамтын ажиллагааны гэрээ”-ний хэрэгжилтийг дүгнэж, цаашид хамтран авч хэрэгжүүлэх арга хэмжээнүүд болон гэрээнд оруулах нэмэлт, өөрчлөлтийн талаар санал солилцож, нэгдсэн тохиролцоонд хүрсэн. Талууд гэрээний хэрэгжилтийг “Хангалттай хэрэгжсэн” гэж дүгнэв.

Хамтын ажиллагааны хүрээнд дараахь томоохон ажлуудыг зохион байгууллаа.

1 “Эрдэнэс Тавантолгой” ХК нь эрүүл мэндийн салбарыг дэмжих хүрээнд Өмнөговь аймгийн Цогтцэций сумын Эрүүл мэндийн төвд химийн хортой хог хаягдал устгах автоклав болон дагалдах багаж хэрэгслийг 2020 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр хүлээлгэн өглөө. Ингэснээр тус суманд эрүүл мэндийн салбарт химийн хортой хогт хаягдлаа зориулалтын багаж хэрэгслээр устгах, халдваргүйжүүлэх бүрэн боломжтой болсон.



2 Өмнөговь аймаг 2020 оныг Боловсролыг дэмжих жил болгон зарласантай холбогдуулан “Эрдэнэс Тавантолгой” ХК нь Өмнөговь аймгийн Цогтцэций сумын 27-р цэцэрлэгийн дуу хөгжмийн кабинетэд шаардлагатай мэргэжлийн даралтат хөгжим, тоног төхөөрөмж дагалдах хэрэгслүүдийн хамт 2020 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр хүлээлгэн өгсөн. Тус цэцэрлэгийн хүүхэд багачууд 2020-2021 оны хичээлийн жилд хүссэн хөгжмийн зэмсгээр хичээллэх, авьяас чадвараа дайчлан өөрийгөө хөгжүүлэх бүрэн боломжтой болсон.



3 Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нөлөөллийн бүсийн иргэдийн амьдрах орчинг сайжруулах ажлын хүрээнд тус сумын 6 өрхөд 5 ханатай иж бүрэн өргөө цагаан гэрийг 2020 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр гардуулсан.



4 Гамшгийн үед сайн дурын үндсэн дээр тухайн орон нутагт техник, тоног төхөөрөмж, ажиллах хүчний болон бусад материаллаг туслалцаа үзүүлэх хүрээнд Цогтцэций сумын гал унтраах, аврах 44 дүгээр ангитай хамтран ажиллаж, сансрын хөдөлгөөнт холбооны гар утас авч өгөв. Ингэснээр тус сумын болон бүс нутгийн хэмжээнд гэнэтийн гамшиг осол, байгалийн давагдашгүй хүчин зүйлтэй нүүр тулгарахад цаг алдалгүй мэдээлэл дамжуулах, мэдээллээр хангаж ажиллах бүрэн боломжтой болсон.

5 Өмнөговь аймагтай байгуулсан хамтын ажиллагааны гэрээний хүрээнд Цогтцэций сумын ахмадуудад Сар шинийн баярыг тохиолдуулан хүндэтгэл үзүүлэх ажлыг сумын Засаг даргын Тамгын газартай хамтран зохион байгууллаа. Цогтцэций сумын ЗДТГ-аас ирүүлсэн хүсэлтийн дагуу 57 ахмадад компанийн зүгээс гарын бэлэг өгөхөөр шийдвэрлэсэн бөгөөд цар тахлын нөхцөл байдалтай холбогдуулан олон нийтийн үйл ажиллагаа зохион байгуулах

боломжгүй болсон тул төлөөлөл болгон зургаан ахмадад хүндэтгэл үзүүлэн үлдсэн 51 ахмадын гарын бэлгийг ЗДТГ-т хүлээлгэн өгсөн.



6

Орон нутгийн хүүхдийн хөгжлийг дэмжих хүрээнд Өмнөговь аймгийн Засаг даргаас ирүүлсэн хүсэлтийн дагуу тус аймгийн харьяат МУ-ын шатрын спортын дэд мастер Г.Номинг Грек улсад зохион байгуулагдах “Шатар сонирхогчдын дэлхийн аварга” шалгаруулах тэмцээнд оролцоход дэмжлэг үзүүлж ажилласан.

7

Өмнөговь аймгийн Засаг даргаас ирүүлсэн хүсэлтийн дагуу Өмнөговь аймгийн хэмжээнд Ковид-19 цар тахлын болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хилийн боомтод ариутгал, халдваргүйтгэл хийх, шаардлагатай нөөц бүрдүүлэх зардалд 52.5 сая төгрөгийн мөнгөн дэмжлэг үзүүлэн ажилласан.

8

Өмнөговь аймаг 2020 оныг “Боловсролыг дэмжих жил” болгон зарласантай холбогдуулан Өмнөговь аймагтай байгуулсан “Хамтын ажиллагааны гэрээ”-ний хүрээнд Өмнөговь аймгийн Даланзадгад хотын Ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн Мэдээлэл зүйн кабинетыг иж бүрэн тохижуулж 2020 оны 07 дугаар сарын 03-ны өдөр хүлээлгэн өгсөн.



9

Өмнөговь аймгийн Цогтцэций сумын Өрхийн эрүүл мэндийн төвийн үзлэгийн өрөөг бүрэн засварлан, үйл ажиллагаа явуулахад шаардлагатай тоног төхөөрөмжүүдийн хамтаар 2020 оны 10 дугаар сарын 16-ны өдөр хүлээлгэн өгсөн. Ингэснээр тус сумын хүүхэд бүр эрүүл аюулгүй орчинд эрүүл мэндийн үйлчилгээ авах бүрэн боломжтой боллоо.



10

Өмнөговь аймгийн Цогтцэций суманд 2020 оны 08 дугаар сарын 11-ны өдөр зохион байгуулагдсан “Адууны соёл” арга хэмжээнд дэмжлэг үзүүлж хамтран ажилласан.

11

Өмнөговь аймгийн Цогтцэций сумын өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах хүрээнд өвс, тэжээлийн нөөц бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлж Цагаан-Овоо багийн иргэдэд 735 боодол өвс, тэжээлийг 2020 оны 12 дугаар сард олгосон.





12

“Эрдэнэс Тавантолгой” ХК нийгмийн хариуцлагын хүрээнд 2013 оноос уламжлал болгон Өмнөговь аймгийн харьяат оюутнуудыг сургалтын тэтгэлэгт хамруулж эхэлсэн бөгөөд “Оюутны тэтгэлэгт хөтөлбөр”-ийг Өмнөговь аймгийн хэмжээнд болон Улсын хэмжээнд зарласан. Хөтөлбөрийг хэвлэл мэдээллийн хэрэгсэл, бусад хэлбэрээр олон нийтэд 1 сар гаруй хугацаанд сурталчилсан бөгөөд тэтгэлэгт хамрагдах хүсэлтэй оюутнуудын материалыг заасан хугацаанд хүлээн авч, нийт 90 оюутныг сонгон шалгаруулж, 2020 оны 10 дугаар сарын 28-ны өдөр батламжийг гардуулав.

13

Гэр нь шатсан Өмнөговь аймгийн Цогтцэций сумын Цагаан-Овоо багийн оршин суугч Н.Алтанзулд гамшгийн үед үзүүлэх тусламжийн хүрээнд 2020 оны 11 дүгээр сарын 08-ний өдөр монгол гэр өгч дэмжлэг үзүүлсэн.



14

Компанийн нийгмийн хариуцлагын хүрээнд 2020 оны 12 дугаар сарын 18-ны өдөр уурхайн Зүүн Цанхийн 07 дугаар овоолгоос Өмнөговь аймгийн Цогтцэций сум дахь Гал унтраах, аврах 44 дүгээр ангид 20 тн исэлдсэн нүүрс олгох ажлыг зохион байгууллаа.

15

“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Захирлын зөвлөлийн 2020 оны 09 дүгээр сарын 17-ны өдрийн хурлын шийдвэр, Гүйцэтгэх захирлын 2020 оны А/ 287 тоот тушаал болон Гүйцэтгэх захирлын 2020 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн баталсан төлөвлөгөөний дагуу Цогтцэций сумын Цагаан-Овоо багийн иргэдийн хөрөнгийн үнэлгээг танилцуулж гарын үсэг зуруулан баталгаажуулах, шаардлагатай тохиолдолд нэмэлт үнэлгээг хийлгэх ажлыг 2020 оны 10 дугаар сарын 16-21-ний өдрүүдэд

зохион байгуулсан. Тайланг танилцуулах ажлыг “Тавантолгой” ХК-тай хамтран зохион байгуулсан бөгөөд тус багийн иргэдийн 98 хувь нь биеэр ирж тайлантай танилцсан. Тайланг танилцуулах үеэр хөрөнгийн өмчлөгч, хамтран өмчлөгчийн талаарх мэдээлэл, дансны дугаарыг авч өмчлөгчдөөр гарын үсэг зуруулсан.



16

“Эрдэнэс Тавантолгой ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн хурлаар “Эрдэнэс Тавантолгой хөгжлийг дэмжих сан”-г байгуулах шийдвэрийг гаргалаа. Уг сан байгуулагдсанаар орон нутгийн хөгжлийг дэмжих олон талт арга хэмжээг Өмнөговь аймгийн удирдлагуудтай хамтран зохион байгуулах боломжтой юм. Сангийн дүрмийг боловсруулах ажил явагдаж байна.



ЗУРГАА. БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ

*Эх орныхоо
Тусын Тулд*
ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ ЭТТ

“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн зүгээс 2020 он томоохон бүтээн байгуулалтыг өрнүүлсэн жил боллоо. 2020 онд Уурхайн захиргааны барилга, Ажилчдын хотхон, цэцэрлэгт хүрээлэн, цэвэрлэх байгууламж, Цогтцэций сумын төвийг уурхайн захиргаатай холбох 13.5 км авто зам, гэрэлтүүлэг, дулаан хангамжийн зэрэг олон бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлэн ажиллаж байна.



БАРИЛГА, БАЙГУУЛАМЖ

ЦЭЦЭРЛЭГТ ХҮРЭЭЛЭН

“Эрдэнэс Тавантолгой” ХК Өмнөговь аймгийн Цогтцэций сумын 2 га газарт цэцэрлэгт хүрээлэнгийн тохижилтын ажлыг хийж гүйцэтгэн Өмнөговь аймгийн Цогтцэций сумын Засаг даргын Тамгын газарт хүлээлгэн өглөө.

Гүйцэтгэл 100%

ЦЭЦЭРЛЭГТ ХҮРЭЭЛЭН



ДИСПЕТЧЕРИЙН НЭГДСЭН ТӨВ

ЭТТ-2019/172 дугаартай “Мэдээлэл технологийн диспетчерийн нэгдсэн төвийн зураг төсөл боловсруулах, барилга угсралтын ажил гүйцэтгэх” гэрээний барилга

угсралтын ажлыг “Ган алт нэмэх” ХХК хийж гүйцэтгэсэн Барилга угсралтын ажилд хяналт тавьж ажлыг 100% гүйцэтгүүлэн Улсын комисст хүлээлгэн өгсөн.

Гүйцэтгэл 100%

УУРХАЙН ЗАХИРГААНЫ БАРИЛГА

“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Уурхайн захиргааны барилгын угсралтын ажлыг “Голден лайт групп” ХХК гэрээний дагуу гүйцэтгэж байна. Уг захиргааны барилга нь нийтдээ 3600 м кв хэмжээтэй бөгөөд 150 ажилтан, албан хаагч ажиллах боломжтой, 3 давхар, орчин үеийн оффисын байрны шаардлагыг бүрэн хангасан барилга юм. Өнөөдрийн байдлаар барилга угсралтын ажлын гүйцэтгэл 70%-тай байна.

Гүйцэтгэл 70%

ХИЙГДСЭН АЖЛУУД:

- ✓ Төмөр бетон каркас угсралт,
- ✓ Гадна дотор өрлөг шаврын ажил,
- ✓ Дээвэр,
- ✓ Цонх угсралт,
- ✓ Метал фасад каркас угсралт,
- ✓ Дотор сантехникийн угсралт,
- ✓ Дотор цахилгаан холболт зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэсэн.

ЗАХИРГААНЫ БАРИЛГЫН ГҮЙЦЭТГЭЛ



УУРХАЙН АЖИЛЧДЫН ХОТХОНЫ БАРИЛГА

Уурхайн ажилчдын хотхоны барилгыг “Лаки лайф” ХХК гэрээний дагуу гүйцэтгэж байна. Уурхайн ажилчдын хотхоны барилга нь 3 давхар, 4900 м кв хэмжээтэй 300 хүний багтаамжтай бөгөөд дотроо номын сан, хурлын танхим, хоолны заал, амрах өрөө, бялдаржуулах танхим, автомашины гараашиг иж бүрнээр шийдсэнээрээ онцлогтой. Барилга угсралтын ажлын явц 85%-тай байна.

Гүйцэтгэл 85%

ХОТХОНЫ БАРИЛГА:

- ✓ Төмөр бетон каркас угсралт,
- ✓ Гадна дотор өрлөг шаврын ажил,

- ✓ Дээвэр,
- ✓ Цонх угсралт,
- ✓ Метал фасад каркас угсралт,
- ✓ Шилэн фасад каркас угсралт,
- ✓ Дотор сантехникийн угсралт,
- ✓ Дотор цахилгаан холболт,

ГАРААШНЫ БАРИЛГА:

- ✓ Төмөр бетон каркас угсралт,
- ✓ Гадна дотор өрлөг шаврын ажил,
- ✓ Дээвэр,
- ✓ Дотор сантехникийн холболт зэрэг ажлууд хийж гүйцэтгэсэн.

ХОТХОНЫ БАРИЛГЫН ГҮЙЦЭТГЭЛ



ЦЭВЭРЛЭХ БАЙГУУЛАМЖ

Уурхайн ажилчдын хотхон болон захиргаа гараашны барилгуудын ахуйн бохир усыг цэвэрлэх цэвэрлэгээний үндсэн аргад биологийн аргыг сонгосон ба энэ нь цэвэрлэгээний үр дүн өндөртэй, азотыг бүрэн цэвэрлэх, ашиглалтын зардал бага, тогтвортойгоор ажиллах давуу талтай юм. Хотхоноос ирж буй бохир ус нь гар сараалжаар дамжин тунгаагуурт орно. Тунгаагдсан ус нь АНУ-ын патендлагдсан "MicroFAST19.0" төхөөрөмжид цэвэрлэгдээд өөрийн урсгалаар цэвэрлэгдсэн сан руу орно. Гүн цэвэрлэгээний шатанд умбуур бодис болон биохимийн хүчилтөрөгчийн хэмжээг 6-8мг/л хүртэл бууруулахын тулд агаажуулагчтай био цөөрмийг хэрэглэнэ. Үүнд LagoonFAST төхөөрөмж ашиглана. Цэвэрлэгдсэн усыг гипохлорит натриг ашиглан халдваргүйжүүлээд гарсан усыг усан санд хадгалж дахин ашиглана. Энэхүү Цэвэрлэх байгууламжийн барилга

угсралтын ажлыг "Анверса" ХХК гүйцэтгэж байгаа бөгөөд ажлын гүйцэтгэл 80%- тай байна.

Гүйцэтгэл 80%

ОДООГИЙН БАЙДЛААР ХИЙГДСЭН АЖЛУУД:

- ✓ Гадна бохир усны шугамын газар шорооны ажил,
- ✓ Гадна цахилгааны шугамын ажил,
- ✓ Био цөөрмийн арматурчлал,
- ✓ Цэвэрлэх байгууламжийн барилгын цутгалтын ажил,
- ✓ 500м³ усан сангийн цутгалтын ажил,
- ✓ Холбох худаг 1-ийн холболт хийж хөрсөөр нь буцаан булалт,
- ✓ Цэвэрлэх байгууламж, усан сан 1, 2-ын шугамын холболт, усан сан 1, 2-ын хар тосон түрхлэг зэрэг ажлууд хийгдсэн.

ЦЭВЭРЛЭХ БАЙГУУЛАМЖИЙН АЖЛЫН ЯВЦ



ХОТХОНЫ ГАДНА ИНЖЕНЕРИЙН ШУГАМ СҮЛЖЭЭ

"Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн Хотхоны гадна инженерийн шугам сүлжээний угсралт, зураг төсөв боловсруулах ажлыг "Анод катод" ХХК бүрэн гүйцэтгэж дуусгалаа.

Гүйцэтгэл 100%

Хийгдсэн ажил:

ХОТХОНЫ ГАДНА ИНЖЕНЕРИЙН ШУГАМ СҮЛЖЭЭНИЙ ЗУРАГ ТӨСӨВ:

- ✓ Дулааны шугамын зураг төсөв,
- ✓ Цэвэр усны шугамын зураг төсөв,
- ✓ Цахилгааны шугамын зураг төсөв,
- ✓ Бохир усны шугамын зураг төсөв,
- ✓ Шилэн кабелийн шугамын зураг төсөв,

БАРИЛГА УГСРАЛТЫН АЖИЛ:

- ✓ 2 ширхэг цэвэр усны гүний худгийн барилга угсралтын ажил

ГҮНИЙ ХУДАГ



ЗУРАГ, ТӨСӨВ БОЛОВСРУУЛАЛТ

- ✓ Өмнөговь аймгийн Даланзадгад хотод суманд баригдаж буй “Байгалийн түүхийн музей”-н 1-р давхарт байрлах “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн 7,5м х 3,5м х 3,0м хэмжээтэй талбайн интерьер зураг болон барилгын дотор заслын ажлын төсөв гаргасан.
- ✓ Компанийн ажилчдын шинээр барих 16 давхар

оффисын барилгын гадна инженерийн шугам сүлжээний тооцоог урьдчилсан байдлаар гаргасан.

- ✓ “Говь повер” гаалийн хяналтын бүсийн талбайд очиж гаалийн хяналтын бүсийн сэргээн засварлалтын ажлын төсвийг ESTIMATOR PRO программ дээр гаргав.

ЦАХИЛГААН, ДУЛААН ХАНГАМЖ, ГЭРЭЛТҮҮЛЭГ

Уурхайн ажилчдын хотхон, захиргааны барилгуудыг цахилгаанаар хангах 10 кВ-ын дэд өртөө, агаарын шугам барих, зураг төсөл боловсруулах ажлыг байнгын ашиглалтад хүлээж авах тухай Өмнөговь аймгийн ЗДТГ-ын А/938 тоот захирамж 2020 оны 08-р сарын 22-нд гарсны дагуу 2020 оны 08-р сарын 23-ны өдөр Улсын комиссыг ажиллуулж, тус барилга байгууламжийг хүлээж авсан.

Гүйцэтгэл 100%

Уурхай-Гашуунсухайтын 8.2 км авто замын 3 км хэсэгт гэрэлтүүлгийн барилга байгууламжийг байнгын ашиглалтад хүлээж авах тухай Өмнөговь аймгийн ЗДТГ-ын А/938 тоот захирамж 2020 оны 08-р сарын 18-нд гарсны дагуу 2020 оны 08-р сарын 20-ны өдөр Улсын комиссыг ажиллуулж хүлээлгэж өгсөн. Улсын комиссоос гаргасан үүрэг даалгаврыг гүйцэтгэгч компани “Лэдсити” ХХК хийж дуусгасны дагуу ажлын гүйцэтгэлийг хянаж гэрээг дүгнэсэн.

Гүйцэтгэл 100%

Баруун Цанхийн цахилгаан хангамжийн 10/04кВ-ын дэд өртөөг 2км зөөх ажил гүйцэтгэх тендерт Ноён сайхан ХХК шалгарч барилга угсралтын ажлыг 2020 оны 01-р сарын 20-ны өдрөөс 2020 оны 03-р сарын 02-ны өдрийг хүртэл хийж гүйцэтгэн ашиглалтад оруулсан.

Гүйцэтгэл 100%

Уурхайн захиргааны барилгад халаалтын цахилгаан зуух, халуун хөшиг тавих ажлын техникийн тодорхойлолтын дагуу тендер зарлагдаж гүйцэтгэгч компаниар “Энержи конвертер” ХХК шалгарч 2019 оны 10-р сарын 28-ны өдрөөс 2020 оны 01-р сарын 05-ны өдрийг хүртэл хугацаанд гүйцэтгэж хүлээлгэж өгсөн.

Гүйцэтгэл 100%

“Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК-ийн харьяа 220/110/35/10кВ-ын Тавантолгой дэд станцаас 110кВ-н гаргалгаа гарган ойролцоогоор 14км орчим ЦДАШ татаж 2х25000кВА чадалтай 110/10кВ-ын ил хуваарилах байгууламж барих ажлыг мөн 2021 онд ашиглалтад оруулах зайлшгүй шаардлага байгаа тул техникийн нөхцөлийг 2020 ондоо багтаан гаргуулахаар Эрчим хүчний яам диспетчерийн үндэсний төвд хандсан. Диспетчерийн үндэсний төвөөс горим ажиллагааны тооцоо хийж Эрчим хүчний яаманд хүргүүлснээр техникийн нөхцөлийн хурлаар хэлэлцэгдэхээр хүлээгдэж байна.

Гүйцэтгэл 15%

Өмнөговь аймгийн Даланзадгад хотод “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн нэрэмжит гудамжинд 27 ш авто замын гэрэлтүүлэг хийх ажлыг хариуцан ажиллаж гэрээнд заасан хугацаанд гүйцэтгүүлж аймгийн Засаг даргын тамгын газарт хүлээлгэн өгч ашиглалтад оруулсан.

Гүйцэтгэл 100%



АВТО ЗАМ

“Тавантолгой-Гашуунсухайт”, “Тавантолгой-Ханги”, “Тавантолгой-Цагаан дэл уул” чиглэлийн хүнд даацын авто замуудын судалгааг хийж танилцуулга боловсруулсан.

Цогтцэций сумыг Шинэ суурьшлын бүстэй холбох хатуу хучилттай 3.0 км автозамын зураг төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээний ажлыг “ХЗТ автозам” ХХК-иар гүйцэтгүүлэхээр гэрээг байгуулсан бөгөөд гэрээний дагуу Цогтцэций сумыг Шинэ суурьшлын бүстэй холбох хатуу хучилттай 3.0 км автозамын зураг төслийн ажил бүрэн хийгдсэн.

Гүйцэтгэл 100%

“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн уурхайг Өмнөговь аймгийн Цогтцэций сумын төвтэй холбох 13.5 км хатуу хучилттай автозамын барилгын ажлыг “Түм Арвижих” ХХК-иар гүйцэтгүүлэхээр гэрээг байгуулсан. Уг 13.5 км хатуу хучилттай автозамын барилгын ажилд байнгын хяналт тавих зөвлөх үйлчилгээ үзүүлэх ажлыг “Эн Би Си Си” ХХК-иар гүйцэтгүүлэхээр гэрээг байгуулсан.

2020 оны 09 дүгээр сарын 13-нд барилгын ажлын улаан

шугам тавьсан актыг хүлээн авч барилгын талбай дээр түр кемпийг төлөвлөлтийн дагуу байгуулсан эсэхэд хяналт тавин 13.5 км хатуу хучилттай автозамын барилгын ажлыг эхлүүлсэн.

Автозамын барилгын ажлын трасст өртөж буй “Энержи Ресурс” ХХК-ийн цахилгааны шугам болон ус дамжуулах хоолойг хэрхэн шийдвэрлэх талаар “Энержи Ресурс” ХХК-ийн холбогдох хүмүүстэй ажлын талбай дээр уулзалт хийж, шийдлийг албан бичгээр баталгаажуулж ирүүлэхээр тохиролцлоо. “Ростов” ХХК-иас 13,5 км автозамын трассын өөрчилсөн хэсгийн зураг, мөн “Энержи Ресурс” ХХК-ийн цэвэр усны хоолойн хэсгийн далангийн өндөржилтийг өөрчилсөн шинэчилсэн зургийг гаргуулан авсан байна. “Мобиком Нетворкс” ХХК-иас ирүүлсэн 13.5 км автозамын трасстай огтлолцож буй шилэн кабелийн координатуудыг шалгуулахаар салбарын маркшейдерт хүсэлт тавьсан.

Цаг агаар хүйтэрсэн болон хөл хорио тогтоосонтой холбоотойгоор 13.5 км хатуу хучилттай автозамын барилгын ажлыг 2021оны 03 дугаар сарын 01-ний өдөр хүртэл зогсоосон.

Гүйцэтгэл 15%

АВТО ЗАМЫН АЖЛЫН ЯВЦ





ДОЛОО. ДОТООД ХЯНАЛТ, ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

*Эх орныхоо
Тусын Тулг*
ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ СТТ

ДОТООД ХЯНАЛТ, ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын газар нь дотоод хяналт шалгалтыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд явуулж, удирдлага үйл ажиллагааны зорилго зорилтоо биелүүлэхэд нь дэмжлэг үзүүлж, компанийн хэмжээнд дотоод хяналтын үр ашигтай тогтолцоо, хяналтын соёлыг бий болгох зорилготой ажиллав.

ХЯНАЛТ ШАЛГАЛТ

Төлөвлөгөөт хяналт шалгалтын хүрээнд 8 удирдамж боловсруулан Гүйцэтгэх захирлаар батлуулж дотоод хяналт шалгалтыг хийж гүйцэтгэлээ. Хяналт шалгалтад илэрсэн зөрчил, дутагдал арилгуулах 109 зөвлөмжийг холбогдох нэгжүүдэд хугацаатай хүргүүлж хэрэгжилтийг хангуулан ажиллав.

Гүйцэтгэлийн хүрсэн түвшнийг бодитой тогтоох, компанийн удирдлагын үйл ажиллагаа, шийдвэр гаргалтад дэмжлэг үзүүлэх зорилгоор компанийн дотоод үйл ажиллагаанд мөрдөгдөж буй дүрэм, журам, горим зааврын хэрэгжилтэд III-р улирлын байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж үр дүнг удирдлагуудад танилцууллаа.

Компанийн удирдлага, дээд газраас өгсөн үүрэг чиглэлийн дагуу 27 удаагийн төлөвлөгөөт бус хяналт шалгалтын ажлыг зохион байгуулжээ.

ҮҮНЭЭС ТОМООХОН АЖЛУУДЫГ ДУРДВАЛ:

- ✓ Худалдан авалт, ханган нийлүүлэлтийн газрын 2018, 2019, 2020 онд зохион байгуулсан, амжилттай хэрэгжиж буй худалдан авалтын тендерээс 36

тендерт хяналт шалгалтыг хийж гүйцэтгэв. Нийт худалдан авалтын 69 тендерийн материалд хяналтыг хийж дүгнэлт гарган ажиллаа.

- ✓ Салбарын Нүүрс ачилт, логиستيкийн хэлтэс, Тээвэр, логиستيкийн хэлтсийн үйл ажиллагаанд иж бүрэн хяналт шалгалт хийж, нүүрс ачилт, тээвэр, логиستيкийн үйл ажиллагаанд үүссэн алдаа дутагдал, зөрчлийг илрүүлэн, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний санал, зөвлөмжийг боловсрууллаа.
- ✓ Компаниас “Тавантолгой Түлш” ХХК-д олгогдсон санхүүжилт болон олгогдох санхүүжилтийн хүрээнд хяналт тавих ажлын хэсгийг байгуулсан. “Тавантолгой түлш” ХХК-ийн үйл ажиллагаанд зориулан өгсөн санхүүжилттэй холбоотой 24 хуудас бүхий тайлан, дүгнэлтийг нэгтгэн боловсрууллаа.
- ✓ “Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлогын баримт бичиг”, “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг компанийн хэмжээнд тодорхойлж, хяналт-шинжилгээ үнэлгээ хийж Уул уурхайн хүнд үйлдвэрийн яаманд хүргүүлэв.

ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА, ЧАНАРЫН МЕНЕЖМЕНТ

“Эрдэнэс Тавантолгой” ХК-д нэгдсэн менежментийн тогтолцоог олон улсын стандартуудын шаардлагын дагуу сайжруулах Чанарын багийг шинэчлэн байгуулав. Нэгдсэн менежментийн стандартыг 7 бүлэг 85 зүйл заалттай төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлснээр магадлан аудитаар олон улсын стандартын гэрчилгээг сунгуулсан.

Компанийн эрсдэлийн удирдлагын тогтолцоог сайжруулах зорилгоор “Эрсдэлийн удирдлагын журам”, журмыг дагалдан гарах горим зааврыг боловсруулан батлууллаа.

Батлагдсан эрсдэлийн үнэлгээний журам, заавар


болон олон улсын ISO:31000 стандартын дагуу “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн үйл ажиллагаанд анх удаа эрсдэлийн шинжилгээ, үнэлгээ хийж гарч болзошгүй эрсдэлүүдийг тодорхойлов. Компанийн үйл ажиллагаанд учирч болзошгүй нийт 167 эрсдэлийг 9 бүлэгт хуваан байгууллагын, гадаад үйл ажиллагаа, техникийн гэсэн 3 үндсэн, 19 дэд ангилалд хуваан нарийвчлан тодорхойллоо. Эрсдэлүүдийг ангиллаар нь харуулбал хамгийн их эрсдэлтэй салбар нь ХАБЭА-29%, Байгаль орчин-12%, Мэдээллийн технологи-12%, худалдан авалт, гэрээ - 7% байна. Эрсдэлийн үнэлгээний дагуу тайлан төлөвлөгөөг боловсруулан удирдлагад танилцуулж холбогдох газар нэгжүүдэд хүргүүлж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

ХАРИУЦЛАГАТАЙ УУЛ УУРХАЙ, ШИЛЭН ДАНС

Нэгдсэн үндэстний байгууллагаас батлан гаргасан “Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал” хариуцлагатай уул уурхайтай холбоотой олон улсын 23 стандарт баримт бичгүүд, болон Канадын Уул Уурхайн Ассоциацийн гаргасан “Тогтвортой уул уурхайн үнэлгээний заавар”-т үндэслэн хариуцлагатай уул уурхайн үнэлгээ хийх шалгуур үзүүлэлтийг 5 бүлэг 248 асуулгатайгаар боловсруулан батлуулсан. Батлагдсан “Хариуцлагатай уул уурхайн үнэлгээний аргачлал”-ын дагуу үнэлгээ хийж тайлан боловсруулагдсан бөгөөд хэрэгжилтийг сайжруулах эрчимжүүлэх шаардлагатай ажлуудын төлөвлөгөө боловсруулж батлуулан холбогдох нэгжид хүргүүлсэн.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын харьяа байгууллагуудад хийгдсэн шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн холбогдох баримт материалыг Үндэсний Аудитын газрын Нийцлийн аудитын газарт хүргүүлэн, хяналт шалгалтад хамрагдав. Шилэн дансны цахим хуудсанд байршуулах мэдээллийн жагсаалтыг шинэчлэн батлуулсан. Уг тушаалын дагуу 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хойших мэдээллийг нөхөн байршуулсан.

“Эрдэнэс Тавантолгой” ХК Шилэн дансны нэгдсэн системд 12 дугаар сарын 31-ны өдрийн байдлаар 108 мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулсан байна.



НАЙМ. КОВИД-19 ЦАР ТАХЛЫН ХАЛДВАРААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

КОВИД-19 ЦАР ТАХЛЫН ХАЛДВАРААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын “Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай” 2020 оны А/21 дүгээр тушаалын дагуу компанийн хэмжээнд шуурхай удирдлагаар хангах штабыг Гүйцэтгэх захирлын А/55 дугаар тушаалаар байгуулж, шуурхай удирдлагаар ханган ажиллаж байна.

“Эрдэнэс Тавантолгой” Хувьцаат компаниас өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжүүлсэн хугацаанд авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж, Уул уурхай, хүнд үйлдвэрийн гамшгаас хамгаалах улсын албанд шуурхай удирдлагаар хангах штабаас болон салбарын диспетчерийн албанаас өдөр бүрийн 16 цагт мэдээлэл хүргүүлэн ажиллаж байна.

Гүйцэтгэх захирлын 2020 оны А/44, А/79, А/98 тоот тушаалуудаар нийтдээ 191 сая төгрөгийн өртөг бүхий нэг удаагийн амны хаалт, шүүлтүүртэй маск, гар ариутгагч, дархлаа дэмжих чацарганын охь, витамин вирусийн халдварыг оношлох оношлуур, хамгаалалтын хувцас, нүүрний хаалт худалдан авч нөөц бүрдүүлсэн. Үүнээс 66,1 сая төгрөгийн өртөг бүхий бүтээгдэхүүнийг “Эрдэнэс Тавантолгой” ХК-тай тээврийн гэрээ байгуулсан компанийн нүүрс тээврийн жолооч нарт тараан, Улаанбаатар хот руу татах ажлыг 2020 оны 02 дугаар сард зохион байгуулав.



Өмнөговь аймгийн хэмжээнд “Covid-19” вирусийн халдварын болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хилийн боомтод ариутгал, халдваргүйтгэл хийх, шаардлагатай нөөц бүрдүүлэх ажлын зардалд 52.5 сая төгрөгийг хандивлалаа.

Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацаа, өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацаанд мөрдөн ажиллах Түр журам, Халдваргүйжүүлэлт хийх түр зааврын дагуу цэвэрлэгээ, үйлчилгээ хийх ажлын хуваарь заавар, Нэг бүрийн хамгаалах хэрэгсэл, ариутгалын бүтээгдэхүүн тараах хуваарийг батлан, мөрдүүлэн ажиллаж байна.

“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн үед хэрэгжүүлэх ажлын жишиг төлөвлөгөөг боловсруулан, баталсан бөгөөд УУХҮЯ-наас. “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн жишиг төлөвлөгөөг Уул уурхайн салбарын компаниудад хүргүүлсэн.

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн 64 дүгээр хуралдааны тэмдэглэлийн 5 дахь заалт, Уул уурхай хүнд үйлдвэрийн сайдын 2020 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн А/297 дугаар тушаалын дагуу Тавантолгой бүлэг ордын аюулгүйн тусгай бүсэд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан батлуулсан.

Төлөвлөгөөний дагуу Цагаан хад хилийн боомтод ажиллаж байгаа Дотоодын цэргийн 805 дугаар ангийн Штабын дарга Д.Энхбадрахаар ахлуулсан 50 цэрэг, Өмнөговь аймгийн ЭМН-ийн ЗУХ-ийн даргаар ахлуулсан Зооноз өвчин судлалын үндэсний төвийн 5 эмч, Ханбогд сумын 24 эмч нарын байрлах буудал, хоол, түлшний зардал, халдвар хамгааллын хэрэгслийн зардлын 60%-ийн төлбөр, зохион байгуулалтыг хариуцан ажиллав.

Компанийн төв оффисын байранд өдөрт 2 удаа 6 цагийн зайтай, ажилчдын байранд өдөрт 3 удаа 6 цагийн зайтай, ажилчдын автобусанд өдөрт 2 удаа халдваргүйтгэл, ариутгал хийж байна. Хуваарийн дагуу ажилтнуудад урьдчилан сэргийлэх нэг бүрийн хамгаалах хэрэгсэл, дархлаа дэмжих бүтээгдэхүүнийг тараан ажиллаж байна. Ариутгал халдваргүйжүүлэлтийг мэргэжлийн байгууллага болох “Хүслэн хийморь” ХХК-иар уурхай, хотхоны нийт ажил амралтын байруудад 2 удаа, гэрээт катерингийн үйлчилгээний компаниар 32 удаа тус тус хийлгэлээ.

УУХҮЯ-ны гамшгаас хамгаалах уул уурхай, хүнд үйлдвэрийн улсын албатай хамтран ЭМЯ-нд хүсэлт гарган, БНСУ-аас 15000 ширхгийг захиалан авч, гэрээт компаниудад тараан, 7 хоног тутам салбарт ажиллаж байгаа ажилтан албан хаагчдаас шинжилгээ авч хяналт тавьж ажиллаж байна.



ЕС. КОМПАНИАС ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨРҮҮД


*Эх орныхоо
Тусын Тулг*
ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ ЭТТ

КОМПАНИАС ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨРҮҮД

Монгол Улсын Их Хурлын 2018 оны 73 дугаар тогтоолоор Тавантолгойн нүүрсний ордын эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх, холбогдох дэд бүтцийг барьж байгуулах зорилгоор томоохон төсөл хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлэхийг даалгасан.

“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн 2021-2025 онд хэрэгжүүлэх “А6-20” бизнес төлөвлөгөөний хүрээнд өртөг, зардлыг бууруулах, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг хөгжүүлэх зэрэг томоохон зорилтууд дэвшүүлж байгаа бөгөөд энэ нь Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн “3.2.1.6 Тавантолгой нүүрсний бүлэг ордын дэд бүтцийг бүрдүүлж, үйлдвэрлэл технологийн парк байгуулах ажлын хүрээнд нүүрс баяжуулах үйлдвэрийг ашиглалтад оруулна”, “5.1.4 Тавантолгойн 450 МВт-ын цахилгаан станц, холбогдох дэд бүтцийн бүтээн байгуулалтыг эхлүүлэх” гэсэн заалтуудтай бүрэн нийцэж байна.

Дээрх болон холбогдох бусад тогтоол шийдвэрийн дагуу Тавантолгойн ордыг түшиглэсэн үндэсний их бүтээн байгуулалтыг эхлүүлж, олон улсын зах зээлд голлох байр суурь бүхий сайн чанарын нүүрсний “Тавантолгой” брэнд бүтээгдэхүүн бий болгоход чиглэсэн аюулгүй, тогтвортой, нээлттэй, хариуцлагатай уул уурхай, үйлдвэрлэл, технологийн цогцолбор парк байгуулж, шинээр ажлын байр бий болгох, улс орны болон бүс нутгийн эдийн засгийн өсөлтөд бодитой хувь нэмэр оруулах “Уул уурхай - Дэд бүтэц - Аж үйлдвэрлэл”-ийн тэргүүлэгч компани болж хөгжих зорилготой ажиллаж байна.



9.1. ТӨМӨР ЗАМЫН ТӨСЛҮҮД

“Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого”-ын 2.2.3-д стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордуудаас олборлосон, боловсруулсан бүтээгдэхүүнийг тээвэрлэх төмөр замын суурь бүтцийг улсын эдийн засаг, нийгэмд онцгой ач холбогдолтой суурь бүтэц гэж үзсэн бөгөөд Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замыг Монгол Улсын тогтвортой хөгжил, эдийн засгийн өсөлт, нийгэм-эдийн засгийн онцгой ач холбогдлыг төрийн бодлогын түвшинд авч үзэж тодорхойлсон.

Тавантолгой – Гашуунсухайт чиглэлийн төмөр зам нь компаний тээвэр, ложистикийн өртгийг 2-3 дахин бууруулж, дэд бүтэцтэй холбоотойгоор өнөөдөр компанид тулгарч буй

хүндрэлүүдийг арилгах ба зорилтот зах зээл болох БНХАУ-ын хойд болон зүүн хойд бүс дэх эцсийн хэрэглэгчдэд бүтээгдэхүүнээ нийлүүлэхэд чиглэсэн компанийн дунд хугацааны зорилгыг хангах төдийгүй эрчим хүчний нүүрсийг их хэмжээгээр борлуулах боломж олгоно.

Компанийн маркетинг, борлуулалтын төлөвлөгөөнд дунд хугацаанд ОХУ болон БНХАУ-ын далайн боомтоор дамжуулан бусад зах зээл болох БНЭУ, Япон улс, БНСУ-ын зах зээлд нүүрс нийлүүлэх туршилт хийх, хамтын ажиллагааг хөгжүүлэх, нүүрсний экспортыг нэмэгдүүлэх чиглэл туссан бөгөөд “Тавантолгой- Зүүнбаян” чиглэлийн төмөр замын төсөл нь бусад зах зээл рүү чиглэсэн бодлоготой уялдана.

ТАВАНТОЛГОЙ – ГАШУУНСУХАЙТ ЧИГЛЭЛИЙН ТӨМӨР ЗАМЫН ТӨСӨЛ

Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр зам нь Өмнөговь аймгийн Цогтцэций, Баян-Овоо, Ханбогд сумдын нутаг дэвсгэрээр дайран өнгөрч, 240 орчим километр

үргэлжлэх бөгөөд нийт 2 өртөө, 6 зөрлөгтэй баригдахаар төлөвлөгдсөн.

Засгийн газрын 2018 оны 242 дугаар тогтоолын

дагуу төслийн суурь бүтцийг эзэмших, барьж байгуулах үүрэгтэй тусгай зориулалтын “Тавантолгой төмөр зам” ХХК нь “Монголын төмөр зам” ТӨХК-ийн 100 хувийн охин компани хэлбэрээр 2018 оны 10 дугаар сарын 08- ны өдөр байгуулагдаж байсан бол Засгийн газрын 2019 оны 304 дүгээр тогтоолын дагуу тус компанийн нийт гаргасан хувьцааны 66 хувийг “Эрдэнэс Тавантолгой” ХК, 34 хувийг “Монголын төмөр зам” ТӨХК тус тус эзэмшиж төслийн ажлыг үргэлжлүүлж байна.

“Тавантолгой-Гашуунсухайт” чиглэлийн төмөр замын барилгын ажлыг гүйцэтгэж дуусахад шаардлагатай хөрөнгө оруулалтын хэмжээг нийт 1,282.0 сая ам.доллар гэж тооцсон бөгөөд дээрх төслийг хэрэгжүүлэгч компани болон холбогдох талуудын зүгээс одоогийн байдлаар нийт 633.9 сая ам.долларын хөрөнгийг тус төсөлд зарцуулсан байна.

2021 оны 2 дугаар сарын байдлаар замын доод бүтцийн ажил 99.4 хувь, дээд бүтцийн ажил 77.6 хувь, өртөө зөрлөг барилга угсралтын ажил 1.5%-ийн гүйцэтгэлтэй явж байна.


ТАВАНТОЛГОЙ –ГАШУУНСУХАЙТ ЧИГЛЭЛИЙН ТӨМӨР ЗАМЫН ТӨСЛИЙН АЖИЛ ҮРГЭЛЖИЛЖ БАЙНА



Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын 2019 онд боловсруулсан ТЭЗҮ-ийн тодотголоор нэг тонн/км ачааны тариф \$0.030, хөрөнгө оруулалтын нөхөх хугацаа 13 жил хүртэл, жил бүр 235-331 сая ам.долларын тээврийн орлого олсноор, 20.6 сая ам.долларын татварыг улсын

төсөвт төвлөрүүлж, 1,355 байнгын ажлын байраас гадна, 1,000 гаруй дагалдах ажлын байр бий болох, нүүрсийг БНХАУ-аар дамжуулан гуравдагч орны зах зээлд хүргэн экспортыг нэмэгдүүлэх эдийн засгийн ач холбогдолтой төсөл юм.

ТАВАНТОЛГОЙ-ГАСУУНСУХАЙТ, ТАВАНТОЛГОЙ-ЗҮҮНБАЯН ЧИГЛЭЛИЙН ТӨМӨР ЗАМЫГ ХОЛБОХ ТӨМӨР ЗАМЫН ШУГАМЫН ЧИГ



9.2. ТАВАНТОЛГОЙ ДУЛААНЫ ЦАХИЛГААН СТАНЦЫН ТӨСӨЛ

Монгол Улсын Их хурлын 2018 оны 73 дугаар тогтоолоор Тавантолгойн нүүрсний ордын эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх, холбогдох дэд бүтцийг байгуулах зорилгоор өмнөд бүсийн уул уурхайн төслүүдийн эрчим хүчний хэрэгцээг хангах цахилгаан станц болон нүүрс химийн үйлдвэрийг Тавантолгойн ордыг түшиглэн барих талаар шаардлагатай арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газарт даалгасан. Тавантолгой цахилгаан станцыг барьж байгуулах нь өмнийн говийн уул уурхайн эрчим хүчний хэрэглээг найдвартай эрчим хүчний эх үүсвэрээс хангах, цахилгаан станцын үйл ажиллагааны гол зардал болох нүүрсний тээвэрлэлтийн зардлыг хэмнэх, тус бүс нутгийн эрчим хүчний системийн горимыг тогтворжуулж, найдвартай ажиллагааг сайжруулах зэрэг олон талын ач холбогдолтой юм.

Түүнчлэн тухайн бүс нутагт үйл ажиллагаа явуулж байгаа Тавантолгой, Оюутолгой болон уул уурхайн хэрэглэгчдийн цахилгаан эрчим хүчний хэрэглээг хангах шаардлагатай тооцоолон 450МВт хүчин чадалтай 3 блок цахилгаан станц барихаар сонгосон. Шинээр баригдах цахилгаан станцын гол хэрэглэгчид нь "Оюутолгой" ХХК болон Тавантолгойн

нүүрсний уурхайн цогцолбор бөгөөд "Оюутолгой" ХХК-ийн Монгол Улсын Засгийн газартай байгуулсан хөрөнгө оруулалтын гэрээнд үйлдвэрлэл эхэлснээс хойш 4 жилийн дараа эрчим хүчний хэрэгцээг дотоодын эрчим хүчний эх үүсвэрээс хангана гэж тодорхойлсон.

Засгийн газрын 2020 оны 175 дугаар тогтоолын дагуу Тавантолгойн 450 МВт-ын цахилгаан станцыг холбогдох дэд бүтцийн хамт барьж байгуулах зорилготой "Тавантолгой дулааны цахилгаан станц" ТӨХХК-ийг үүсгэн байгуулж, нийт хувьцааны 50 хувийг Эрчим хүчний яам, 30 хувийг "Эрдэнэс Тавантолгой" ХК, 20 хувийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар тус тус эзэмшиж байна.

"Эрдэнэс Тавантолгой" ХК-аас нийт хөрөнгө оруулалтын 30%-ийг санхүүжүүлснээр Тавантолгойн 450 МВт-ын дулааны цахилгаан станцыг холбогдох дэд бүтцийн хамт 2021-2024 онд барьж ашиглалтад оруулж, эрчим хүчний зориулалтын 1.4 сая тн нүүрс нийлүүлж, дотоодын цахилгааны хэрэгцээг хангах нөхцөл бүрдэх юм.

Тавантолгойн 450 МВт-ын дулааны цахилгаан станцын ТЭЗҮ-г 2020 онд "Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн"

ТӨААТҮГ боловсруулсан ба өндөр бүтээмжтэй, хорт бодисын ялгаралт багатай эргэлтийн буцламтгай үет технологи бүхий зуух, конденсагийн уурын турбин, турбогенератор, усны

хэрэглээ бага шаардах агаарын хөргөлттэй конденсатор, орчин үеийн удирдлага мэдээллийн системийг төлөвлөж өгсөн.

ТАВАНТОЛГОЙ ДУЛААНЫ ЦАХИЛГААН СТАНЦЫН 3D ТӨЛӨВЛӨЛТ



9.3. УС ХАНГАМЖИЙН ТӨСЛҮҮД

Тавантолгойн уурхай бүрэн хүчин чадлаараа ажиллаж эхэлснээр Монгол Улсын эдийн засагт чухал нөлөө үзүүлэх үндэсний том бүтээн байгуулалт болох бөгөөд энэхүү төслийг цогцолбор байдлаар бүрэн хүчин чадлаар нь ажиллуулахад ус хангамжийн асуудал нэн чухал ач холбогдолтой юм.

Одоогийн байдлаар “Эрдэнэс Тавантолгой” ХК нь уурхайн усны хэрэгцээг өөрийн эзэмшлийн 21 ширхэг гүний худгаас одоогоор 15 худгийг ашиглаж байгаа ба эдгээр худгийн нийт нөөц (ундарга) 46 л/сек байдаг.

Компани нь дээрх усыг ундны, ахуйн болон үйлдвэрлэлийн зориулалтаар ашигладаг бөгөөд үйлдвэрийн усны хэрэглээний дийлэнх нь уурхайн зам талбайг усалж, тоосжилтыг дарахад зарцуулагддаг.

Уул уурхайн үйлдвэрлэл хурдацтай өсч, эдийн засгийн гол суурь болж байгаатай холбогдуулан үйлдвэрлэлийг хэвийн үргэлжлүүлэхийн тулд Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутагт байрлах Загийн усны хоолой дахь гүний усны орд болон Дорноговь аймгийн Мандах сумын нутагт байрлах Цагаан цавын гүний усны ордоос зохих хэмжээний усыг эхний ээлжинд ашиглах, цаашдаа Говийн бүс нутгийг гадаргын усаар хангах “Орхон”, “Хэрлэн” голоос урсцын тохируулга хийж шугам хоолой татах төсөлтэй уялдуулахаар тодорхой ажлуудыг төлөвлөж байна.

- ✓ Нүүрс баяжуулах үйлдвэрийн 1-р үе шат (10 сая.тн) - 2024 онд ашиглалтанд орно. 54.5 л/с усыг Загийн усны хоолойн гүний усны эх үүсвэрээс хангана.
- ✓ Нүүрс баяжуулах үйлдвэрийн 2-р үе шат (30 сая.

тн) - 2026 онд ашиглалтанд орно. Нийт 129.97 л/с ус хэрэглэх бөгөөд үүнийг Загийн усны хоолойгоос гадна Цагаан цавын усны ордоос хангана.

- ✓ Цахилгаан станц- 2024-2025 онд ашиглалтад орох бөгөөд шаардлагатай усны хэрэглээ 32 л/с байна.

Говийн бүс нутгийг гадаргын усаар хангах төслүүд хэрэгжихэд 6-8 жил зарцуулахаар салбарын төрийн захиргааны байгууллагууд мэдэгдэж байгаа бөгөөд компанийн зүгээс гадаргын усыг ашиглаж эхлэхээр газар доорх гүний усны хэрэглээг шат дараалалтайгаар багасгаж ажиллахаар төлөвлөж байна.

Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутагт байрлах Загийн усны хоолой дахь гүний усны орд болон Дорноговь аймгийн Мандах сумын нутагт байрлах Цагаан цавын гүний усны ордоос зохих хэмжээний усыг эхний ээлжид ашигласнаар нүүрс баяжуулах үйлдвэрийн шаардлагатай усны хэрэглээ хангагдаж үйлдвэрлэл явуулах боломжтой болно.

2019 онд “Загийн усны хоолой”-н гүний усны ордоос Тавантолгой уурхай хүртэл ус татах шугам хоолойн ТЭЗҮ-ийг “Престиж Инженеринг” ХХК боловсруулсан.

2021 оноос Цагаан цавын гүний усны ордоос ашиглах ТЭЗҮ, зураг төслийг боловсруулах ажлыг эхлүүлэхээр төлөвлөсөн.

Говийн бүсийн хөгжил болон үйлдвэрлэлд шаардлагатай усны эх үүсвэрийг гүний болон гадаргын ус ашиглах хэлбэрээр үе шаттайгаар хангаж, нөхөн сэргээгдэх бодлогыг хэрэгжүүлэхээр ажиллаж байна.



9.4. НҮҮРС БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭРИЙН ТӨСӨЛ

Цанхийн баруун болон зүүн уурхайн ТЭЗҮ-д тус бүр 2014 болон 2015 онуудад нүүрс баяжуулах үйлдвэрийг ашиглалтад оруулж ордын нөөцийг бүрэн ашиглаж, баяжуулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэхээр төлөвлөсөн байдаг. Гэвч өнөөгийн байдлаар нүүрс баяжуулах үйлдвэр баригдаагүй бөгөөд үүний улмаас 3 болон 4-р давхаргын нүүрсийг голчлон олборлож байгаа нь уурхайн технологийн горимын хангаж үйл ажиллагаа явуулахад хүндрэл үзүүлсээр байна.

“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор Монгол Улсын Их Хурал, Засгийн газрын гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх хүрээнд коксжих чанар султай нүүрсийг сайн чанарын нүүрстэй хольж баяжуулан чанарыг дундажлан экспортын шаардлага хангасан, орчин үеийн, дэвшилтэт техник, технологи бүхий “Нүүрс баяжуулах үйлдвэр”-ийг барихаар төлөвлөсөн.

Нүүрс баяжуулах үйлдвэрийн нийт хүчин чадлыг ордын нөөц, усан хангамжийн эх үүсвэр, ил уурхайн олборлолтын ирээдүйн хүчин чадал болон зах зээлийн байдлыг харгалзан жилд 30.0 сая тн хүртэлх нүүрсийг баяжуулах хүчин чадалтай байхаар төлөвлөсөн. Нүүрс баяжуулах үйлдвэр нь ижил хүчин чадалтай, хоорондоо хамааралгүй ажиллах боломжтой тус бүр 10.0 сая.тн нүүрс баяжуулах хүчин чадалтай 3 модуль байх ба нэг модулийн үндсэн баяжуулах хэсэг тус бүр нь 5.0 сая.тн нүүрс баяжуулах хүчин чадалтай 2 шугамтай байхаар төлөвлөгдсөн.

НБҮ-ИЙН ТӨСЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ДАРААХ ГОЛ ШАЛТГААН НӨХЦӨЛ, БОЛОМЖУУД БАЙНА.

Үүнд:

- ✓ Нүүрс баяжуулах хүчин чадалтай үйлдвэрийг ашиглалтад оруулснаар Тавантолгой ордын

түүхийгээр борлуулах боломжгүй давхаргуудын (0,5,7,8,9-р) нүүрсийг зохистой хэмжээнд олборлож боловсруулах боломжтой болно. Ингэснээр их хэмжээний сул чанартай нүүрстэй үлдэх эрсдэлээс сэргийлж, ордын нөөцийг жигд ашиглаж, уурхай үйл ажиллагаа явуулах хугацааг уртасгана.

- ✓ Баяжуулах үйлдвэрт орох нүүрсний харьцааг давхаргуудын баяжигдах шинж чанарын судалгаан дээр үндэслэн коксжих чанар султай нүүрсийг сайн чанарын нүүрстэй хольж баяжуулан чанарыг дундажлах замаар баяжмалын гарцыг хамгийн өндөр байхаар тооцож ТЭЗҮ-д тусгасан.
- ✓ НБҮ-ийн төсөл бүрэн хүчин чадлаараа ажиллаж эхэлснээр жилд дунджаар 205.8 сая ам.долларын цэвэр ашигтай ажиллах бөгөөд төслийн өнөөгийн цэвэр үнэ / NPV@10% / 911.5 сая ам доллар, өгөөжийн дотоод норм / IRR/ 23.9%, хөрөнгө оруулалтаа /барилга угсралтын жилийг оруулснаар/ 7 жилд бүрэн нөхөн төлөхөөр байгаа нь уг төсөл үр ашигтай хэрэгжих боломжтой төсөл болохыг илтгэж байна.
- ✓ Төсөл хэрэгжсэнээр улс орон болон бүс нутгийн нийгэм эдийн засгийн өсөлтийг дэмжиж жилд дунджаар 290.4 сая ам.долларыг татвар төлбөр хураамж хэлбэрээр улс орон нутгийн төсөвт оруулахаар байна.
- ✓ Үйлдвэрийг ашиглалтад оруулсанаар 472-928 ажлын байр шинээр бий болно. Шаардлагатай ажиллах хүчний хэрэгцээний 97 хувийг дотоодын зах зээлээс хангах бөгөөд компанийн зүгээс 2021-2025 онуудад дотоодын их дээд сургууль, МСҮТ, коллеж, сургалтын төвүүдэд ажиллах хүчийг бэлтгэж, хангах ажлыг зохион байгуулахаар төлөвлөж байна.
- ✓ НБҮ-ийн ТЭЗҮ, FEED-ийг гүйцэтгэгч БНХАУ-ын СМЕС компани НБҮ-ийн FEED буюу техникийн зураг төслийг 7 сард дуусгаж хүлээлгэн өгөхөөр ажиллаж байна. Цаашлаад НБҮ-ийн төслийг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий тусгай зориулалтын компанийг байгуулж үйл ажиллагааг эрчимжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.
- ✓ НБҮ байгуулснаар бид дэлхийн жишигт нийцсэн брэнд бүтээгдэхүүнтэй уурхай болж цаашлаад нүүрс хими, метан хий болон коксын үйлдвэр гэх мэт төслүүдээ зөв зохистой хэрэгжүүлэн Монгол улсын засгийн газар, Их хурлаас дэвшүүлсэн Тавантолгойн орд газрыг түшиглэсэн үйлдвэрийн цогцолбор байгуулах, дотоодоо нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, экспортын орлогыг нэмэгдүүлэх зорилтуудад бүрэн нийцэх юм.

ТӨСЛИЙН ТАЛБАЙН ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨЛТ





9.5. НҮҮРС АЧИЛТЫН БАЙГУУЛАМЖИЙН ТӨСӨЛ

Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын техник эдийн засгийн үндэслэлд Тавантолгой уурхайн нүүрсийг галт тэргэнд бункерийн байгууламжаар ачих зорилгоор Тавантолгой өртөөтэй холбогдож буй ачилтын тойргийг хос замтай барихаар тусгасан. Тавантолгой - Зүүнбаян чиглэлийн төмөр замын техник, эдийн засгийн үндэслэлийн тодотголын судалгаанд Цогтцэций өртөөг төлөвлөхдөө нүүрс ачих байгууламжтай холбох хэсгийг багтаагаагүй тул Цогтцэций өртөөг Тавантолгой өртөөтэй холбох төмөр замыг барьснаар ачааны эх үүсвэртэйгээ холбогдох ач холбогдолтой.

Дээрх хоёр чиглэлийн төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагааг төлөвлөсөн хугацаанд эхлүүлэх, нүүрс ачилт, тээвэрлэлтийн тасралтгүй ажиллагааг хангахын тулд төмөр замын бүтээн байгуулалт, тээвэр зохион байгуулалтын ажилтай уялдуулан нүүрс ачих байгууламжийг 2022 оны эхний хагаст багтаан ашиглалтад оруулах шаардлагатай байна.

“ТАВАНТОЛГОЙ ТӨМӨР ЗАМ” ХХК нь ДЭЭРХ 2 ЧИГЛЭЛИЙН ТӨМӨР ЗАМААР ТЭЭВЭРЛЭХ НҮҮРСИЙГ ТАВАНТОЛГОЙ ӨРТӨӨНИЙ АЧИЛТЫН ТОЙРОГТ АЧИХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ГҮЙЦЭТГЭХ ДАРААХ ҮНДЭСЛЭЛҮҮД БАЙНА.

Үүнд:

- ✓ Ачилтын үйл ажиллагаа нь тээвэр зохион байгуулалтын үйл ажиллагаатай нягт уялдаа

холбоотой, нэгдмэл цогц системийн нэг хэсэг юм.

- ✓ Ачилтын үйл ажиллагаа нь тээвэрлэлтийн нэг хэсэг буюу терминалын үйлчилгээний салшгүй бүрдэл болно.
- ✓ Ачих байгууламжийн төлөвлөлт, тооцоо судалгаа болон бүтээн байгуулалтын ажлыг төмөр замын мэргэжлийн байгууллага хийж гүйцэтгэснээр нүүрс ачилтын технологийн горим, вагоны бүрэн бүтэн байдал, хөдөлгөөний аюулгүй байдал хангагдана.
- ✓ Төмөр замын тээвэр болон ачилтын бункерийн мэдээллийн системийн уялдаа холбоо сайжирснаар тээвэрлэлтийн хугацаа багасаж, зардал буурна.
- ✓ Гаалийн хяналт шалгалт сайжирч, ачаа барааны манифест, ачаа тээврийн бичиг баримт бүрдүүлэх хугацаа багасаж, ачаа болон вагон эргэлт хурдасна.
- ✓ Ачих байгууламжийн бүтээн байгуулалтын ажлыг одоо хэрэгжиж байгаа “Зураг төсөл, худалдан авалт, барилгын ажил гүйцэтгэх ерөнхий гэрээ” /ЕРС/-ний хүрээнд гүйцэтгүүлэх нь төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагааг цаг алдалгүй төлөвлөсөн хугацаанд эхлүүлэх суурь нөхцөл болно. Тус ажлыг ТБОНӨХБАҮХАТ хуулийн хүрээнд хэрэгжүүлбэл ТЭЗҮ, зураг төсөв, боловсруулах компаниудыг сонгон шалгаруулж, ажил гүйцэтгүүлэх, барьж, байгуулах компанийг сонгон шалгаруулах, гэрээ байгуулах гэх мэт зөвхөн бэлтгэл ажлуудад дунджаар 8-12 сарын хугацаа зарцуулна.

НҮҮРС АЧИЛТЫН БАЙГУУЛАМЖИЙН БАЙРШЛЫН ЗУРАГ



“Эрдэнэс Тавантолгой” ХК нь дэлхийн жишиг стандарт, шаардлагыг хангасан 30 сая.тн нүүрс хадгалах задгай агуулах /талбай/ байгуулах ба уг талбайд авто болон галт тэрэгт ачих байгууламж, суллах, жинлэх төхөөрөмж байхаас гадна бутлуур, шигшүүрийн систем, нүүрс тээвэрлэх конвейер, бункерийн систем, нүүрс хадгалах талбай дээр овоолго үүсгэгч, бульдозер ажиллана. Мөн талбайн галын аюулгүйн байдлыг хангасан аюулгүйн

систем, тоосонцрын эсрэг иж бүрэн систем, салхи халхлах хана, зам талбай цэвэрлэх усан буу зэрэг тоног төхөөрөмж байх юм.

Ачилтын байгууламж ашиглалтад орсноор ТТ-ГС болон ТТ-ЗБ чиглэлийн төмөр замаар тээвэр хийх галт тэрэгний цуваанд орчин үеийн, тасралтгүй технологиор, их хэмжээний нүүрсийг богино хугацаанд ачих боломж бүрдэнэ.



9.6. АВТО ЗАМЫН ТӨСЛҮҮД

Компани өнөөгийн байдлаар жилийн 18 сая. тн ачаа тээвэрлэх хүчин чадалтай Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн 239 км хатуу хучилттай авто замаар бүтээгдэхүүнээ хил хүртэл тээвэрлэж байна. Авто тээврийн хүчин чадлыг нэмэгдүүлэх зорилгоор Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн 250 км параллель авто зам, Тавантолгой-Ханги-Мандал чиглэлийн 350 км авто зам болон Тавантолгой-Баруун наран чиглэлийн 32 км замын төгсгөлөөс Цагаандэл уул боомт хүртэлх 270 км авто замын төслүүдийг Үндэсний хөгжлийн газар хариуцан ажиллаж байгаа ба концессоор хэрэгжүүлэх ажлууд хийгдэж байна.

Дээрх концессын гэрээгээр хэрэгжиж буй авто замын төслүүдийг гэрээний хугацаанд багтаан ашиглалтад оруулах нь тээврийн эрчим болон борлуулалтын орлогыг

нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой.

“Эрдэнэс Тавантолгой” ХК нь эдгээр төслүүдийг бодлогоор дэмжиж ажилласнаар бүтээгдэхүүнээ зорилтот зах зээлд олон сувгаар нийлүүлэх боломж бүрдэнэ.

Цаашид зорилтот зах зээлд нийлүүлэх бүтээгдэхүүний төрлөө нэмэгдүүлэх, экспортыг эрчимжүүлэх нөгөө талаас БНХАУ-ын нүүрсний зах зээлийн дунд хугацааны өсөлт, дотоодын нүүрсний үйлдвэрлэлээ танах төрийн бодлого, импортын нүүрсний эрэлт зэрэг нь Тавантолгой ордын тээвэр логистик, дэд бүтцийн бүтээн байгуулалтад эерэг хүлээлтийг бий болгож байна.

Авто замын төслүүд хэрэгжсэнээр өсөн нэмэгдэж буй борлуулалт, экспортын хэмжээтэй уялдаж ажлын байрыг нэмэгдүүлэх, тээвэрлэлтийн үр ашгийг дотооддоо үлдээх эдийн засгийн эерэг үр дүнг бий болгоно.

Авто замын төслүүдийн ерөнхий мэдээлэл

№	Төслийн нэр	Авто замын барилгын ажил эхлэх хугацаа	Авто замын барилгын ажил дуусах хугацаа	Концесс эзэмшигчийн авто зам ашиглалтын хугацаа	Трассын урт
1	Тавантолгой-Гашуунсухайт	2019.10.22	2022.4.22	Авто зам ашиглалтад орсноос хойш 12 жил	240 км
2	Тавантолгой-Манлай-Ханги	2020.01.22	2022.07.22	Авто зам ашиглалтад орсноос хойш 27 жил	463 км
3	Тавантолгой-Цагаандэл уул	2019.11.20	2021.11.20	Авто зам ашиглалтад орсноос хойш 20 жил	270 км

ТАВАНТОЛГОЙ-ГАШУУНСУХАЙТ ЧИГЛЭЛИЙН 250 КМ ХҮНД ДААЦЫН ХАТУУ ХУЧИЛТТАЙ АВТО ЗАМ

Тавантолгой – Гашуунсухайт чиглэлийн 250 км хүнд даацын хатуу хучилттай авто замын төслийг хэрэгжүүлэхээр Үндэсний хөгжлийн газар нь “Тал нутгийн хөгжлийн зам” ХХК-тай 2019 оны 3 дугаар сарын 19-ний өдөр “Тавантолгой – Гашуунсухайт чиглэлийн 250 км хүнд даацын хатуу

хучилттай авто замын төсөл”-ийг хэрэгжүүлэх зураг төсөл боловсруулах-барих-ашиглах-шилжүүлэх (DBOT) концессын гэрээг байгуулсан. Ашиглалтын хугацаа нь авто зам ашиглалтад орсноос хойш 12 жил байна.

ТАВАНТОЛГОЙ-МАНЛАЙ-ХАНГИ ЧИГЛЭЛИЙН 463 КМ АВТО ЗАМ

Тавантолгой-Манлай-Ханги чиглэлийн авто замын төслийг хэрэгжүүлэхээр Үндэсний хөгжлийн газар нь “Тахилт хайрхан транс” ХХК-тай 2019 оны 7 дугаар сарын 31-ний өдөр “Тавантолгой-Манлай-Ханги чиглэ-лийн авто

замын төсөл”-ийг хэрэгжүүлэх зураг төсөл боловсруулах-барих-ашиглах-шилжүүлэх (DBOT) кон-цессын гэрээг байгуулсан. Ашиглалтын хугацаа нь авто зам ашиглалтад орсноос хойш 27 жил байна.

ТАВАНТОЛГОЙ-БАРУУННАРАН ЧИГЛЭЛИЙН 32 КМ АВТО ЗАМЫН ТӨГСГӨЛӨӨС ЦАГААНДЭЛ УУЛ ЧИГЛЭЛИЙН 270 КМ АВТО ЗАМ

Өмнөговь аймгийн Ханхонгор сумын Тавантолгой-Барууннаран чиглэлийн 32 км авто замын төгсгөлөөс “Цагаандэл уул” хилийн боомт хүртэлх 270 км авто замын төслийг хэрэгжүүлэхээр Үндэсний хөгжлийн газар нь “Ундрах говь” ХХК-тай 2018 оны 12 дугаар сарын 04-ний өдөр Өмнөговь аймгийн Ханхонгор сумын Тавантолгой-

Барууннаран чиглэлийн 32 км авто замын төгсгөлөөс “Цагаандэл уул” хилийн боомт хүртэлх 270 км авто замын төслийг хэрэгжүүлэх зураг төсөл боловсруулах-барих-ашиглах-шилжүүлэх (DBOT) концессын гэрээг байгуулсан. Ашиглалтын хугацаа нь авто зам ашиглалтад орсноос хойш 20 жил байна.





ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН МАТЕРИАЛ

2021.04.23

Эх орныхоо
Тусын Тулг
ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ ЭТТ



**ЭРДЭНЭС-ТАВАНТОЛГОЙ
ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН
УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ**

2021 оны 08 сарын 09 өдөр

Дугаар 08

Улаанбаатар хот

**Хувьцаа эзэмшигчдийн ээлжит
хурлыг хуралдуулах тухай**

Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.4 дэх хэсэг, 60 дугаар зүйлийн 60.1, 60.2 дахь хэсэг, 64 дүгээр зүйлийн 64.4 дэх хэсэг, 71 дүгээр зүйлийн 71.3, 71.4 дэх хэсэг, 76 дугаар зүйлийн 76.1.2, 76.1.3 дахь заалт, Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 377 дугаар тогтоолоор батлагдаж, 2021 оны 45 дугаар тогтоолоор нэмэлт өөрчлөлт оруулсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-ын 2 дугаар зүйлийн 2.3, 3 дугаар зүйлийн 3.7, 4 дүгээр зүйлийн 4.1.2, 4.2.1 дэх заалт, “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2021 оны 4 дүгээр сарын 23-ны өдрийн 09:00 цагт Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1 дүгээр хороо, Жигжиджавын гудамж-8, Финанс төв хаягт байрлах “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн байрнаас цахим хэлбэрээр хуралдуулсугай.

2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дор дурдсан асуудлыг хэлэлцүүлсүгэй. Үүнд:

2.1. Компанийн 2020 оны санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай;

2.2. Компанийн 2020 оны үйл ажиллагааны тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай;

2.3. Ногдол ашиг хуваарилахгүй тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийн танилцуулга;

2.4. Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай;

2.5. Төсөл, хөтөлбөрүүдийг санхүүжүүлэх арга хэмжээний тухай.

3. Компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг төрийн эзэмшлийн хувьцааг эзэмших эрхийг хэрэгжүүлэгч Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны төлөөлөл даргалахаар шийдвэрлэсүгэй.

4. Хурлын зарыг энэхүү тогтоолын нэгдүгээр, хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэгийг хоёрдугаар, хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох баримт бичгийн жагсаалтыг гуравдугаар, хурлаас гарах шийдвэрийн төсөлд санал авах хуудасны загварыг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

5. Хурлын зарыг хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдэд болон зохих журмын дагуу 2021 оны 3 дугаар сарын 14-ний өдрийн дотор нийтэд мэдээлэхийг Гүйцэтгэх захирал Б.Ганхуягт үүрэг болгосугай.

6. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссыг доорх бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:

1000000063

Дарга: Х.Батсайхан (Захиргаа, удирдлагын газрын дарга)
 Гишүүн: Т.Золжаргал (Тайлан бүртгэлийн хэлтсийн дарга)
 С.Батсүрэн (ТУЗ-ийн Ажлын албаны ахлах хуульч)

7. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын дэгдэлтийн нөхцөл байдалтай уялдуулан Улсын онцгой комиссын шийдвэр, Санхүүгийн зохицуулах хорооны холбогдох журам, зөвлөмжид заасны дагуу "Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг мэдээллийн технологийн шийдэл ашиглан зайнаас цахим хэлбэрээр зохион байгуулж, холбогдох эрх бүхий байгууллагатай зөвшилцөн хэрэгжилтийг хангаж ажиллахыг Гүйцэтгэх захирал Б.Ганхуягт даалгасугай.

ДАРГА



Б.БАТ-ЭРДЭНЭ



“Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн
Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны
3 дугаар сарын 09-ний өдрийн тогтоол
тогтоолын нэгдүгээр хавсралт

“ЭРДЭНЭС-ТАВАНТОЛГОЙ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ЗАР

“Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2021 оны 4 дүгээр сарын 23-ны өдрийн 09:00 цагт Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1 дүгээр хороо, Жигжиджавын гудамж-8, Финанс төв хаягт байрлах “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн байрнаас цахим хэлбэрээр хуралдана.

Хурлаар хэлэлцэх асуудлууд:

1. Компанийн 2020 оны санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай;
2. Компанийн 2020 оны үйл ажиллагааны тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай;
3. Ногдол ашиг хуваарилахгүй тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийн танилцуулга;
4. Компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах тухай;
5. Төсөл, хөтөлбөрүүдийг санхүүжүүлэх арга хэмжээний тухай.

Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчийн бүртгэлийн өдөр нь 2021 оны 3 дугаар сарын 31-ний өдөр байна.

Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 181 дүгээр тогтоолд “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн хувьцааг үнэ төлбөргүйгээр эзэмшсэн иргэд, нэрлэсэн үнээр худалдаж авсан аж ахуйн нэгжүүдийн хувьцаа нь хоёрдахь зах зээлийн арилжаа эхлэх хүртэл саналын эрхгүй, тэдгээрийг аливаа хэлбэрээр захиран зарцуулахгүй байхаар заасан тул хувьцаа эзэмшигчдийн 2021 оны ээлжит хурлаар хэлэлцэх асуудлаар зөвхөн саналын эрхтэй хувьцаа эзэмшигчийн саналыг авахыг мэдэгдье.

Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын дэгдэлтийн нөхцөл байдалтай уялдуулан Улсын онцгой комиссын шийдвэр, Санхүүгийн зохицуулах хорооны холбогдох журам, зөвлөмжид заасны дагуу “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг цахим хэлбэрээр хуралдуулна.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудал болон түүнтэй холбоотой баримт бичгийг 2021 оны 4 дүгээр сарын 9-ний өдрөөс танилцаж, холбогдох мэдээллийг хурал зохион байгуулах комиссоос доорх хаягаар ажлын цагаар холбогдож авч болно.

Хаяг: Финанс төв, Жигжиджавын гудамж-8, 1-р хороо, Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар-15160, Монгол Улс

Цахим хаяг: www.ett.mn

Утас: 70118585, 7505-5555

Цахим шуудан: info@erdenestt.mn



“Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн
Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны
3 дугаар сарын 09-ний өдрийн 2 тоот
тогтоолын хоёрдугаар хавсралт

**“Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн
Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэг**

№	Хурлын дэг	Хугацаа
1	Хурлын ирц бүртгэх, танилцуулах; (Тооллогын комисс)	5 минут
2	Хурлын дарга хурлын үйл ажиллагааг нээж, хурлаар хэлэлцэх асуудал, хурлын дэгийг танилцуулах;	10 минут
3	Хэлэлцэх асуудлыг дарааллын дагуу танилцуулж хэлэлцүүлэх;	Асуудал тус бүрээр 10 хүртэл минут
4	Хуралд оролцогчдоос асуулт хариулт, санал дүгнэлт авах;	Хүн тус бүрээр 1 минут (+1) минут
5	Хурлаас гарах шийдвэр, тогтоолын төслийг танилцуулах;	5 минут
6	Хурлын ажиллагааг хаах.	5 минут

-----ooOoo-----



“Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн
Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны
3 дугаар сарын 09-ний өдрийн 22 тоот
тогтоолын гуравдугаар хавсралт

**“Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн
ээлжит хурлаар хэлэлцэх асуудалтай холбогдуулан хувьцаа
эзэмшигчдийн танилцаж болох баримт бичгийн жагсаалт**

1. Компанийн 2020 оны санхүүгийн тайлан;
2. Компанийн 2020 оны үйл ажиллагааны тайлан;
3. Компанийн 2020 оны санхүүгийн тайлангийн талаар гаргасан аудитын байгууллагын дүгнэлт;
4. Компанийн 2020 оны санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлт;
5. Компанийн 2020 оны үйл ажиллагааны тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлт;
6. Ногдол ашиг хуваарилахгүй тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэр;
7. Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах төслийн танилцуулга;
8. Төсөл, хөтөлбөрүүдийг санхүүжүүлэх арга хэмжээний тухай шийдвэрийн төслийн танилцуулга;
9. Холбогдох бусад материал.

-----ooOoo-----



“Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн
Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны
3 дугаар сарын 09-ний өдрийн 22 тоот
тогтоолын дөрөвдүгээр хавсралт

**“ЭРДЭНЭС-ТАВАНТОЛГОЙ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ХЭЛЭЛЦЭХ АСУУДЛААР ХУРЛААС ГАРАХ
ШИЙДВЭРИЙН ТӨСӨЛД САНАЛ АВАХ ХУУДАС**

1. Компанийн нэр: “Эрдэнэс-Тавантолгой” ХК
2. Хурал хуралдах газар, өдөр, цаг: 2021 оны 4 дүгээр сарын 23-ны өдрийн 09:00 цагт
Компанийн байрны хурлын танхимд (Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын
дэгдэлттэй холбогдуулан Улсын онцгой комиссийн шийдвэр, Санхүүгийн зохицуулах
хорооны журам, зөвлөмжийн дагуу ЦАХИМ хэлбэрээр хуралдана.)
3. Хувьцаа эзэмшигчийн нэр:
4. Эзэмшиж байгаа хувьцааны төрөл: Энгийн
5. Эзэмшиж байгаа хувьцааны тоо /хувь хэмжээ/ /.....
..... / тоогоор үсгээр
6. Санал хураах аргын нэр: Ердийн

№	Хэлэлцэх асуудлууд	Тухайн асуудлаар гарах шийдвэрийн төсөл	Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн	Татгалзсан бол таны өгөх санал
1.	Компанийн 2020 оны санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай;	Тогтоол гарна.				
2.	Компанийн 2020 оны үйл ажиллагааны тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай;	Тогтоол гарна.				
3.	Ногдол ашиг хуваарилахгүй тухай ТУЗ-ийн шийдвэрийн танилцуулга;	Танилцуулга хийнэ.				
4.	Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай;	Тогтоол гарна.				
5.	Төсөл, хөтөлбөрүүдийг санхүүжүүлэх арга хэмжээний тухай.	Тогтоол гарна.				

Хувьцаа эзэмшигчийн бөглөх хэсэг	
ХЭ хувь хүний бөглөх хэсэг	ХЭ хуулийн этгээдийн бөглөх хэсэг
ХЭ иргэний овог, нэр	ХЭ хуулийн этгээдийн нэр
Гарын үсэг	Улсын бүртгэлийн дугаар
Хэрэв иргэн та саналаа итгэмжлэгдсэн этгээдээр төлөөлүүлэх бол итгэмжлэгдсэн төлөөлөгчийн мэдээллийг дор бичин итгэмжлэлийн хамт саналын хуудсыг ирүүлнэ үү.	Хувьцаа эзэмшигч хуулийн этгээдийг төлөөлж хуралд оролцсон итгэмжлэгдсэн төлөөлөгчийн нэр:
Итгэмжлэгдсэн төлөөлөгчийн овог, нэр:	Албан тушаал:
Регистрийн дугаар:	Гарын үсэг:
Саналын хуудсыг хүлээлгэн өгсөн огноо, цаг:	
Саналын хуудсыг хүлээн авсан этгээдийн нэр, гарын үсэг:	

Тооллогын комиссын бөглөх хэсэг:	
Саналын хуудсыг хүчинтэй/хүчингүйд (доогуур зурах) тооцон тоолсон	
Тооллогын комиссын Дарга:	 /
Гишүүн:	 /
Гишүүн:	 /
Хүчингүйд тооцсон бол шалтгаан:	

Саналын хуудсыг бөглөх санамж:

1. Хувьцаа эзэмшигч нь саналын хуудсыг бөглөхдөө санал өгөх хэсэгт (+) эсхүл (☑) гэсэн тэмдэглэгээг хийнэ. Жишээ нь: Зөвшөөрсөн бол зөвшөөрсөн гэсэн нүдэнд (+) эсхүл (☑), түдгэлзсэн бол түдгэлзсэн гэсэн нүдэнд (+) эсхүл (☑), татгалзсан бол татгалзсан гэсэн нүдэнд (+) эсхүл (☑) тэмдэг тавина.
2. Хэрэв татгалзсан бол та тухайн асуудлаар гарах шийдвэрийн төсөлд өгөх өөрийн саналаа татгалзсан бол таны өгөх санал гэсэн багананд бичнэ үү
3. Засварласан, балласан, залруулгатай эсхүл давхар тэмдэглэгээний аль нэгийг хийсэн бол санал авах хуудас нь **хүчингүйд** тооцогдоно.
4. Хэрэв та **Саналын хуудаст** энэхүү санамжийн 1-т заасан тэмдэглэгээний аль нэгийг хийгээгүй бол Түдгэлзсэнд тооцно.
5. Хэрэв та **Саналын хуудсыг** буруу бөглөсөн бол Санал өгөгч нь Тооллогын комисс нэгтгэсэн дүнг гаргахаас өмнө **Саналын хуудсыг** дахин авч бөглөж болно.

-----ooOoo-----



**ЭРДЭНЭС-ТАВАНТОЛГОЙ
ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН
УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ**

2021 оны 04 сарын 12 өдөр

Дугаар 13.

Улаанбаатар хот

Компанийн 2020 оны үйл ажиллагааны болон
санхүүгийн тайланд дүгнэлт гаргах тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.11, “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.6.11 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн 2020 оны үйл ажиллагааны нийт орлогыг 1.5 их наяд төгрөг, нийт зардлыг 1.4 их наяд төгрөг, цэвэр ашгийг 149.0 тэрбум төгрөгөөр тус тус баталсугай.

2. Компанийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг “Хангалттай” гэж үзсүгэй.

3. “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн 2020 оны үйл ажиллагааны тайлангийн дүгнэлтийг 1 дүгээр хавсралтаар, санхүүгийн тайлангийн дүгнэлтийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

4. “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлөөс гаргасан дүгнэлтийг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцүүлж батлуулахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн Аудитын хороо (Ү.Амарбат), Гүйцэтгэх захирал Б.Ганхуягт тус тус даалгасугай.

ДАРГА



Б.БАТ-ЭРДЭНЭ



1000000078

“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн
Төлөөлөн удирдах зөвлөлийн
2021 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн
13 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт



“ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ” ХК-ИЙН 2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАНД ӨГСӨН ДҮГНЭЛТ

Стратегийн ач холбогдол бүхий Тавантолгойн нүүрсний ордыг ашиглах талаар Улсын Их Хурал, Засгийн газраас гаргасан тогтоол, Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр, Төлөөлөн удирдах зөвлөлөөс баталсан төлөвлөгөөг биелүүлэх чиглэлээр “Эрдэнэс Тавантолгой” хувьцаат компанийн удирдлага, хамт олон 2020 онд хичээл зүтгэл гарган ажилласныг тэмдэглэж байна.

“Эрдэнэс Тавантолгой” хувьцаат компанийн удирдлагын зүгээс менежментийн оновчтой бодлого баримтлан төлөвлөгөөт зорилтуудаа амжилттай хэрэгжүүлэхийн төлөө шаргуу ажиллаж, хамт олныхоо хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлэх, компанийн засаглал, бүтцийг сайжруулах, нүүрс олборлолт, борлуулалтын үйл ажиллагааг нэмэгдүүлэх, үйлдвэрлэлд орчин үеийн техник технологийг нэвтрүүлэх, үйлдвэрлэлийн болон бүтээгдэхүүний үр ашиг, үнэ цэнийг нэмэгдүүлэх, санхүү, эдийн засгийн чадавх, нөөцийг бий болгох, гадаад худалдаа, хамтын ажиллагааг өргөтгөх, нийгмийн хариуцлагаа дээшлүүлэх, Ковид-19 цар тахлын халдвараас урьдчилан сэргийлэх чиглэлээр олон талт арга хэмжээ авч ажиллажээ.

2020 онд Тавантолгойн ордын гадаргуугийн нэгдсэн төлөвлөгөө, Цанхийн баруун уурхайн шинэчилсэн техник-эдийн засгийн үндэслэл, Бортээгийн уурхайн техник эдийн засгийн үндэслэл тус тус батлуулж, компанийн хувь эзэмшлийн “Зүүнбаян төмөр зам” ХХК, “Тавантолгой дулааны цахилгаан станц” ХХК байгуулагдсанаар Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа - 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл зэрэг бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан “Тавантолгойн ордыг цогцоор нь хөгжүүлэх” зорилтыг биелүүлэх эхний алхмууд амжилттай хэрэгжиж, төмөр зам, авто зам, нүүрс баяжуулах үйлдвэр, цахилгаан станц, ус хангамж зэрэг томоохон төслүүдийг хэрэгжүүлэхэд 2018 оноос хойш нийтдээ 2.4 их наяд төгрөгийн хөрөнгө оруулалт хийжээ. Үүний үр дүнд эдгээр томоохон төслүүдийн ажил амжилттай урагшилж, хэрэгжиж эхлээд байна.

Түүнчлэн нийгмийн хариуцлагын хүрээнд Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах “Таван толгой түлш” ХХК-д нийтдээ 269.1 тэрбум төгрөгийн санхүүжилт олгож, техник технологийн хувьд шинэчлэл хийж Зүүн бүсийн үйлдвэрийг барьж байгуулжээ.

Тайлант хугацаанд Цанхийн уурхайгаас 13 сая тонн нүүрс олборлож, 15.5 сая тонн нүүрс борлуулж, 2020 оны олборлолтын төлөвлөгөөг 100 хувь, борлуулалтын төлөвлөгөөг 111 хувиар биелүүлж, нийт 1 их наяд 677.1 тэрбум төгрөгийн (“ЭТТ” ХК-1 их наяд 547.7 тэрбум төгрөг, “ЭТТ Майнинг” ХХК-129.9 тэрбум төгрөг) борлуулалтын орлоготой, 149.4 тэрбум төгрөгийн (“ЭТТ” ХК нь 149.0 тэрбум төгрөг, “ЭТТ Майнинг” ХХК нь 0.4 тэрбум төгрөг) цэвэр ашигтай ажиллаж улсын төсөвт 490.1 тэрбум төгрөгийн татвар (“ЭТТ” ХК-459.5 тэрбум төгрөг, “ЭТТ Майнинг” ХХК-30.6 тэрбум төгрөг), хураамжийг төвлөрүүлжээ.

Компанийн Төлөөлөн Удирдах зөвлөлийн 2020 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн 09 тоот тогтоолоор компанийн нэгж хувьцаанд 90 төгрөгийн ногдол ашиг олгохоор тооцон 2,512,768 хувьцаа эзэмшигч иргэдэд 179.8 тэрбум төгрөгийн ногдол ашиг олгохоор анх удаа шийдвэрлэж, 2.5 сая иргэнд ногдол ашиг тараасан анхны компани болж чадсан нь энэ оны онцлох амжилт болжээ.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан "Алсын хараа - 2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл зэрэг бодлогын баримт бичиг, геологи хайгуул, уулын ажил, бизнесийн орчны судалгаа, төсөл хөтөлбөрүүдийн ТЭЗҮ зэрэгт тулгуурлан компанийг хөгжүүлэх "А6-20" дунд хугацааны бизнес төлөвлөгөөг боловсруулан батлуулсан нь цаашид компанийн хөгжлийн бодлогыг тодорхойлоход чухал түлхэц үзүүлж байна.


Ковид-19 цар тахлын халдвараас урьчилан сэргийлэх, цар тахлаас үүдсэн эдийн засгийн хүндрэлийг алдагдал багатайгаар даван туулах тал дээр компанийн удирдлагуудын зүгээс шуурхай арга хэмжээ авч ажилласан бөгөөд "Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн үед хэрэгжүүлэх ажлын жишиг төлөвлөгөө"-г боловсруулан, баталж амжилттай хэрэгжүүлсэн байна.

Компанийн засаглалын нээлттэй ил тод байдлыг хангах, төр, аж ахуй нэгж, хувьцаа эзэмшчдийг мэдээллээр хангах зорилгоор "Шилэн компани" хөтөлбөрийг хэрэгжүүлж компанийн үйл ажиллагаатай холбоотой 9500 орчим хуудас материалыг веб сайтад байршуулж, "Нүүрс тээврийн цахим цонх"-ыг ажиллуулж нүүрс тээврийн компаниуд, жолооч нар, худалдан авагчдыг мэдээллээр хангах ажлыг зохион байгуулж байгаа нь компанийн ил тод байдлын зөв жишиг тогтоожээ.

2018-2020 оны ажлын үр дүн, үзүүлэлтүүдийг үндэслэн "Эрдэнэс Тавантолгой" хувьцаат компанийн 2020 оны үйл ажиллагааны үр дүн болон Гүйцэтгэх захиралтай байгуулсан "Контракт гэрээ"-ний биелэлтийг "бүрэн хангалттай" гэж дүгнэв.

Цаашид компанийн үйл ажиллагааг өргөжүүлэн, иргэдэд эзэмшүүлсэн 1072 хувьцааг эргэлтэд оруулж үнэ цэнтэй болгох, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд анхаарч, олон улсын нүүрсний зах зээлд өрсөлдөх чадварыг сайжруулахад чиглэсэн дэд бүтэц, бүтээн байгуулалтын төслүүдийг эрчимжүүлж, Монгол Улсын Засгийн газраас баталсан "Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10.0 (арван) их наядын цогц төлөвлөгөө"-г хэрэгжүүлэхэд компанийн оролцоог нэмэгдүүлж, "ЭТТ-Бонд"-оор хөрөнгө оруулалтыг төвлөрүүлж, томоохон төслүүдийг санхүүжүүлэх санхүүгийн нөөцийг бүрдүүлэн ажиллах нь зүйтэй байна.

-оОо-



“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн
 Төлөөлөн удирдах зөвлөлийн
 2021 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн
 13- дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

“ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ” ХК-ИЙН
 2020 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНД
 ӨГСӨН ДҮГНЭЛТ

Компанийн борлуулалтын орлого 2020 онд 1.5 их наяд төгрөг байсан бөгөөд өмнөх оноос 41.8 хувиар буюу 1,113.3 тэрбум төгрөгөөр, цэвэр ашгийн хэмжээ 85.6 хувиар буюу 886.6 тэрбум төгрөгөөр тус тус буурсан.

Тайлант хугацааны компанийн нийт зардлын 47.0 хувийг борлуулсан бүтээгдэхүүний өртөг, 6.7 хувийг орлогын татварын зардал, 22.7 хувийг борлуулалт маркетингийн зардал /үүний 87.9 хувь буюу 285.2 тэрбум төгрөгийг АМНАТ, гаалийн хураамжийн зардал эзэлж байна/, 1.3 хувийг ерөнхий ба удирдлагын зардал тус тус эзэлж байгаа бол 22.3 хувийг бусад зардал эзэлж байна.

Компанийн өр төлбөрийн үзүүлэлтийг авч үзвэл нийт өрийн 45.4 хувь буюу 925.7 тэрбум төгрөгийг урт хугацаат, 54.6 хувь буюу 1,115.1 тэрбум төгрөгийг богино хугацаат өр төлбөр тус тус эзэлж байна.

Тайлант хугацаанд компанийн нийт өр төлбөр 2,040.8 тэрбум төгрөг байсан нь өмнөх оноос 1,685.6 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байх бөгөөд голлох нөлөө үзүүлсэн нь Бусад урт хугацаат өр төлбөр 880.2 тэрбум төгрөгөөр, богино хугацаат зээл 330.0 тэрбум төгрөгөөр, урьдчилж орсон орлого 315.9 тэрбум төгрөгөөр, дансны өглөг 185.9 тэрбум төгрөгөөр өссөнтэй холбоотой юм.

Санхүүгийн харьцааны гол үзүүлэлтээс харахад тайлант хугацаанд компанийн төлбөрийн чадвар болон тогтвортой байдлыг харуулдаг гол харьцааны үзүүлэлтүүдийн хувьд авч үзэхэд төлбөр түргэн гүйцэтгэх чадварын хувьд 0.8-аас дээш байхаас 1.0 болсон нь өмнөх жилээс буурсан боловч хэвийн хэмжээнд байна.

Иймд дээр дурдсан санхүүгийн үзүүлэлтийн өсөлт, үр ашигтай байдал, түүнчлэн аудитын дүгнэлтээр тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн стандартыг баримталж, санхүүгийн зөрчилгүй ажилласныг баталгаажуулсан зэргийг үндэслэн Төлөөлөн удирдах зөвлөлийн зүгээс компанийн 2020 оны санхүүгийн үйл ажиллагааг “бүрэн хангалттай” гэж дүгнэлээ.

Цаашид компанийн үр ашгийг нэмэгдүүлж, хувьцаа эзэмшигч хөрөнгө оруулагчдын хөрөнгийн өгөөжийг нэмэгдүүлэх тал дээр анхааран, аудитын байгууллага болон Төлөөлөн удирдах зөвлөлөөс өгсөн чиглэлийн дагуу шаардлагатай арга хэмжээг авч ажиллахыг компанийн Гүйцэтгэх удирдлагад зөвлөмж болгов.

-----ooOoo-----



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас: 26-04-37, Факс: 51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ЭРДЭНЭС-ТАВАНТОЛГОЙ ХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Б.ГАНХУЯГ
ТАНАА

2021.03.15 № 07/310
танай -ны № -т

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх тусдаа санхүүгийн байдал, тусдаа орлогын дэлгэрэнгүй, тусдаа өмчийн өөрчлөлт, тусдаа мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх тусдаа санхүүгийн тайлан материаллаг алдаагүй, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгадагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 28 зорилтын хүрээнд 128 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 94 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд удирдлагын хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, холбогдох журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн 2020 оны тусдаа санхүүгийн тайланд хийсэн
санхүүгийн тайлангийн аудит

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		2019 оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	656,360,016,783.45	134,579,817,564.83
1.1.2	Дансны авлага	222,962,485,334.10	22,750,533,629.22
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	539,420,897.07	2,925,855,367.51
1.1.4	Бусад авлага	26,834,546,936.22	8,533,994,273.71
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө	15,323,473,972.58	-
1.1.6	Бараа материал	105,541,226,765.63	129,688,069,920.17
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	12,334,137,985.70	898,673,489,044.95
1.1.8	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө	392,534,246.50	392,534,246.50
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	1,040,287,842,921.25	1,197,544,294,046.90
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	37,416,536,446.07	46,918,974,558.66
1.2.2	Биет бус хөрөнгө	11,159,414,518,191.40	11,138,815,800,462.80
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт	312,187,509,157.49	309,341,309,157.49
1.2.5	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө	13,711,907,860.88	15,832,974,521.81
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө	23,302,067,511.01	41,780,018,808.34
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө	798,825,099,315.37	1,384,886,624,342.71
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	12,344,857,638,482.20	12,937,575,701,851.80
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	13,385,145,481,403.50	14,135,119,995,898.70
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	184,098,780,006.13	370,019,327,697.83
2.1.1.2	Цалингийн өглөг	8,862,983,853.85	8,139,618,248.68
2.1.1.3	Татварын өр	88,455,571,781.25	62,929,482,678.46
2.1.1.5	Богино хугацаат зээл	-	330,000,000,000.00
2.1.1.6	Хүүгийн өглөг	-	150,630,136.98
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	23,630,475,928.63	339,534,363,656.66
2.1.1.9	Нөөц/өр төлбөр/	6,803,147,064.20	426,555,781.00
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	-	3,948,674,481.00
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	311,850,958,634.06	1,115,148,652,680.62
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.2	Нөөц /өр төлбөр/	36,602,486,605.33	45,516,330,455.33
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр	6,773,392,535.29	-
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	-	880,188,699,600.00
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	43,375,879,140.62	925,705,030,055.33
2.2	Өр төлбөрийн нийт дүн	355,226,837,774.69	2,040,853,682,735.95
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч:- төрийн		
2.3.2	хувийн		
2.3.3	хувьцаат	11,196,000,000,000.00	11,196,000,000,000.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	1,833,918,643,628.80	898,266,313,162.75
2.3.11	Эздийн өмчийн дүн	13,029,918,643,628.80	12,094,266,313,162.75
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	13,385,145,481,403.50	14,135,119,995,898.70

Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн 2020 оны тусдаа санхүүгийн тайланд хийсэн
санхүүгийн тайлангийн аудит

2.2 Аудит хийсэн тусдаа орлогын дэлгэрэнгүй тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		2019 оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	2,660,970,560,945.28	1,547,691,719,286.00
2	Борлуулалтын өртөг	(695,657,580,691.40)	(672,708,908,139.94)
3	Нийт ашиг(алдагдал)	1,965,312,980,253.88	874,982,811,146.06
4	Түрээсийн орлого	106,145,454.43	157,969,393.97
5	Хүүгийн орлого	27,509,403,793.63	24,164,215,030.72
6	Ногдол ашгийн орлого	-	-
7	Эрхийн шимтгэлийн орлого	-	-
8	Бусад орлого	7,011,028,207.29	4,558,617,764.42
9	Борлуулалт, маркетингийн зардал	(351,069,037,477.24)	(324,315,459,019.11)
10	Ерөнхий ба удирдлагын зардал	(19,605,067,376.24)	(18,039,329,034.40)
11	Санхүүгийн зардал	-	(10,415,287,671.24)
12	Бусад зардал	(239,569,180,628.91)	(307,601,163,518.70)
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	16,341,295,876.79	1,545,561,030.44
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	(57,092,920.37)	(11,368,945.02)
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)		
17	Бусад ашиг (алдагдал)		
18	Татвар төлөхийн өмнөх ашиг(алдагдал)	1,405,980,475,183.26	245,026,566,177.14
19	Орлогын татварын зардал	(370,405,680,110.04)	(96,007,989,035.72)
20	Татварын дараах ашиг (алдагдал)	1,035,574,795,073.22	149,018,577,141.42
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	1,035,574,795,073.22	149,018,577,141.42
23	Бусад дэлгэрэнгүй орлого		
	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
	Бусад олз (гарз)		
24	Орлогын нийт дүн	1,035,574,795,073.22	149,018,577,141.42
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	86.30	12.42

Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн 2020 оны тусдаа санхүүгийн тайланд хийсэн
санхүүгийн тайлангийн аудит

2.3 Аудит хийсэн тусдаа өмчийн өөрчлөлтийн тайлан

			/төгрөгөөр/
Үзүүлэлт	Өмч	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2018 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	11,196,000,000,000.00	807,826,923,203.93	12,003,826,923,203.90
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга		(9,483,074,648.35)	(9,483,074,648.35)
Залруулсан үлдэгдэл	11,196,000,000,000.00	798,343,848,555.58	11,994,343,848,555.60
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)		1,035,574,795,073.22	1,035,574,795,073.22
Өмчид гарсан өөрчлөлт			-
Зарласан ногдол ашиг			-
2019 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	11,196,000,000,000.00	1,833,918,643,628.80	13,029,918,643,628.80
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга		(4,670,907,607.47)	(4,670,907,607.47)
Залруулсан үлдэгдэл	11,196,000,000,000.00	1,829,247,736,021.33	13,025,247,736,021.30
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)		149,018,577,141.42	149,018,577,141.42
Зарласан ногдол ашиг		(1,080,000,000,000.00)	(1,080,000,000,000.00)
2020 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	11,196,000,000,000.00	898,266,313,162.75	12,094,266,313,162.70

Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн 2020 оны тусдаа санхүүгийн тайланд хийсэн
 санхүүгийн тайлангийн аудит

2.4 Аудит хийсэн тусдаа мөнгөн гүйлгээний тайлан

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	/төгрөгөөр/	
		2019 оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	2,479,132,362,016.53	1,003,642,059,120.93
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	2,390,054,698,305.28	988,070,461,440.28
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	38,567,428.80	31,869,691.90
	Бусад мөнгөн орлого	89,039,096,282.45	15,539,727,988.75
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	1,690,340,468,047.62	1,002,174,567,014.51
	Ажиллагчдад төлсөн	41,787,153,211.09	47,613,170,664.71
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	11,122,300,000.00	12,405,000,000.00
	Бараа материал худалдан авахад төлсөн	822,185,520,652.46	441,955,132,095.75
	Ашиглалтын зардалд төлсөн	22,564,096.05	28,347,908.53
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	2,876,883,969.56	1,842,455,236.05
	Хүүгийн төлбөрт төлсөн		10,264,657,534.26
	Татварын байгууллагад төлсөн	696,821,669,271.50	471,501,128,183.36
	Даатгалын төлбөрт төлсөн	109,633,550.63	275,716,022.40
	Бусад мөнгөн зарлага	115,414,743,296.33	16,288,959,369.45
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	788,791,893,968.91	1,467,492,106.42
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	26,402,408,276.77	7,401,671,535.85
	Хүлээн авсан хүүгийн орлого	26,402,408,276.77	7,401,671,535.85
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	316,598,554,496.50	157,174,176,606.09
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	3,266,894,009.00	21,236,670,238.59
	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	1,606,160,487.50	2,930,906,367.50
	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	311,725,500,000.00	6,600,000.00
	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа		133,000,000,000.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(290,196,146,219.73)	(149,772,505,070.24)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	542,000,000,000.00
	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		542,000,000,000.00
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	468,768,360,000.00	923,555,170,360.00
	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	468,768,360,000.00	743,725,000,000.00
	Төлсөн ногдол ашиг		179,830,170,360.00
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(468,768,360,000.00)	(381,555,170,360.00)
4	Валютын ханшийн зөрүү	21,274,145,919.25	8,079,984,105.20
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	51,101,533,668.43	(521,780,199,218.62)
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	605,258,483,115.02	656,360,016,783.45
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	656,360,016,783.45	134,579,817,564.83



**ЭРДЭНЭС-ТАВАНТОЛГОЙ
ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН
УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ**

2021 оны 02 сарын 19 өдөр

Дугаар 05

Улаанбаатар хот

Ногдол ашиг хуваарилахгүй тухай

Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1, 46.6, 76 дугаар зүйлийн 76.1.12, “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн дүрмийн 8.6.4, 13.1, 13.3 дахь заалт, “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн 05 тоот тогтоолоор баталсан “Ногдол ашгийн журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.1, 4.3 дахь заалт, “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн төрийн эзэмшлийн хувьцааг эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамнаас ирүүлсэн 2021 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 21/04 тоот удирдамжийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Эрдэнэс-Тавантолгой” ХК нь 2021 онд төлөвлөсөн томоохон бүтээн байгуулалтын хөрөнгө оруулалтыг өөрийн болон бусад санхүүгийн эх үүсвэрээр санхүүжүүлэх шаардлагатай байгаа тул 2020 оны үйл ажиллагааны цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсүгэй.

2. Ногдол ашиг хуваарилахгүй гэж шийдвэрлэсэнтэй холбогдуулан энэ тухай үндэслэлээ Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд тайлагнасугай.

ДАРГА

[Signature]



Б.БАТ-ЭРДЭНЭ

1000000029



**ЭРДЭНЭС-ТАВАНТОЛГОЙ
ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН
УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ**

2021 оны 04 сарын 12 өдөр

Дугаар 15.

Улаанбаатар хот

**Журмуудад нэмэлт, өөрчлөлт
оруулах тухай**

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 78.1.13, 80 дугаар зүйлийн 80.4, “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.16 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн “Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам”-д дор дурдсан агуулгатай нэмэлт, өөрчлөлт оруулсугай.

5.1.6. Төлөөлөн удирдах зөвлөлийн хурал болон хороодын хурлыг мэдээллийн технологийн шийдэл ашиглан зайнаас зохион байгуулж, цахим хэлбэрээр хуралдуулж болно.

2. “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн “Хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулах журам”-д дор дурдсан агуулгатай нэмэлт, өөрчлөлт оруулсугай.

2.12. Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн 45 дугаар тогтоолоор “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-д оруулсан нэмэлт, өөрчлөлтийн дагуу Хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурлыг цахим хэлбэрээр зохион байгуулж болно.

3. Энэ тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүд, нарийн бичгийн дарга болон Гүйцэтгэх захиралд тус тус үүрэг болгосугай.

ДАРГА

ББс



Б.БАТ-ЭРДЭНЭ

1000000082



“ЭРДЭНЭС-ТАВАНТОЛГОЙ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ЗАР

“Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал **2021 оны дөрөвдүгээр сарын 23-ны 09.00 цагт** Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1 дүгээр хороо, Жигжиджавын гудамж-8, “Финанс” төв хаягт байрлах “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн байрнаас цахим хэлбэрээр хуралдана.

Хурлаар хэлэлцэх асуудлууд:

1. Компанийн 2020 оны санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай;
2. Компанийн 2020 оны үйл ажиллагааны тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай;
3. Ногдол ашиг хуваарилахгүй тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийн танилцуулга;
4. Компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах тухай;
5. Төсөл, хөтөлбөрүүдийг санхүүжүүлэх арга хэмжээний тухай.

Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчийн бүртгэлийн өдөр нь 2021 оны гуравдугаар сарын 31-нд байна.

Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 181 дүгээр тогтоолд “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн хувьцааг үнэ төлбөргүйгээр эзэмшсэн иргэд, нэрлэсэн үнээр худалдаж авсан аж ахуйн нэгжүүдийн хувьцаа нь хоёр дахь зах зээлийн арилжаа эхлэх хүртэл саналын эрхгүй, тэдгээрийг аливаа хэлбэрээр захиран зарцуулахгүй байхаар заасан тул хувьцаа эзэмшигчдийн 2021 оны ээлжит хурлаар хэлэлцэх асуудлаар зөвхөн саналын эрхтэй хувьцаа эзэмшигчийн саналыг авахыг мэдэгдье. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын дэгдэлтийн нөхцөл байдалтай уялдуулан Улсын онцгой комиссын шийдвэр, Санхүүгийн зохицуулах хорооны холбогдох журам, зөвлөмжид заасны дагуу “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг цахим хэлбэрээр хуралдуулна.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудал болон түүнтэй холбоотой баримт бичгийг **2021 оны дөрөвдүгээр сарын 9-ний** өдрөөс танилцаж, холбогдох мэдээллийг хурал зохион байгуулах комиссоос доорх хаягаар ажлын цагаар холбогдож авч болно.

Хаяг: “Финанс” төв, Жигжиджавын гудамж-8, I хороо, Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар-15160, Монгол Улс


Цахим хаяг: www.ett.mn

Утас: 7505-5555

Цахим шуудан: info@erdenestt.mn

ӨНӨӨДӨР СОНИН. 2021.03.15 ДАВАА №048Б 049 (7096, 7097)

ЭТТ-БОНД



Өсөн нэмэгдэх үнэ цэн

Эхний транч

600,000,000,000

/зургаан зуун тэрбум төгрөг/

40 САЯ ШИРХЭГ

төгрөг болон ам.долларын бонд

БОНДЫН НӨХЦӨЛ

	ТӨГРӨГИЙН БОНД	ДОЛЛАРЫН БОНД
Нэгж үнэ	100,000 төгрөг	100 ам.доллар
Жилийн хүү	10.0% хүртэл	6.8% хүртэл
Хүү төлөгдөх хугцаа	6 сар тутам	6 сар тутам
Бондын хугацаа	2 жил	2 жил
Нийт хэмжээ	₮ 120 тэрбум	\$ 168 сая

Эх орныхоо
Тусын Тулг
ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ ЭТТ